



ЗАХИАЛАГЧ:

**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**



ГҮЙЦЭТГЭГЧ:

**АВТО ЗАМЫН ЗУРАГ
ТӨСӨЛ, ЗӨВЛӨХ
“ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК**

**ХОВД-АЛТАЙ ЧИГЛЭЛИЙН АВТОЗАМААС ХОВД
АЙМГИЙН ЧАНДМАНЬ СУМ ХҮРТЭЛХ АВТОЗАМЫН
ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ**

ЭЦСИЙН ТАЙЛАН

2017он



ЗАХИАЛАГЧ:

**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**



ГҮЙЦЭТГЭГЧ:

**АВТО ЗАМЫН ЗУРАГ
ТӨСӨЛ, ЗӨВЛӨХ
“ГЕО-ЗУРАГЛАЛ” ХХК**

**ХОВД-АЛТАЙ ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС ХОВД
АЙМГИЙН ЧАНДМАНЬ СУМ ХҮРТЭЛХ АВТО ЗАМЫН
ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ**

Доктор (PhD), Зөвлөх инженер  Р.Болормаа

Дэд захирал

 Н.Нямсүрэн



2017 он

ГАРЧИГ

| | |
|--|----|
| Танилцуулга | |
| Оршил | 5 |
| ТЭЗҮ боловсруулах үндэслэл, зорилго, үр дүн | 5 |
| I. ИНЖЕНЕРИЙН ХАЙГУУЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН | |
| 1 Автозамын хайгуул судалгаа | 7 |
| 1.1 Автозамын маршрут | 7 |
| 1.2 Автозамын трассын хувилбар | 8 |
| 1.3 Хувилбаруудын байр зүйн судалгаа, харьцуулалт | 9 |
| 2. Уур амьсгалын нөхцөл байдлын судалгаа | 12 |
| 2.1 Автозамын дагуух бүс нутгийн уур амьсгал | 12 |
| 2.2 Автозамын уур амьсгал, геотехникийн бүсчлэлийн онцлог | 17 |
| 3 Инженер-геологийн судалгаа | 20 |
| 3.1 Газрын гадаргын тогтоц ба физик-геологийн нөхцөл | 20 |
| 3.2 Ул хөрсний тогтоц ба инженер-герологийн ангилал | 24 |
| 3.3 Барилгын материалын судалгаа | 26 |
| 4 Замын урьдчилсан төлөвлөлт | 28 |
| 4.1 Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний судалгаа | 28 |
| 4.2 Төлөвлөлтийн стандарт ба шалгуур нөхцөл | 29 |
| 4.3 Автозамын трассын төлөвлөлт | 32 |
| 4.4 Автозамын дагуу огтлол | 35 |
| 4.5 Автозамын хөндлөн төлөвлөлт | 36 |
| 4.6 Ус зайлуулах хоолойн төлөвлөлт | 37 |
| 4.7 Жижиг гүүр төлөвлөлт | 44 |
| 4.8 ПК30+200 –ПК31+000 хэсгийн төсөлөлтийн шийдлүүд | 45 |
| 4.9 Хучилтын хийцийн хувилбарууд | 56 |
| 4.10 Хувирбаруудын ажлын тоо хэмжээ | 61 |
| 4.11 Хувирбаруудын урьдчилсан төсөв | 67 |
| 4.12 Хувилбаруудын харьцуулалт | 69 |
| 5 Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, зөвлөмж | 70 |
| 5.1 Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө | 70 |
| 5.2 Барилгын ажил гүйцэтгэх төлөвлөгөө | 71 |
| 5.3 Замын барилгын ажилд шаардлагатай хүн хүч машин механизм | 72 |
| 5.4 Замын арчлалт, засварын ажлын төлөвлөгөө | 74 |
| II. ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН | |
| 6 Орон нутгийн хөгжлийн өнөөгийн байдал, хэтийн төлөв | 78 |
| 6.1 Ховд аймгийн хөгжлийн өнөөгийн байдал | 78 |
| 6.2 Чандмань сумын хөгжлийн өнөөгийн байдал | 81 |
| 7 Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний судалгаа, хэтийн эрчмийн тооцоо | 84 |
| 7.1 Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний судалгаа | 84 |
| 7.2 Хөдөлгөөний хэтийн эрчмийн шинжилгээ | 84 |
| 8 Эдийн засгийн үр ашгийн шинжилгээ | 88 |
| 8.1 Тээвэр ашиглалтын зардал | 88 |

| | | |
|------|---|-----|
| 8.2 | Зам хэрэглэгчийн зардлын хэмнэлт | 92 |
| 8.3 | Байгаль орчинд нөлөөлөх хохирил ба нийгмийн салбарт гарах зардлын бууралт | 92 |
| 8.4 | Төслийн хөрөнгө оруулалтын үр өгөөж, өнөөгийн цэвэр үнэ | 94 |
| 8.5 | Мэдрэмжийн шинжилгээ | 95 |
| 9 | НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШГИЙН СУДАЛГАА | 96 |
| 9.1 | Төслөөс бүс нутагт нөлөөлөх байдал | 96 |
| 9.2 | Төслийн нийгмийн өгөөж, үр дагавар | 96 |
| 10 | ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ | 99 |
| 11 | БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГАА | 101 |
| 11.1 | Байгаль орчны төлөв байдлын судалгаа, үнэлгээ | 101 |
| 11.2 | Түүх соёлын дурсгалт зүйлсийн судалгаа, хамгаалах арга зам | 110 |
| 11.3 | Төслийн замаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл | 114 |
| | Ашигласан материал | 118 |
| | Хавсралт 1. Орон нутгийн захиргаанаас авсан баримт, албан тоот | 119 |
| | Хавсралт 2. Трассын 1-р хувилбар | 122 |
| | Хавсралт 3. Трассын 2-р хувилбар | 122 |
| | Хавсралт 4. Уур амьсгалын мэдээлэл | 123 |
| | Хавсралт 5. Уур амьсгалын мэдээлэл | 123 |
| | Хавсралт 6. Тээврийн хөдөлгөөн ба тээврийн хэрэгслийн мэдээлэл | 126 |
| | Хавсралт 7.Зам барилгын ажлын урьдчилсан төсөв /2 хувилбар/ | 127 |
| X7.1 | I хувилбарын давхар гадаргуун боловсруулалттан хучилтын хийцтэй авто замын төсөв | 127 |
| X7.2 | I хувилбарын битумээр боловсруулсан дайрган хучилтын хийцтэй авто замын төсөв | 139 |
| X7.3 | II хувилбарын давхар гадаргуун боловсруулалттан хучилтын хийцтэй авто замын төсөв | 151 |
| X7.4 | II хувилбарын битумээр боловсруулсан дайрган хучилтын хийцтэй авто замын төсөв | 164 |
| X7.5 | 15 у/м төмөрбетон гүүрийн төсөв | 177 |
| X7.6 | 6 у/м 2ш төмөрбетон гүүрийн төсөв | 190 |
| X7.7 | 2x2 харьцаатай 3ш төмөрбетон хоолойн төсөв | 200 |
| X7.8 | Давуулах далан болон бэхэлгээтэй далангийн төсөв | 207 |
| | Хавсралт 8. Дагуу огтлол | 208 |

ТАНИЛЦУУЛГА

- **Оршил**

Ховд аймгийн хөгжлүүлэх бодлогын бичиг баримт, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд үндэслэн “Ховд - Чандмань чиглэлийн 62 км авто замын техник-эдийн засгийн үндэслэлийн судалгаа боловсруулах ажил”-ын гэрээг 2017 оны 8-р сарын 07-д Ховд аймгийн Засаг даргын албатай “Гео зураглал” ХХК байгуулсны дагуу ажлын даалгаврын хүрээнд уг төслийн ажлыг гүйцэтгэн эцсийн тайланг толилуулж байна.


- **ТЭЗҮ боловсруулах үндэслэл, зорилго, үр дүн**

Ховд аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр бүлгийн 1.4.2.5, Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3 дугаар бүлгийн 3.4.12 дахь заалтуудад Ховд аймгийн төвөөс Чандмань сум чиглэлд хатуу хучилттай авто зам барихаар тусгасан байна. Эдгээр бодлогын бичиг баримт, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгасны дагуу олон улсын болон улсын чанартай авто замуудад түшиглэн зарим сумдыг хатуу хучилттай замтай холбох замаар орон нутгийн иргэдэд хүргэж буй худалдаа үйлчилгээг чанартай, түргэн шуурхай хүртээх, орон нутагт үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын зах зээлд нийлүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Ховд-Чандмань чиглэлийн автозам нь ачаа тээвэр, зорчигч тээврийн хөдөлгөөнийг ирээдүйд Мянганы автозамын хэвтээ тэнхлэгийн Баруун чиглэл болох Завханмандал-Дөргөн-Мянгад-Өлгий чиглэлтэй холбох Баруун бүсийн автозамын сүлжээг өргөсгөх чухал ач холбогдолтой замын чиглэл болох юм.

Уг “Ховд –Чандмань чиглэлийн 62 км автозамын техник-эдийн засгийн үндэслэлийн судалгаа боловсруулах” төслийн хүрээнд Ховд аймгийн Манхан, Зэрэг, Чандмань сумдын газар нутаг хамрагдах бөгөөд эдгээр сумд болон зэргэлдээх сумдын ард иргэдийн зорчигч, ачаа тээврийн хөдөлгөөнд зориулсан авто замыг төлөвлөх үндэслэлийг боловсрууллаа.

Төсөлд
хамрагдах бүс



Зураг 1. Төслийн бүсийн байрлал



БҮЛЭГ I. ИНЖЕНЕРИЙН ХАЙГУУЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН



1. АВТОЗАМЫН ХАЙГУУЛ СУДАЛГАА


1.1. Автозамын маршрут

Ховд-Чандмань сум чиглэлийн авто зам нь Чандмань сумын иргэдийн мал аж ахуйн болон тариалангийн бүтээгдэхүүн, түүхий эдийг борлуулах, мөн сумын иргэдэд худалдаа үйлчилгээг ойртуулах зорилготой юм.

Энэ чиглэлийн авто замыг Ховд-Дарви чиглэлийн авто замын 95-р км дэх уулзвараас салж Чандмань сум чиглэлд явахаар трассын чигийг судалгаа хийлээ. Одоогоор ашиглаж буй хөрсөн замын урт нь 62.7 км байгаа бөгөөд голын хөндийгөөр дайрч, Тоорой элсийг тойрон Жаргалант хайрхан, Бумбат хайрханы хоорондох шилээр давж, Нарийний хоолойгоор хуурай сайрын голидролоор явж Чандмань сум ордог юм байна.

Авто замын чигийн хувилбарыг 1:100 000 масштабтай газрын зураг ашиглан дараах хувилбарыг тодорхойлов. Үүнд:

- Трассын нэгдүгээр хувилбар нь Ховд-Дарви чиглэлийн замын уулзвараас эхлэн Төгрөгийн голын хөндийгөөр өнгөрч, Нарийн шилээр даван, Бүдүүний толгодын баруун талаар гарч Өндөр Хар уулын зүүн талаар Чандмань сум хүрэх;
- Трассын хоёрдугаар хувилбар нь мөн адил Ховд-Дарви чиглэлийн замын уулзвараас эхлэн Төгрөгийн голын хөндийгөөр өнгөрч, Нарийн шилээр даван, 34,3км-ээс зүүн эргэж Бүдүүний толгодын урдуур гарч Чандмань сум хүрэх;



Зураг 2. Трассын хувилбарууд

1.2. Автозамын трассын хувилбар

Авто замын трассын хувилбаруудыг 1:100 000 масштабтай газрын зураг ашиглан тоймлон тогтоож, уг чигүүдийн дагуу талбайн үзлэг, хэмжилтийг төслийн газарт явж хийсэн бөгөөд урьдчилсан байдлаар гурван хувилбарт судалгаа хийж, цаашид хоёр хувилбарыг сонгон харьцуулсан судалгаа хийлээ.

Трассын хоёр хувилбарын эхлэл нь Ховд-Дарви чиглэлийн хатуу хучилттай авто замын 95 дахь км дээр байхаар тооцлоо.

Газар нутгийн бартаа, хөрсний геологи, гидрологийн онцлог болон орон нутгийн иргэдийн зам харилцааны хэрэгцээг тооцон трассын 2 хувилбараар замын чигийг судаллаа.

Трассын нэгдүгээр хувилбарын хувьд, эхлэлийн цэгээс баруун тийш гарч Өөшийн голын хөндийгөөр явж, Өөшийн голыг дайран, Тоорой элсний дээд хэсгээр гарч, Жаргалант хайрхан, Бумбат хайрханы хоорондох Нарийны шилээр давж, Бүдүүний толгодын баруун талаар гарч Өндөр Хар уулын урд талаар тойрон Чандмань сумын зүүн урдаас орно. Энэ хувилбар нь 55.05 км болж байна.



Зураг 3. Трассын 1-р хувилбар, L=55.05 км

Трассын хоёрдугаар хувилбарын хувьд, эхлэлийн цэгээс баруун тийш гарч Өөшийн голын хөндийгөөр явж, Өөшийн голыг дайран, Тоорой элсний дээд хэсгээр

гарч, Жаргалант хайрхан, Бумбат хайрханы хоорондох Нарийны шилээр давж, 34.3км-ээс зүүн эргэж Бүдүүний толгодын урдуур гарч Чандмань сумын зүүн урдаас орно.


Энэ хувилбар нь 57.3 км болж байна.



Зураг 4. Трассын 2-р хувилбар, L=57.3 км

1.3. Хувилбаруудын байр зүйн судалгаа, харьцуулалт

Трассын хоёр хувилбарын дагуу талбайн үзлэг хэмжилт хийж, нийт трассын уртыг нягтлан тогтоолоо. Трассын хувилбаруудын байр зүйг нэгтгэн тайлбарлалбал 1,2-р хувилбар 34.3 км-ээс хоёр тийш салж Бүдүүний толгод, Өндөр Хар уулын урд хойд талаар гарч Чандмань сумын наана нийлж байгаа болно.



Зураг 5. Замын трассын хоёр хувилбар

Трассын хувилбаруудыг дараах үзүүлэлтээр харьцуулж дүгнэв.

Трассын хувилбаруудын байр зүйн болон трассын үндсэн үзүүлэлтийн харьцуулалт:

Хүснэгт 1.

| № | Трассын үзүүлэлт | х/н | 1-р хувилбар | 2-р хувилбар |
|-----|--|-----|----------------|----------------|
| 1 | Трассын урт | км | 55,052 | 57,305 |
| 2 | Эргэлтийн тоо | ш | 21 | 22 |
| 3 | Эргэлтийн хамгийн бага радиус | м | 2000 | 2000 |
| 4 | Дагуу налуу хэмжээ | ‰ | 42,7 | 42,7 |
| 5 | Хамгийн их дагуу налуутай хэсгийн үргэлжлэх урт | м | 3300 | 3300 |
| 6 | Хоолойн тоо | ш | 58 | 60 |
| 7 | Гүүрийн тоо, урт | ш / | 3 (1; 2; 3) | 3 (1; 2; 3) |
| 8 | Гүүрийн урт | у/м | 48 (24; 18; 6) | 48 (24; 18; 6) |
| 9 | Геологи-гидрологийн хүндрэлтэй хэсгийн үргэлжлэх урт: | | | |
| 9.1 | Үүшийн голын хөндийгөөр явах хэсгийн урт | м | 2000 | |
| 9.2 | Тооройн элс | м | 5200 | |
| 9.3 | Нарийний хоолойн үерийн хуурай сайртай хэсгээр өнгөрөх | м | 2100 | |

| | | | | |
|--|-----|--|--|--|
| | урт | | | |
|--|-----|--|--|--|

Трассын хувилбарууд эхний 34 км хүртэл нэг трассаар явна. Трассын эхний 15 км хэсэгт тэгш тал газраар явах бөгөөд хэд хэдэн жижиг салаагаар урсдаг Үүшийн голоор дайрах ба Тооройн элсний дээд хэсгээр тойрч гарах юм. (3 км орчим Тооройн элсний дээд захаар гарах)


Үүнээс үргэлжлэн 15км – 34 км хоорондох трасс Жаргалант хайрхан, Бумбат хайрханы шилээр давж, 28км – 30.1км хэсэгт үерийн хуурай сайр бүхий хоолойгоор өнгөрч байгаа.

Замын 34-р км орчимд Бүдүүний толгодын урдуур 2-р хувилбар тойрон гарч цаашид харьцангуй бартаа багатай хэсгээр явж Чандмань сум орно.

Трассын хоёр хувилбар дараах онцлог хэсгүүдээр дайран гарч байгаа. Үүнд:

Хүснэгт 2.

| № | Байрлал | Онцлог хэсгийн тайлбар |
|---|---------------------|--|
| 1 | ПК4+300 | Үүшийн гол |
| 2 | ПК10 +500 -ПК15+500 | 5 км орчим Тооройн элсний дээд захаар гарах; |



Зураг 6. Замын трассын онцлог хэсэг



Тоорой элсээр гарч буй хэсэг



Жаргалант хайрхан, Бумбат хайрханы шил өөд өгсөх хэсэг

3. ПК28+500 – ПК30+100 Үерийн хуурай сайр бүхий хоолойгоор гарах;



2. УУР АМЬСГАЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

2.1. Автозамын дагуух бүс нутгийн уур амьсгал

Замын трасс нь Ховд аймгийн Манхан сумын төвөөс 5 орчим км зайд А0304 Ховд-Алтай чиглэлийн автозамын 95-р км-ээс зүүн чигт салж Үүшийн голын хөндий, Жаргалант хайрхан, Бумбат хайрханы хоорондох шилээр давж Чандмань сум хүрнэ.

Иймд уг зам Манхан сум, Чандмань сумын нутаг дэвсгэрээр явах юм.

Чандмань сумын нутаг дэвсгэрийн хувьд, өндөр уул толгод ихтэй, их нуурын хотгор, өргөн удам тал хээр нутагтай бөгөөд зүүн талаараа Дөргөн, Хар Ус нуураар, баруун талаараа Жарганлант, Бумбат хайрхан уулуудаар хүрээлэгдсэн. Сумын нийт нутаг дэвсгэрийн 60 орчим хувь нь байгалийн тусгай хамгаалалтын бүсэд хамрагддаг. Газар нутгийн байгаль уур амьсгалын бүсчлэлийн хувьд хангай, говь хосолсон нутаг.

Газар зүйн онцлогийн хувьд, далайн түвшнээс дээш 1132-3796м өргөгдсөн. Физик газарзүйн хувьд, Монгол орны баруун бүсэд хамрагдах Их нууруудын хотгорт байрлах бөгөөд газар хөдлөлийн эрчим 7 балл хүрнэ. Цаг уурын нөхцөл нь өвөлдөө хүйтэн, зундаа огцом халдаг онцлогтой. Сүүлийн 10 жилийн (2007-2016 он) цаг уурын станцын мэдээнээс дүнгэхэд 1 дүгээр сарын дундаж агаарын температур -20.8°C , 7 дугаар сарын дундаж агаарын температур $+19.3^{\circ}\text{C}$ байдаг.

Жилийн дундаж салхины хурд 2.2 -2.8м/с, жилийн хур тунадасны нийлбэр 148,3мм.

Гаднах агаарын сар, жилийн дундаж температур, °C

Хүснэгт 3.

| Станц | Сар | | | | | | | | | | | | Жил |
|----------|-------|-------|------|-----|------|------|------|------|------|-----|------|-------|-----|
| | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII | |
| Зэрэг | -23.3 | -17.9 | -5.0 | 6.8 | 14.7 | 20.2 | 21.7 | 19.8 | 13.9 | 4.6 | -7.9 | -18.6 | 2.4 |
| Манхан | -23.7 | -19.7 | -7.5 | 5.1 | 13.7 | 18.7 | 19.9 | 19.0 | 12.9 | 3.2 | -9.4 | -19.6 | 1.0 |
| Чандмань | -21.2 | -18.9 | -7.5 | 2.6 | 10.8 | 16.5 | 17.5 | 16.0 | 9.8 | 1.6 | -8.6 | -18.6 | 0.0 |
| Ховд хот | -24.2 | -19.4 | -7.0 | 4.1 | 11.9 | 17.5 | 19.0 | 17.0 | 10.7 | 1.6 | -9.9 | -20.1 | 0.1 |

Эх сурвалж: БНБД 23-01-09

Гадна агаарын үнэмлэхүй хамгийн их температур, °C

Хүснэгт 4.

| Станц | Үнэмлэхүй хамгийн их | Он сар өдөр | VII сарын үнэмлэхүй ихийн дундаж |
|----------|----------------------|-------------|----------------------------------|
| Зэрэг | 39.0 | 1984.VII.20 | 33.7 |
| Манхан | 37.0 | 2004.VII.15 | 32.5 |
| Чандмань | 34.0 | 2004.VII.15 | 32.5 |

Эх сурвалж: БНБД 23-01-09

Гадна агаарын үнэмлэхүй хамгийн бага температур, °C

Хүснэгт 5.

| Станц | Үнэмлэхүй хамгийн бага | Он сар өдөр | I сарын үнэмлэхүй бага дундаж |
|----------|------------------------|-------------|-------------------------------|
| Чандмань | -42.0 | 1984.II.5 | -33.2 |
| Зэрэг | -46.4 | 1984.II.2 | -37.6 |

Эх сурвалж: БНБД 23-01-09

Ховд аймгийн “Манхан”, “Чандмань”, “Зэрэг”, “Ховд хот” станцуудын үзүүлэлтээр өгч хүснэгтээр үзүүллээ.

Хүснэгт 6.

| Агаарын дундаж температур, °C | | | | | | | | | | | | |
|-------------------------------|-------|-------|------|-----|------|------|------|------|------|-----|-------|-------|
| он/сар | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII |
| 1. Манхан | | | | | | | | | | | | |
| 2007 | -22.5 | -13.0 | -4.1 | 7.3 | 15.1 | 20.1 | 23.1 | 19.3 | 13.5 | 1.9 | -7.4 | -19.7 |
| 2008 | -27.1 | -22.9 | -1.2 | 7.0 | 14.6 | 19.8 | 21.0 | 20.0 | 13.0 | 4.6 | -6.3 | -19.3 |
| 2009 | -24.9 | -14.1 | -2.6 | 9.3 | 14.2 | 18.0 | 20.4 | 17.9 | 11.5 | 4.9 | -13.3 | -22.1 |
| 2010 | -23.9 | -23.7 | -8.0 | 2.0 | 12.1 | 19.9 | 21.4 | 17.1 | 12.3 | 3.8 | -3.3 | -13.7 |
| 2011 | -30.7 | -21.3 | -9.1 | 8.2 | 12.2 | 19.3 | 20.3 | 19.9 | 10.9 | 4.7 | -7.6 | -20.2 |
| 2012 | -28.2 | -23.1 | -6.9 | 6.7 | 13.5 | 20.8 | 21.1 | 18.1 | 13.2 | 2.7 | -8.7 | -19.0 |
| 2013 | -20.7 | -18.0 | 2.9 | 7.6 | 13.1 | 17.9 | 20.3 | 19.2 | 11.8 | 4.0 | -7.9 | -19.9 |
| 2014 | -19.8 | -23.3 | -5.5 | 7.9 | 12.2 | 18.3 | 21.5 | 18.9 | 12.0 | 7.3 | -7.4 | -21.1 |
| 2015 | -16.2 | -13.9 | -3.1 | 7.9 | 13.9 | 17.3 | 22.4 | 19.9 | 11.2 | 4.1 | -6.2 | -15.5 |
| 2016 | -26.7 | -25.0 | -3.9 | 8.3 | 11.0 | 19.8 | 22.0 | 18.6 | 14.4 | 2.1 | -7.3 | -12.4 |
| 2. Ховд | | | | | | | | | | | | |
| 2007 | -22.0 | -12.8 | -4.6 | 6.9 | 14.5 | 19.5 | 22.5 | 18.9 | 12.9 | 1.1 | -8.0 | -19.7 |
| 2008 | -26.8 | -21.9 | -1.6 | 6.4 | 14.0 | 19.0 | 20.6 | 19.3 | 12.1 | 3.9 | -6.5 | -18.0 |
| 2009 | -24.2 | -14.9 | -3.2 | 8.6 | 13.6 | 17.2 | 19.9 | 17.6 | 11.0 | 4.4 | -13.9 | -22.8 |
| 2010 | -25.0 | -24.3 | -8.9 | 1.3 | 11.4 | 19.1 | 20.9 | 16.5 | 11.7 | 3.0 | -5.1 | -15.0 |
| 2011 | -30.9 | -19.9 | -9.1 | 7.7 | 11.4 | 18.8 | 19.5 | 19.3 | 10.2 | 3.8 | -8.1 | -20.7 |
| 2012 | -28.3 | -23.4 | -7.1 | 6.3 | 12.7 | 20.5 | 20.8 | 17.5 | 12.4 | 2.4 | -8.1 | -18.6 |
| 2013 | -20.2 | -16.2 | 2.2 | 7.0 | 12.2 | 17.2 | 20.0 | 18.6 | 11.2 | 3.3 | -9.6 | -19.8 |
| 2014 | -20.4 | -21.5 | -4.6 | 7.4 | 11.5 | 17.7 | 20.8 | 18.4 | 10.9 | 5.9 | -8.1 | -19.4 |
| 2015 | -15.9 | -13.6 | -4.3 | 7.2 | 13.1 | 17.3 | 22.1 | 19.8 | 10.5 | 3.6 | -7.6 | -14.7 |
| 2016 | -25.1 | -22.7 | -3.0 | 7.8 | 10.4 | 18.9 | 21.7 | 18.3 | 13.9 | 1.0 | -7.9 | -12.9 |
| 3. Чандмань | | | | | | | | | | | | |
| 2007 | -18.3 | -8.8 | -5.0 | 5.5 | 12.8 | 17.7 | 20.9 | 17.5 | 11.8 | 0.2 | -7.2 | -16.1 |
| 2008 | -23.5 | -19.0 | -1.9 | 5.1 | 12.3 | 17.8 | 18.8 | 18.1 | 11.2 | 3.9 | -5.2 | -16.2 |
| 2009 | -21.2 | -14.2 | -4.1 | 7.7 | 12.1 | 15.4 | 18.3 | 16.2 | 10.3 | 3.7 | -12.4 | -18.6 |
| 2010 | -20.8 | -20.8 | -9.1 | 0.2 | 9.9 | 17.7 | 19.4 | 15.3 | 10.7 | 3.0 | -4.0 | -13.6 |
| 2011 | -28.9 | -18.0 | -9.6 | 6.7 | 9.7 | 17.1 | 17.8 | 17.8 | 9.1 | 3.6 | -6.5 | -18.7 |
| 2012 | -25.5 | -21.9 | -7.2 | 4.5 | 11.0 | 18.4 | 19.0 | 16.1 | 11.5 | 1.6 | -8.8 | -17.5 |
| 2013 | -16.5 | -15.7 | 1.8 | 6.0 | 10.9 | 15.5 | 18.1 | 17.1 | 10.1 | 3.1 | -7.7 | -16.3 |
| 2014 | -16.4 | -20.4 | -4.7 | 6.4 | 10.0 | 16.0 | 19.2 | 17.1 | 10.5 | 5.5 | -6.8 | -17.1 |

Эх сурвалж: Ховд аймгийн Цаг уурын станцын мэдээ

Хүснэгт 7.

| | | | | | | | | | | | | |
|------|-------|-------|------|-----|------|------|------|------|------|-----|------|-------|
| 2015 | -13.4 | -12.5 | -4.8 | 6.1 | 11.7 | 15.6 | 20.8 | 18.8 | 9.3 | 3.4 | -6.8 | -11.8 |
| 2016 | -23.6 | -19.6 | -3.9 | 6.5 | 8.9 | 17.6 | 20.4 | 16.8 | 13.1 | 0.2 | -7.3 | -9.9 |

| Агаарын хамгийн бага температур, °C | | | | | | | | | | | | |
|-------------------------------------|-------|-------|-------|-------|-------|------|------|------|-------|-------|-------|-------|
| он/сар | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII |
| Манхан | | | | | | | | | | | | |
| 2001 | -32.0 | -32.1 | -24.0 | -15.7 | -1.5 | 0.9 | 7.3 | 7.4 | -2.0 | -12.8 | -23.9 | -35.6 |
| 2002 | -36.7 | -36.7 | -32.8 | -13.4 | -2.0 | 8.2 | 10.0 | 3.9 | -5.4 | -18.9 | -20.4 | -35.0 |
| 2003 | -34.0 | -35.9 | -23.9 | -17.3 | -3.2 | 7.5 | 8.9 | 4.4 | -4.7 | -15.5 | -21.5 | -30.4 |
| 2004 | -33.0 | -32.0 | -19.7 | -8.3 | -7.4 | 2.9 | 9.5 | 5.1 | -11.5 | -13.7 | -22.4 | -42.7 |
| 2005 | -43.9 | -44.5 | -33.1 | -10.9 | -10.1 | 1.0 | 10.0 | 5.6 | -4.2 | -9.5 | -27.0 | -35.2 |
| 2006 | -35.2 | -25.4 | -23.5 | -12.8 | -4.5 | -1.8 | 8.8 | 4.8 | -1.4 | -10.0 | -22.8 | -26.3 |
| 2007 | -33.1 | -25.8 | -23.2 | -15.5 | -0.8 | 1.8 | 12.1 | 6.3 | -3.2 | -13.8 | -20.0 | -30.7 |
| 2008 | -37.7 | -37.6 | -18.2 | -10.7 | -8.0 | 5.3 | 6.4 | 2.9 | -5.2 | -11.1 | -20.3 | -34.7 |
| 2009 | -36.7 | -27.2 | -22.5 | -6.3 | -2.3 | 3.1 | 9.1 | 3.9 | -4.9 | -10.4 | -27.0 | -31.8 |
| 2010 | -34.1 | -38.2 | -26.8 | -18.4 | -4.6 | 3.0 | 7.7 | 3.3 | -0.2 | -9.7 | -17.4 | -28.3 |
| 2011 | -40.6 | -31.4 | -30.0 | -7.8 | -4.8 | 7.9 | 6.0 | 4.1 | -3.1 | -10.0 | -18.1 | -29.7 |
| 2012 | -37.7 | -35.7 | -24.5 | -11.8 | -3.9 | 7.9 | 11.6 | 5.7 | -2.3 | -15.3 | -23.2 | -32.6 |
| 2013 | -33.8 | -33.7 | -15.6 | -9.8 | -3.3 | 4.6 | 10.1 | 5.8 | -6.2 | -11.0 | -21.1 | -30.9 |
| 2014 | -31.3 | -37.3 | -26.7 | -8.4 | -2.5 | 2.4 | 7.4 | 5.2 | -3.7 | -14.1 | -25.6 | -31.6 |
| 2015 | -29.9 | -29.0 | -22.4 | -11.1 | -2.3 | 1.3 | 7.0 | 6.1 | -4.2 | -13.8 | -20.1 | -29.9 |
| 2016 | -43.7 | -39.5 | -25.4 | -7.7 | -5.3 | 7.2 | 11.9 | 5.4 | -1.9 | -18 | -28.5 | -24.6 |
| Ховд | | | | | | | | | | | | |
| 2007 | -30.6 | -25.2 | -21.4 | -13.9 | -0.1 | 1.8 | 11.6 | 7.1 | -4.4 | -13.2 | -20.3 | -30.9 |
| 2008 | -37.5 | -37.2 | -17.0 | -9.9 | -6.5 | 5.0 | 7.6 | 2.8 | -5.1 | -9.6 | -19.8 | -33.9 |
| 2009 | -35.0 | -27.1 | -23.2 | -4.4 | -2.4 | 3.4 | 8.0 | 5.7 | -3.0 | -9.6 | -27.4 | -32.8 |
| 2010 | -36.9 | -41.0 | -28.2 | -20.6 | -2.1 | 4.4 | 7.5 | 3.7 | -0.8 | -9.9 | -24.7 | -30.0 |
| 2011 | -40.8 | -32.9 | -26.7 | -8.6 | -2.7 | 7.5 | 5.3 | 3.5 | -3.2 | -11.6 | -19.0 | -30.2 |
| 2012 | -37.8 | -35.6 | -24.5 | -9.3 | -2.8 | 9.1 | 10.7 | 4.6 | -2.3 | -15.1 | -23.7 | -30.9 |
| 2013 | -32.7 | -28.8 | -16.5 | -12.7 | -1.4 | 5.7 | 9.0 | 5.2 | -5.5 | -10.4 | -25.0 | -30.5 |
| 2014 | -31.3 | -34.7 | -22.0 | -7.6 | -1.4 | 2.3 | 6.6 | 5.8 | -4.1 | -14.1 | -26.1 | -29.7 |
| 2015 | -28.6 | -28.5 | -25.0 | -10.6 | -2.1 | 2.4 | 6.4 | 5.6 | -5.4 | -13.2 | -22.0 | -25.6 |
| 2016 | -39.7 | -36.6 | -21.2 | -6.4 | -4.3 | 8.5 | 11.3 | 4.5 | 0.1 | -21.6 | -27.1 | -23.9 |
| Чандмань | | | | | | | | | | | | |
| 2007 | -28.8 | -19.0 | -20.8 | -14.0 | 0.2 | -0.5 | 9.6 | 7.3 | -4.3 | -14.3 | -16.5 | -26.0 |
| 2008 | -32.5 | -31.6 | -12.7 | -12.2 | -7.1 | 3.4 | 7.9 | 2.6 | -4.9 | -10.1 | -16.1 | -29.2 |

| | | | | | | | | | | | | |
|------|-------|-------|-------|-------|------|-----|------|-----|------|-------|-------|-------|
| 2009 | -30.5 | -26.8 | -20.9 | -4.8 | -0.8 | 1.1 | 7.4 | 3.2 | -4.0 | -9.1 | -23.3 | -29.5 |
| 2010 | -30.6 | -33.5 | -27.4 | -20.8 | -4.2 | 3.8 | 6.2 | 2.4 | -0.8 | -9.7 | -20.3 | -26.6 |
| 2011 | -37.6 | -27.4 | -24.4 | -8.6 | -6.5 | 8.1 | 3.8 | 3.9 | -3.6 | -10.1 | -16.7 | -27.6 |
| 2012 | -33.5 | -32.5 | -22.7 | -10.9 | -4.1 | 8.4 | 10.3 | 2.9 | -2.7 | -11.3 | -20.2 | -29.9 |
| 2013 | -29.7 | -27.5 | -14.8 | -10.6 | -2.7 | 5.9 | 9.4 | 5.1 | -5.6 | -10.8 | -23.0 | -27.2 |
| 2014 | -28.1 | -32.0 | -20.5 | -10.1 | -2.9 | 2.0 | 8.6 | 5.1 | -2.9 | -10.4 | -22.9 | -25.7 |
| 2015 | -25.3 | -27.0 | -21.3 | -13.7 | -2.6 | 0.7 | 7.3 | 5.7 | -3.9 | -12.7 | -22.0 | -24.7 |
| 2016 | -37.8 | -34.6 | -23 | -6.5 | -6 | 6.6 | 11.8 | 3 | 0.8 | -18.8 | -25.1 | -20.2 |

Эх сурвалж: Ховд аймгийн Цаг уурын станцын мэдээ

Хүснэгт 8.

Барилга, байгууламж, техник технологийн тооцооны температур, °C

| Станц | Гадна агаарын тооцооны температур, oC | | | | |
|----------|---------------------------------------|---------|---------|------------------|-----------------------------------|
| | Хамгийн хүйтэн үеийн | | | | Хамгийн халуун үеийн нэг хоногийн |
| | 1 хоног | 3 хоног | 5 хоног | Агаар сэлгэлтийн | |
| Зэрэг | -35.8 | -34.9 | -34.0 | -28.3 | 27.8 |
| Манхан | -35.5 | -34.1 | -32.6 | -23.1 | 28.8 |
| Чандмань | -26.7 | -26.1 | -25.4 | -21.4 | 27.5 |
| Ховд хот | -39.8 | -39 | -38.4 | -33.7 | 25.6 |

Эх сурвалж: БНБД 23-01-09

Тухайн бүс нутагт ордог хур тунадасны хэмжээ хөрсний ууршиц /ууршуулах чадвар буюу ууршуулах хэрэгцээ ч гэж ярьдаг/-аас олон дахин бага, өөрөөр хэлбэл нийтдээ чийг дутмаг. Ууршцийн хэмжээ өндөр уулын бүслүүрт 500 мм-ээс бага, хээр говийн бүсэнд 800 мм байдаг.

Хур тунадасны 85% орчим нь жилийн дулаан улиралд /IV-IX сард/ үүнээс зөвхөн 7,8 дугаар сард 50-60% нь орно.

Хэдийгээр хур тунадас бага боловч түүний нэгж хугацаанд орох эрчим их. Дөчөөд оноос хойш хийсэн цаг уурын хэмжилтээр нэг хоногт орсон хамгийн их хур тунадас Манхан суманд 138 мм /1956 оны 8 дугаар сарын 5-нд/, 1 цаг хүрэхгүй шахам хугацаанд 40-65 мм хур буух тохиолдол хаана ч тохиолдож мэднэ.

Монгол оронд нутгийн хойд уулархаг хэсгээр Алтайн нурууны захын бэсрэг уулс, уулс хоорондын хөндий 15-25 хоног бороотой байх боловч жилийн хур тунадасны ихэнх нь цөөхөн хэдэн борооноос бүрэлддэг онцлогтой. Өөрөөр хэлбэл хур тунадасны нийт хэмжээ бага боловч хур тунадасны эрчим ихтэй, зарим тохиолдолд хоногт 50 мм-ээс их бороо ажиглагддаг боломжтой.

Чандмань сумын 2007-2017 оны хур тунадасны сарын үзүүлэлтийг дараах хүснэгтээс харна уу.

Сарын нийлбэр хур тунадас,мм

Хүснэгт 9.

Ховд аймгийн Чандмань сум

| Ажигла сан он | Сарууд | | | | | | | | | | | | sum |
|---------------|--------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|--------------|
| | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII | |
| 2007 | 18,3 | 8,8 | 5 | 5,5 | 12,8 | 17,7 | 20,9 | 17,5 | 11,8 | 0,2 | 7,2 | 16,1 | 141,8 |
| 2008 | 23,5 | 19 | 1,9 | 5,1 | 12,3 | 17,8 | 18,8 | 18,1 | 11,2 | 3,9 | 5,5 | 16,2 | 153,3 |
| 2009 | 21,2 | 14,2 | 4,1 | 7,7 | 12,1 | 15,4 | 18,3 | 16,2 | 10,3 | 3,7 | 12,4 | 18,6 | 154,2 |
| 2010 | 20,8 | 20,8 | 9,1 | 0,2 | 9,9 | 17,7 | 19,4 | 15,3 | 10,7 | 3 | 4 | 13,6 | 144,5 |
| 2011 | 28,9 | 18 | 9,6 | 6,7 | 9,7 | 17,1 | 17,8 | 17,8 | 9,1 | 3,6 | 6,5 | 18,7 | 163,5 |
| 2012 | 25,5 | 21,9 | 7,2 | 4,5 | 11 | 18,4 | 19 | 16,1 | 11,5 | 1,6 | 8,8 | 18,5 | 164 |
| 2013 | 16,5 | 15,7 | 1,8 | 6 | 10,9 | 15,5 | 18,1 | 17,1 | 10,1 | 3,1 | 7,7 | 16,3 | 138,8 |
| 2014 | 16,4 | 20,4 | 4,7 | 6,4 | 10 | 16 | 19,2 | 17,1 | 10,5 | 5,5 | 6,8 | 18,1 | 151,1 |
| 2015 | 13,4 | 12,5 | 4,8 | 6,1 | 11,7 | 15,6 | 20,8 | 18,8 | 9,3 | 3,4 | 6,8 | 11,8 | 135 |
| 2016 | 4,5 | 3,8 | 14,2 | 5,2 | 9,9 | 29,5 | 20,1 | 9,4 | 17,3 | 20,7 | 2 | 0,2 | 136,8 |
| Дундаж | 18,9 | 15,5 | 6,24 | 5,34 | 11,0 | 18,0 | 19,2 | 16,3 | 11,1 | 4,8 | 6,77 | 14,8 | 148,3 |

Эх сурвалж: Ховд аймгийн Цаг уурын станцын мэдээ

Хурдас (нойтон цас, цан, мөстлөг) субилмацийн үзэгдлийн давтагдал, ачааллын муж

Хүснэгт 10.

| Муж | Нойтон цастай | | Цантай | | Мөстлөгийн | | | |
|-----|---------------|----------------|------------|----------------|------------|----------------|----------------------|--------|
| | өдрийн тоо | үргэлжлэх, цаг | өдрийн тоо | үргэлжлэх, цаг | өдрийн тоо | үргэлжлэх, цаг | Зузаан, /ачаалал/ мм | |
| | | | | | | | 10 жилд | 5 жилд |
| II | 1-5 | 2-3 | 1-5 | 6-14 | 1-2 | 1-3 | 10 | 5 |

Эх сурвалж: Геологийн тайлан

Судалгааны район Монгол орны газрын гадарга дээрх цасны ачааллын III мужид хамаарах ба цасан бүрхүүлийн нормчилсон ачаалал 30 кг/м² байна. Судалгааны талбайд тархсан хөрсний улирлын гэсэлтийн норматив гүнийг БНБД 23-01-09-д дараах байдлаар өгсөн байна. “Манхан” станцаар:

| | |
|---|--------|
| - Шавар, шавранцар хөрсөнд | 2.50 м |
| - Элсэнцэр, жижиг ширхэгтэй элсэн хөрсөнд | 3.04 м |
| - Том ширхэгтэй элсэн хөрсөнд | 3.22 м |
| - Том хэмжээст хөрсөнд | 3.58 м |

“Чандмань” станцаар:

| | |
|---|--------|
| - Шавар, шавранцар хөрсөнд | 2.42 м |
| - Элсэнцэр, жижиг ширхэгтэй элсэн хөрсөнд | 2.94 м |
| - Том ширхэгтэй элсэн хөрсөнд | 3.11 м |
| - Том хэмжээст хөрсөнд | 3.46 м |

Хадан хөрс илэрсэн тохиолдолд хадан хөрсний дээд хилээр тооцно.

Трасс дайран өнгөрч буй газар нутгийн салхины дундаж хурдыг Чандмань, Манхан, Жаргалантын цаг уурын станцаар авлаа.

Хүснэгт 11.

| он | сар | Жаргалант | | | Манхан | | | Чандмань | | |
|------|-----|-----------|-------|--------|--------|-------|--------|----------|-------|--------|
| | | зүг | т/тоо | д/хурд | зүг | т/тоо | д/хурд | зүг | т/тоо | д/хурд |
| 2014 | I | X | 45 | 2,5 | Ө | 60 | 1,7 | 3Ө | 29 | 3,4 |
| | II | X | 25 | 2,3 | Ө | 56 | 1,8 | 33X | 25 | 2,4 |
| | XI | Ө | 33 | 1,5 | Ө | 35 | 2,2 | 33Ө | 37 | 5 |
| | XII | Ө | 55 | 1,6 | Ө | 59 | 1,9 | 33Ө | 27 | 2,9 |
| 2015 | I | Ө | 39 | 1,5 | Ө | 47 | 1,9 | 3 | 33 | 3,8 |
| | II | Ө | 36 | 2,6 | Ө | 37 | 1,8 | БХ | 29 | 3 |
| | XI | X | 25 | 2 | Ө | 44 | 1,8 | 33X | 26 | 3,5 |
| | XII | X | 43 | 2,5 | Ө | 56 | 1,9 | 33Ө | 31 | 2,7 |
| 2016 | I | Ө | 27 | 1,2 | Ө | 53 | 1,8 | 3Ө | 30 | 2,1 |
| | II | БХ | 34 | 1,7 | Ө | 56 | 1,9 | 3 | 24 | 2,6 |
| | XI | Ө | 27 | 1,5 | Ө | 31 | 2,2 | 3 | 32 | 4,9 |
| | XII | X | 29 | 2,1 | Ө | 26 | 1,7 | 3 | 25 | 4 |

Эх сурвалж: Ховд аймгийн Цаг уурын станцын мэдээ

Жил, сарын дундаж салхины хурд

| Станц | Сар, өвлийн улирал, жилийн дундаж хурд, м/с | | | | | | | | | | | | Өвөл | Жил |
|----------|---|-----|-----|-----|-----|-----|-----|------|-----|-----|-----|-----|------|-----|
| | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII | | |
| Зэрэг | 0.3 | 0.5 | 1.1 | 1.8 | 1.6 | 1.3 | 0.8 | 0.8 | 0.9 | 0.8 | 0.7 | 0.4 | 0.4 | 0.9 |
| Манхан | 0.7 | 1.1 | 1.8 | 2.3 | 2.1 | 1.9 | 1.6 | 1.4 | 1.6 | 1.7 | 1.4 | 0.7 | 0.8 | 1.5 |
| Чандмань | 0.6 | 0.9 | 1.8 | 2.8 | 2.2 | 2.0 | 1.5 | 1.5 | 1.9 | 1.4 | 1.1 | 1.0 | 0.8 | 1.6 |

Эх сурвалж: БНБД 23-01-09

Нарны гийгүүлэл: Энэ бүс нуагт үүлшил бага, цэлмэг өдрийн тоо их, жилдээ 230-260 хоног байх тул жилдээ 2600-3300 цаг нар гийгүүлнэ.

2.2. Автозамын уур амьсгал, геотехникийн бүсчлэлийн онцлог

Тус замын трасс нь Ховд аймгийн Манхан, Чандмань сумдын нутгаар тавигдаж байгаа бөгөөд энэ газар нутаг Монгол орны авто замын уур амьсгалын IV бүсэд хамрагдана [1]. Авто замын уур амьсгалын өндөр уулын бүсийн дэд бүс болох Алтайн бүс нь Монгол Алтайн өндөр уулын авто замын уур амьсгалын нэн хүйтэн – сэрүүн, хахир бүсэд тооцогддоно. Тогтвортой цасан бүрхүүл эрт тогтож, хожуу ханзахдаг, олон жилийн цэвдэг чулуулаг үргэлжилсэн хэлбэрээр тархдаг, нилээд тогтдогтой тооцогддог, хур бороо аянга аадар цахилгааны эрчимтэй.

Судалгааны районы Авто замын уур амьсгалын, геотехникийн бүсийн нөхцөл нь “Автозамын уур амьсгал ба геотехникийн нөхцөл” (АЗУАГН 2.01.01-2004)-ийн зааснаар дараах онцлогтой байна.

Бүсийн тодорхойлолт

| Бүсийн дугаар, нэр | Дэд бүсийн индекс | Бүсийн товч тодорхойлолт | Уур амьсгалын болон хөрсний нөхцөл |
|--|---|---|--|
| II. Авто замын уур амьсгалын хээрийн бүс | IIВ. Уулын завсар хоорондын тал хээрийн дэд бүс | -Авто замын уур амьсгалын хуурай-хүйтэн сэрүүвтэр хахир, хуурайдуу, сэрүүвтэр хүйтэн бэсрэг уулт хээр, хээр талын хахирлаг дэд бүс. | -Тал хээрийн дэд бүс нь улирлын хөлдөлттэй овойлт болон суулт үүсгэнэ. Цас нимгэн, хахир өвөлтэй. -Газар хөдлөл 6-7 балл. |

Хүснэгт 14.

Авто замын уур амьсгалын бүсүүдийн улирлын үргэлжлэх хугацаа

| Бүс | Дэд бүс | Өвөл | | | Хавар | | Зун | | Намар |
|-----|---------|--------------|---------------------|-----------------|---------------|-----------------|------------------|-----------------|-----------------|
| | | Эхлэх | Дуусах | Үргэлжлэх хоног | Дуусах | Үргэлжлэх хоног | Дуусах | Үргэлжлэх хоног | Үргэлжлэх хоног |
| II | IIВ | 1-9.X 5.X | 15-24.III 19.III | 126-143 134 | 6-12.V 9.V | 45-52 48 | 6-19.IX 13.IX | 112-156 129 | 44-54 49 |

Хүснэгт 15.

Хөрс агаарын температурын (°C) үзүүлэлт

| Бүс | Дэд бүс | Хөрсний гадаргын температур, °C | | | | Агаарын орчны дундаж температур, °C | | |
|-----|---------|---------------------------------|----------------|----------------|--------------------|-------------------------------------|----------------------|----------------------|
| | | Олон жилийн дундаж | Хамгийн халуун | Хамгийн хүйтэн | 0° нэвчих гүн, см* | Олон жилийн дундаж | Хамгийн хүйтэн сарын | Хамгийн дулаан сарын |
| II | IIВ | +0...+3 | 60-65 | -41...-45 | 250-350 | -2...+2 | -20...-25 | 15...20 |

Хүснэгт 16.

Хөрсний хөлдөлт-гэсэлтийн уур амьсгалын хугацаа

| Бүс | Дэд бүс | Хөлдөлт | | | Гэсэлт | | |
|-----|---------|-----------------|----------------------|----------------|------------------------|---------------------|-------------|
| | | Эхлэх | Дуусах | Хоног | Эхлэх | Дуусах | Хоног |
| II | IIВ | 20-30.X 25.X | 15.III-30.IV 5.IV | 120-195 160 | 15.III-10.IV 25.III | 15.IV-31.V 23.IV | 20-50 35 |


Хүснэгт 17.

Монгол орны автозамын бүсүүдийн хөрсний хөлдөлтийн норматив гүн

| Бүс | Дэд бүс | Хөрсний хөлдөлтийн норматив гүн, м | | | |
|-----|---------|------------------------------------|-------------------------|----------------------------------|-------------------|
| | | Шавар, шавранцар | Элсэнцэр, тоосорхог элс | Дунд зэргийн элс, хайргархаг элс | Том хэмхдэст хөрс |
| II | IIВ | 2.5 | 3.0 | 3.2 | 3.5 |

Сумын нутаг дэвсгэр нь өндөр уул, ухаа толгод ихтэй, Их нууруудын хотгор, өргөн уудам хээр тал, хосолсон нутагтай бөгөөд өвөлдөө хүйтэн, зундаа огцом халдаг онцлогтой. Чандмань сум нь Хангай, Говь хосолсон өвөрмөц онцлогтой нутаг юм. Сумын зүүн хэсэг нь Их нууруудын ай сав газраар хүрээлэгдсэн элсэрхэг гадаргуутай, тал, хөндий хосолсон бол баруун талаараа Далайн түвшинөөс дээш 3797.0 м өргөгдсөн Жаргалант уул түүний салбар уулсаар хүрээлэгдсэн бол Хойт талаараа Хар ус нуур, Хар нуур, Далайн нуураар хүрээлэгдсэн онцлог

байршилтай нутаг юм. Авто замын трассын эхлэл нь 1200.0-1400.0 м-ийн өндөртэй, Шар бөөрөг, Тооройн элсний хойд хэсгээр тал хөндийн хэв шинжит гадаргуугаас Жаргалант Бумбат уулын шилээр орон уул толгодын хоорондын хөндий, хажуу гадаргууд шилжинэ.



Зураг 7. Автозамын сүлжээ ба замын уур амьсгалын бүсчлэл

Судалгааны район нь гадаргуугийн усны хувьд нилээд баялаг юм. Тухайлбал: Сумын төвийн урд талын арваад булгаас эх авч урссан Жаргалантын урд гол, авто замын трассын эхний хэсэгт байрлах Өөшийн гол болон 3-р багийн орчимд байрлах 5.0 м гүнтэй, 3.6 л/сек-ийн ундрагатай худаг, 5.4 л/сек-ийн ундрагатай, Дуутийн булаг, 15 л/сек-ийн ундрагатай, Шар булгийн орчины худаг, 6.0 л/сек-ийн ундрагатай, Хөтөл усны булаг зэргүүдээс гадна алслагдсан уул, толгодын орчимоор 3.0 л/сек-ийн илүү ундрагатай, булаг, шандууд элбэгтэй юм. Дээрхи худгууд нь гүн багатай, цэнгэг устай, голлож малын ундаанд түгээмэл хэрэглэдэг байна. Дээрхи гол горхи, булагууд нь зун, намрын бороо, хуртай улиралд ус өгөмж сайжирч, ундарга нь ихсэх ба гол, горхиуд нь усжиж, урсгал үүсгэдэг байна. Тухайлбал: Авто замын трассын эхэнд байрлах Өөшийн гол хур, бороо багатай саруудад урсгал үүсгэдэггүй. Харин бороо, хуртай үед түр зуурын урсгал үүсгэж, урсдаг байна.

3. ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН СУДАЛГАА

3.1. Газрын гадаргын тогтоц ба физик-геологийн нөхцөл

Авто замын зурвас талбай нь Газарзүйн түгээмэл ангилалаар Алтайн уулархаг их мужийн Говь-Алтайн дэд мужид хамаарагдана. Уулын үнэмлэхүй өндөр нь арай бага зөвхөн цөөн хэдэн оргил 4000.0 м орчим өндөртэй юм. Харин уур амьсгал арай хуурайн харгаагаар сайр, гуу, жалга уулын хажуу бэлийг ихээхэн хучиж хуримтлагджээ. Нуурууд бие биеэсээ зайтай оршдог, харьцангуй өргөн орших түвшин нь нам буюу 1000.0-1500.0 м орчим байна.

Гол мөрний сүлжээ сийрэг, голууд богинохон, ус арай багатай тул хотгор руу гармагц ул хөрсөнд шингэж, голдуу замхарна. Харин уулын бэл хормойгоор булаг олон байна. Нуур цөөвтөр ихэвчлэн давсархаг буюу шорвог устай, хэмжээгээр бага гүехэн байдаг. Авто замын трассын дагууд геоморфологийн 2 төрлийн элементийг ангилан үзлээ. Үүнд:

1. Нам өндөрлөгтэй уул, түүний салбар ухаа, толгод хамаарагдах бөгөөд өндөр 1440.0-өөс 2014.0 м-ийн хооронд хэлбэлзэнэ. Өгөршлийн процессийн үйл ажиллагаагаар үүссэн Урд хүрэн толгой, Өндөр хүрэн дэнж, 2108.8 м өргөгдсөн нэргүй толгод хамаарагдана.

Дээрхи ухаа толгод нь эх чулуулгийн эндоген болон экзоген үзэгдлийн явцад өгөршлийн процесст хүчтэй орж, бутарч өнөөдрийн энэ биетийг үүсгэж тогтсон болно. Дээрхи уул толгодыг үүсгэж тогтсон цахиурлаг занар, элсэн чулуу, сернитин зэрэг тунамал болон Метоморф гаралтай, чулуулагуудыг авто замын суурь болон даланд хэрэглэж болохоос гадна хучилтын материалын шаардлагыг хангах боломжтой юм.

2. Тал болон ухаа толгодын хоорондийн хөндий: Тал болон ухаа толгодын хоорондийн хөндийн гадаргуу нь авто замын трассын эхлэлээс Чандмань сум хүртэл ойролцоогоор нэг км газрын гадаргуу нь өндөрсөж байна. Трассын эхлэлээс эхлэн Өгөөжийн голын хуурай сайрыг гатлах бөгөөд энэ гол нь хур, бороотой зун намрын саруудад усжиж, урсгал үүсгэхээс гадна орчиноо намагжуулах үйл ажиллагаа давхар явагддаг байна.

Хур, бороо багатай саруудад усны тэжээл эрс багасаж, улмаар урсгал нь ширгэдэг үйл явц давтагдан явагддаг байна. Тал хөндийн гадаргуугийн баруун талын уулнаас урсгал усны үйл ажиллагаагаар үүссэн гуу, жалга ихтэй бөгөөд эдгээр гуу жалга нь хөгжлийнхөө эрчимтэй үед явагдаж байгаагаас хажуу эргэ, гуугаа эвдэх үйл ажиллагаа хүчтэй явагдаж байна. Мөн авто замын зүүн талын уул, ухаа толгодоос ч гадаргуугийн усны угаагдал явагдаж, том, жижиг гуу, жалгыг үүсгэсэн байна. Авто замын трассад ойрхон байгаа 2 талын уулнаас бууж байгаа гадаргуугийн усны эрчим, хурд ихтэйг

онцгой анхаарч гадаргуугийн ус зайлуулах инженерийн цогц арга хэмжээ авах нь зүйтэй юм.

3. Судалгааны районд тархсан Протозой-Палеозой 1-2-ийн чулуулаг болон PR-PZ2-н үеийн чулуулагууд нь гүний температурт талсжин нөгөө талаар метоморфизмийн үзэгдэл хүчтэй явагдаж, ерөнхийдөө метоморф гаралтай болсон. Дээрхи үйл ажиллагаанд өртөгдсөн чулуулагууд нь өөрийн төрлөх шинж чанараа алдаж ерөнхийдөө талсжсан цахиурлаг шинж чанартай болсон бөгөөд уг чулуулагууд нь хатуулаг чанар дээшилэн, нягт цахиурлаг болсон учраас онцлог байдал нь багасаж, ерөнхийдөө шүүрэлтийн чанарын усыг өгдөг нь ус өгөмж багатай болсныг гэрчилнэ.

Судалгааны талбайд тогтсон дээрхи чулуулагууд нь авто замын баруун, зүүн талаар тогтсон уул, толгодын усны чанар, найрлага нь ерөнхийдөө ойролцоо байгаа, нэгэн структур ангилагдаж байгааг харгалзан нэгэн ан цавлаг уст давхарга ангилан үзсэн болно. Судалгааны талбайн гадаргуугийн өндөржилт нь 1148.13-2013.13 м хооронд хэлбэлзэх бөгөөд өндрийн зөрүү нь 865.0 м байна.

Геологи

Судалгааны район нь Региональ геологийнхоо ангилалаар Баруун Монголын атират структурт ангилагдах бөгөөд Их нуруудын хотгор, Алтайн өмнөх өргөгдлийн дунд болон нам өндөрлөгтэй, уулсын Дэд районд ангилагдана. Судалгааны талбай орчинд геологи, гарал үүслийн 4 төрлийн хурдас чулуулгийг ангилал авч үзлээ. Үүнд:

1. Гуравдагч-Дөрөвдөгч(Q3-4) настай, аллюви-пролювийн гаралтай хурдас
2. Гуравдагч-Дөрөвдөгч(Q3-4) настай, делюви-пролювийн гаралтай хурдас
3. Протозой-доод, дунд Палеозой (PR-PZ1-2)-настай, гүний гаралтай, гранитын бүлгийн габбро-диорит
4. Протозой-Палеозой (PR-PZ)-ийн настай, метоморф гаралтай, талсжсан элсэн чулуу

Эдгээр хурдас чулуулгийг тус бүрд нь тодорхойлон авч үзье:

1. Аллюви-пролювийн гаралтай хурдас: Авто замын трассын эхний хэсэгт Өөшийн гол, Төгрөгийн голын хөндийгөөр талбайн болоод гүний тархалт ихтэй хуримтлагдсан. Голлох хурдас нь элсэн болон элсэнцэр чигжээстэй сайр, сайрга, янз бүрийн ширхэгтэй элснээс тогтохоос гадна шавар, шавранцар, элсэнцэрийн мишил нарийн үеүд үндсэн цул давхаргад агуулагдана. Хэмхдэс материал болох сайр, сайрга нь

голлож тунамал, болон гүний чулуу, метоморф чулуулгийн хэмхдэсээс тогтох бөгөөд харьцангуй зөв хэлбэр дүрстэй. Сайнаас дунд зэрэг мөлгөржсөн байна.

2. Делюви-пролювийн гаралтай хурдас: Судалгааны зурвас талбайн уул, толгод, ухаа гүвээний бэл хажуу болон уул, толгод хоорондийн хөндийгөөр үргэлжилэн тархсан бөгөөд голлох чулуулаг нь элсэнцэр болон шавранцар чигжээстэй хайр, хайрга, мөн хайргархаг шавранцар, элсэнцэр, хайргархаг элсэн хөрс зонхилон тархсанаас гадна бул чулуу, үхэр чулуу 15-20 хувь хүртэл агуулагдсан байдаг.

Хайр, хайрга болох хэмхэдэс материал нь голлож тунамал болон метоморф, гүний чулуулгийн хэмхдэсээс тогтоно. Мөлгөржилт бараг байхгүй, хурц ирмэгтэй, зарим хэсэгтээ бага зэрэг мөлгөржсөн байна.

3. Гүний гаралтай, суурилаг найрлагатай Гранитын бүлэг чулуу: Алтайн өмнөх өргөгдлийн үед дунд, болон нам өндөрлөгтэй уулсыг үүсгэж тогтсон. Уулууд нь суурилаг найрлагатай, гранитын бүлэг чулуулагаас бүрэлдэж тогтсон.

Чулуулгийг гол бүрдүүлэгч нь Габбро, Габбро-диорит, плагиогранит, гнейс маягийн гранит, Гранит гнейс, грано-диорит гнейс бөгөөд зонхилох чулуулаг нь Габбро-диорит юм. Энэ бүлгийн чулуу авто замын трассын баруун талын Будын нурууг үүсгэж тогтсон бөгөөд он, цагийн явцад физик өгөршилд хүчтэй орж, хайр, хайрга, хайргархаг элс болтолоо өгөршсөн бүтээгдэхүүн нь уулын бэл хормойгоор хуримтлагдсан байна.

4. Метоморфийн процесст хүчтэй орсон элсэн чулуу, цахиуржсан занар, кварцит, гнейс, гранит гнейс чулуулгууд авто замын трассын зүүн урд талаар уул, толгод, ухаа гүвээг үүсгэж тогтсон бөгөөд голлох чулуу нь талсжсан элсэн чулуу юм. Эдгээр чулуулгууд нь авто замын суурь, даланд нэн тохиромжтойгоос гадна хучилтын материалд ч хэрэгтэй материал болно.

Гидрогеологи

Авто замын трассын дагууд хурдас, чулуулгийн шинж, гарал үүсэл, найрлага бүтэцийг харгалзан хоёр уст давхарга, ус тодорхой хэмжээгээр агуулсан чулуулаг гэж ангилан авч үзлээ.

Дээрхи уст давхарга, үеүдийг тус бүрд нь тодорхойлон авч үзье. Үүнд:

1. Гуравдагч-Дөрөвдөгч (Q3-4)-ийн настай, аллюви-пролювийн гаралтай, хурдасанд агуулагдаж байгаа уст давхарга, энэ уст давхарга нь Өөшийн гол, Төгрөгийн голын хөндийгөөр талбайн болоод гүний тархалт ихтэй хуримтлагдсан.

Ус агуулагч гол хурдас нь элсэн болон элсэнцэр чигжээстэй сайр, сайрган хөрс бөгөөд мөн элсэнцэр, шавранцар болон янз бүрийн ширхэгтэй элсэн хөрсний нарийн мишил үеүд агуулагдана. Дээрхи уст давхаргын дээр хөрсний ус 1.0-1.5 м-ийн гүнээс илэрч, 6.0 м хүртэл үргэлжилнэ.

Дээрхи хөрсний усыг орон нутагт бага гүнтэй худаг гаргаж, малын ундаанд өргөнөөр ашиглаж байна. Хөрсний усны гол тэжээл нь бороо, хурын ус бөгөөд Өөш болоод Төгрөгийн голтой гидрвалик холбоотой бөгөөд харилцан бие биеэ тэжээдэг байна.

2. Гуравдагч-Дөрөвдөгч (Q3-4)-ийн настай, делюви-пролюви (dp)-ийн гаралтай, хурдасанд агуулагдаж байгаа уст давхарга, энэ уст давхарга нь уул, толгодын хөндийгөөр хуримтлагдаж тогтсон.

Ус агуулагч зонхилох хурдас нь элсэнцэр болон элсэн чигжээстэй хайр, хайрга, мөн янз бүрийн ширхэгтэй элсний үеүд агуулагдана. Энэ уст давхаргын дээр хөрсний ус 2.5-4.6 м-ийн гүнээс илэрч, 7.0 м гүн үргэлжилнэ. Хөрсний усыг нутгийн ард иргэд, гүн багатай худаг малтаж, малынхаа ундааны хэрэгцээг хангана. Делюви-пролювийн уст давхарга 7.0-10.0 м-ийн гүнээс илэрч, 15.0-20.0 м гүн үргэлжилнэ. Үндсэн чулуунд хүрдэг байна.

Авто замын трассын зүүн, баруун талд ойрхон байгаа зарим нэгэн ундарга ихтэй булаг зуны цагт намаг үүсгэх, өвлийн цагт халиа, тошин үүсгэдэг гэдгийг баримттайгаар ярьж байгааг анхаарах нь зүйтэй юм.

Гүний худаг, булгийн талаар товч тодорхойлолт: Судалгааны авто замын трассын дагууд хөрсний ус болон гүний усны үйл ажиллагаагаар үүссэн олон булагтай. Тухайлбал:

- Өөшийн голын хөндийд байрлах 3-р багийн төвд 5.0 м гүнтэй 3.6 л/сек-ийн ундрагатай, Дуутын булаг 6.0 м гүнтэй. 5.4 л/сек ундрагатай, Шар булаг 1.5 л/сек ундрагатай, Хөтөл усны булаг 6.0 л/сек-ийн ундрагатай, Сумын урд талд байрлах 6 булаг дунджаар 1.5 л/сек-ийн ундрагатай бөгөөд дээрхи 6 булгийн ус нийлж Жаргалантын голын эх болдог байна. Сумын төвийн ард иргэд нь сумын төвд байрлалтай 3 худагаар усан хангамжийнхаа хэрэгцээг хангадаг байна. Тухайлбал:

- 2002 оны 1 дүгээр сард ашиглалтанд орсон гүний худаг 45.0 м гүнтэй, усны түвшин нь 14.0 м, ундарга нь 17 л/сек, мөн 2008 оны 12 дугаар сард ашиглалтанд орсон худгийн гүн 45.0 м, усны түвшин 16.0 м, ундарга нь 20 л/сек болно. 3 дахь худгийн албан бичиг баримт олдоогүй тул мэдээллийг олж чадаагүй болно. Дээрхи гүний худаг, булгийн гол тэжээл нь хур, борооны ус бөгөөд хур борооны уснаас

тэжээлийнхээ 70-аад хувийг, гүний уснаас 30-аад хувийг авдаг болно. Усний найрлага нь ердийн усны найрлагатай. Гидрокарбонат, Натри, калийн бүлгийн ус юм.

3.2. Ул хөрсний тогтоц ба инженер-геологийн ангилал

1. **Геологийн тогтоцийн хувьд**: Судалгааны район нь Региональ геологийнхоо ангилалаар Баруун Монголын атират структурт ангилагдах бөгөөд Их нуруудын хотгор, Алтайн өмнөх өргөгдлийн дунд болон нам өндөрлөгтэй, уулсын Дэд районд ангилагдана. Судалгааны талбай орчинд геологи, гарал үүслийн 4 төрлийн хурдас чулуулгийг ангилал авч үзлээ. Үүнд:

а. Гуравдагч-Дөрөвдөгч(Q₃₋₄) настай, аллюви-пролювийн гаралтай хурдас

б. Гуравдагч-Дөрөвдөгч(Q₃₋₄) настай, делюви-пролювийн гаралтай хурдас

в. Протозой-доод, дунд Палеозой (PR-PZ₁₋₂)-настай, гүний гаралтай, гранитын бүлгийн габбро-диорит

г. Протозой-Палеозой (PR-PZ)-ийн настай, метоморф гаралтай, талсжсан элсэн чулуу.

2. **Гидрогеологийн хувьд**: Авто замын трассын дагууд хурдас, чулуулгийн шинж, гарал үүсэл, найрлага бүтэцийг харгалзан хоёр уст давхарга, ус тодорхой хэмжээгээр агуулсан чулуулаг гэж ангилна.

Судалгааны талбай нь инженер-геологийн дунд зэргийн төвөгтэй нөхцөлтэй талбайд хамаарагдана. Учир нь хөрсний устай, хөрсний усны хэлбэлзэл ихтэй, овойлттой хөрстэй, хадан хөрстэй, намгархаг гадаргуутай зэрэгээс хамаарч байна.

Авто замын зурвас талбайд тархсан хөрсний овойлтын зэргийг үзүүлбэл:

- Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс - **Овойлтгүй**

- Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс - **Сулавтар хүчтэй**

- Элсэн чулуу, түүний хүчтэй өгөршлийн бүс - **Овойлтгүй**

хөрсөнд нормчлогдоно.

3. Авто замын зурвас талбайд тархсан буурь хөрсний механик шинж чанарын норматив үзүүлэлтийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 18.

| Хөрсний төрөл | Эзлэхүүн жин | Дотоод үрэлтийн өнцөг | | Зууралдлын хүч | | Хэв гажилтын Модуль |
|--|-------------------|-----------------------|-------------|----------------|----------|---------------------|
| | $\gamma_{эз}$ | ϕ^I | ϕ^{II} | C^I | C^{II} | E |
| | г/см ³ | градус | | кПа | | МПа |
| Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс | 2.25 | 36 | 40 | 1.33 | 2 | 45 |
| Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс | 2.11 | 38 | 44 | 11 | 17 | 42 |

Элсэн чулуу

- Өгөршөөгүй 2.38
- Өгөршсөн 2.59
- Өгөршлийн зэрэг 0.91

Хатуулаг:

- Өгөршөөгүй VI (Өрөмдлөг, тэсэлгээний аргаар малтана)
- Өгөршсөн V (Хийн цохилтод төхөөрөмжөөр сулруулж малтах)

4. Авто замын зурвас талбайд илэрсэн хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад:

- Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс - IV
- Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс - IV
- Элсэн чулуу, түүний хүчтэй өгөршил -V/VI

5. Авто замын зурвас талбайд илэрсэн хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл /Ом.м/:

- Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс - 650-730
- Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс - 280-350
- Элсэн чулуу, түүний хүчтэй өгөршлийн бүс - 200-800

6. Судалгааны районд газар хөдлөлтийн 9₂ баллын бүсэд хамаарна.

3.3. Барилгын материалын судалгаа

Төлөвлөж буй трассын 3 хувилбарын дагуу замын шороон далангийн материал болон зам барилгын чулуун материалын орд газрын судалгаа явууллаа.

Трассын дагуу элсэнцэр, элс чигжээстэй хайр, хайрган хөрс элбэг тархсан бөгөөд физик-механик шинж чанар, ширхэглэлийн бүрэлдэхүүний хувьд далангийн материалын шаардлагыг хангаж байна.

Ховд аймгийн Жаргалант хайрхан уул нь улсын тусгай хамгаалалтанд байдаг тул Бумбат хайрхан уулын салаа салбар уул толгод, Бүдүүний толгод зэрэг газраас чулуун материалын орд газрын хайгуул хийлээ.



Хайрган материалын орд газар



Чулуун материалын орд /Өндөр Хар уул/



Чулуун материалын орд /Нарийний хоолойн толгод/



Элсний орд /Тооройн элс/

Зураг 8. Орд газрууд

Трассын эхэн хэсэгт А0304 Ховд-Алтай чиглэлийн замын барилгын ажиллын үед нээсэн орд газар байна. Түүнийг ашиглах боломжтой гэж бас тооцлоо.

Хүснэгт 19.

Чулууны орд газрын байрлал

| № | Орд газар | Координат |
|---|-----------|-------------------------------|
| 1 | Карьер 1 | 5277206.71989 484480.14110 |
| 2 | Карьер 2 | 5271115.62936 484182.25015 |
| 3 | Карьер 3 | 5265673.92353 482842.33041 |
| 4 | Карьер 4 | 5250578.07605 470685.32869 |
| 5 | Карьер 5 | 5251831.09678 465264.20411 |
| 6 | Карьер 6 | 5268629.63621 483917.98126 |
| 7 | Карьер 7 | 5260530.88736 484038.28001 |
| 8 | Карьер 8 | 5257895.59618 482835.30828 |

4. АВТО ЗАМЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ

4.1. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний судалгаа

Төлөвлөж буй трассын дагуу хөдөлгөөний судалгааг 2017 оны 8-р сарын 20, 21-ний өдрүүдэд Чамдмань сумын ойролцоо, мөн Ховд – Дарви чиглэлийн замын уулзвар дээр явууллаа. Энэ өдрүүдийн ажиглалтын тооллогоор өдөрт дундажаар 31 тээврийн хэрэгсэл явж байлаа.

Хүснэгт. Төлөвлөж буй трассын дагуу хийсэн хөдөлгөөний тооллогын дүн

| ажиглалтын хийсэн өдөр | хэмжилт хийсэн огноо | Хөдөлгөөний эрчим ба хөдөлгөөний бүрэлдэхүүн | | | | Хоногийн дундаж хөдөлгөөний эрчим, маш/хоног |
|------------------------|----------------------|--|--------------------------|--------------------------|-----------|--|
| | | Хөнгөн тэрэг | Бага даацын ачааны машин | Дунд даацын ачааны машин | Мотоцикль | |
| 1 | 2017.08.20 | 15 | 6 | 1 | 7 | 30 |
| 2 | 2017.08.21 | 23 | 4 | | 8 | 33 |

Энэ тооллогын дүнг тухайн чиглэлийн хөдөлгөөний бүрэн гүйцэт өгөгдөлд тооцоход учир дутагдалтай юм. Мал аж ахуйн бүтээгдэхүүн мах, арьс шир, ноос борлуулалтын үеэр энэ хөдөлгөөн нэмэгдэх боломжтой юм. Иймд хөдөлгөөний эрчмийг тооцоолохын тулд дээрх үзлэг тооллогын дүн, Чандмань сум болон ойролцоох сум багийн тээврийн хэрэгслийн тоо бүртгэл, Чандмань сумын төлөвлөж буй трассын дагуух орон нутгийн хөгжлийн

хэтийн төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийлээ. Төслийн замын хөдөлгөөний эрчмийн судалгааг замын үйлчлэх хүрээнд хамрагдах сум баг, тээврийн хэрэгслийн тоо, мал аж ахуй, тариалангийн бүтээгдэхүүн, аялал жуулчлал, шилжин ирэх хөдөлгөөн гэсэн чиглэлээр хийлээ. Нийгэм-эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвлөгөө хөтөлбөрт үндэслэн хөдөлгөөний эрчмийн өсөлтийг 6-7.5%-иар тооцлоо.

| Он | Хөдөлгөөний эрчим ба хөдөлгөөний бүрэлдэхүүн | | | | Хөнгөн тэргэнд шилжүүлсэн хөдөлгөөний эрчим, маш/хоног |
|------------------------|--|--------------------------|--------------------------|-----------|--|
| | Суудлын машин | Бага даацын ачааны машин | Дунд даацын ачааны машин | Мотоцикль | |
| 2017 | 23 | 4 | 1 | 2 | 32 |
| 2018 | 25 | 4 | 1 | 2 | 34 |
| 2019 | 26 | 4 | 1 | 2 | 37 |
| 2020 | 57 | 7 | 2 | 5 | 74 |
| 2021 | 61 | 8 | 2 | 5 | 79 |
| 2022 | 66 | 8 | 2 | 6 | 85 |
| 2023 | 71 | 9 | 2 | 6 | 91 |
| 2024 | 76 | 9 | 2 | 7 | 97 |
| 2025 | 82 | 10 | 2 | 7 | 104 |
| 2026 | 88 | 10 | 3 | 8 | 112 |
| 2027 | 94 | 11 | 3 | 8 | 120 |
| 2028 | 101 | 11 | 3 | 9 | 128 |
| 2029 | 108 | 12 | 3 | 9 | 137 |
| 2030 | 116 | 13 | 3 | 10 | 146 |
| 2031 | 124 | 14 | 4 | 11 | 156 |
| 2032 | 131 | 14 | 4 | 11 | 166 |
| 2033 | 139 | 15 | 4 | 12 | 176 |
| 2034 | 147 | 16 | 4 | 13 | 186 |
| 2035 | 156 | 17 | 5 | 14 | 197 |
| 2036 | 164 | 18 | 5 | 14 | 207 |
| 2037 | 172 | 19 | 5 | 15 | 218 |
| 2038 | 181 | 19 | 6 | 16 | 229 |
| 2039 | 190 | 20 | 6 | 17 | 240 |
| Жилийн хоногийн дундаж | | | | | 133 |

4.2. Төлөвлөлтийн стандарт ба шалгуур нөхцөл

Төлөвлөж буй замын төлөвлөлтийг Монгол улсад шинээр мөрдөж буй автозам төсөллөлтийн норм ба дүрэм “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016-д үндэслэн боловсрууллаа. Уг норм ба дүрэмд заасны дагуу төлөвлөж буй зам нь автозамын ангилал болон зэрэглэлд тавих шаардлагаар тодорхойлоход холбож буй суурин газрын хүн ам, замын сүлжээнд гүйцэтгэх үүргийн хувьд сум хоорондын зорчих хөдөлгөөний хэрэгцээг хангахад зориулсан хуримтлуулагч замын ангилалд [2, 1-11 хуудас] багтаж байна.

Хүснэгт 20.

Хөдөлгөөний үйлчилгээний төвшинд тавигдах шаардлага:

| Замын ангилал ба зэрэглэл | Замын нэршил | ХҮТ | Зорчих хэсгийн байдал | Тайлбар |
|-----------------------------------|---|-------------|--------------------------------|---|
| Хуримтлуулагч зам Зэрэглэл -2А | Хөдөөгийн болон хот суурин газрын хуримтлуулагч зам | D, E төвшин | Зорчих хэсэг зааглагдаагүй зам | Замын хажуугаас хөдөлгөөнд нэвтрэх боломжтой. |

Эх сурвалж: ЗЗБНБД 22-004-2016

Замын зэрэглэлийн хувьд 2А зэрэглэлийн зам буюу 1000-гаас дээш хүн амтай суурин болон жуулчдын зорьдог газруудын хэрэгцээг хангах, тухайн бүс нутаг, хүн ам суурьшсан хот суурин, тосгон руу салах, тэндээс төв зам руу орох боломжоор хангах зориулалттай замын ангилалд [2, 1-12 хуудас] хамаарна. Жилийн хоногийн хөдөлгөөний дундаж эрчим 133 байгаа нь орон нутгийн замын жилийн хоногийн дундаж хөдөлгөөний эрчим 100-гаас дээш бол Зэрэглэл 2А –д хамаарна гэж Авто зам төсөллөлт нормд заасантай тохирч байна.

Хүснэгт 21.

Замын төлөвлөлтийн үндсэн тодорхойлолт

| Үндсэн тодорхойлолт | Тайлбар |
|---------------------|--|
| 2А-Хр3-ЗХГ-2-70 | Хуримтлуулагч зам, зорчих хэсэг зааглагдаагүй, хөдөлгөөний 2 зурвастай, тооцоот хурд 70км/ц. |

Эх сурвалж: ЗЗБНБД 22-004-2016

Тооцоот хурд

Тооцоот хурдыг тухайн газар нутгийн газрын гадарга, замын ангилалтай уялдуулан 50км/цаг байхаар сонголоо.

Хүснэгт 22.

Тооцоот хурд

| Замын ангилал ба зэрэглэл | Замын нэршил | Замын тооцоот хурд, км/цаг | |
|-----------------------------------|---|----------------------------|------------------|
| | | Тэгш тал газар | Нугачаатай газар |
| Хуримтлуулагч зам Зэрэглэл -2А | Хөдөөгийн болон хот суурин газрын хуримтлуулагч зам | 70 -80 | 60 |

Эх сурвалж: 33БНБД 22-004-2016

Авто замын ашиглалтын хугацааг хуримтлуулагч замд 15 жилээр тооцохоор норм дүрэмд [2, 1-29] заасан байна. Хөдөлгөөний эрчим харьцангуй бага, мөн захиалагчийн саналыг харгалзан замын ашиглалтын хугацааг 20 жилээр авч тооцлоо.

Тооцоот ачаалал

Нийтийн зориулалттай замын ангилалд хамрагдаж байгаа тул замын тооцоот ачааллыг тээврийн хэрэгслийн нэг тэнхлэг дээр 10тонн ачаалал гэж тооцлоо [2, 1-32].

| Замын ангилал ба зэрэглэл | Нэг тэнхлэг дээрх нормт ачаа, тн | Хөдөлж буй дугуйн D, см | Зогсож буй дугуйн D, см | Дугуйн нэгж даралт, кН |
|---------------------------------|----------------------------------|-------------------------|-------------------------|------------------------|
| Хуримтлуулагч зам, Зэрэглэл -2А | 10,0 | 37 | 33 | 50 |

Ховд – Чандмань чиглэлийн автозамын хөдөлгөөний үйлчилгээний төвшинг тухайн ангилалд заасны дагуу “D” төвшингээр тооцлоо.

Хүснэгт 23.

| Хөдөлгөөний үйлчилгээний төвшин | Тодорхойлолт |
|---------------------------------|---|
| D | Орон нутгийн зам болон гол зам хоёрын хоорондох холбоос зам бөгөөд ихэнх тохиолдолд зэргэлдээх байгууламж болон замд шууд нэвтрэх боломжоор хангагдана. |

Үзэгдэлтийн зай

Авто зам төсөллөх норм ба дүрэмд зааснаар 60км/ц тооцоот хурдтай тохиолдолд үзэгдэл хангагдах зай: гүдгэр босоо муруйн дээр 420м, хотгор босоо муруйн дээр 85м байна. Дагуу налуун зөрүү 6% байхаар тооцоход босоо муруйн урт 1140м-ээс багагүй байна [2, 2-105].

ЗЗБНБД 22-004-2016 Авто зам төсөллөх норм дүрэмд зааснаар 60км/ц тооцоот хурдтай, 2А зэрэглэлийн хуримтлуулагч замын төсөлтийн үндсэн үзүүлэлтэнд тавигдах шаардлагыг дараах хүснэгтэнд тусгалаа.

Хүснэгт 24.

Авто замын төсөллөлтийн үндсэн элементүүдэд тавигдах шаардлага

| Үзүүлэлт | Зөвшөөрөгдөх хэмжээ |
|---|--------------------------|
| Тооцоот хурд | 60 – 80км/ц |
| Хэвтээ мургуйн хамгийн бага радиус | 60км/ц хурдтай үед 1200м |
| Эргэцтэй хэвтээ мургуйн хамгийн бага радиус | 60км/ц хурдтай үед 130м |
| Эргэц дээрх хөндлөн хэвгийн хэмжээ | 40-60‰ |
| Дагуу налуун хамгийн бага хэмжээ: | |
| Гүдгэр босоо муруйн дээрх үзэгдэлт | 420м |
| Хотгор босоо муруйн дээрх үзэгдэлт | 85м |

Хэвтээ муруйн хамгийн бага радиусыг тооцож үзвэл:

$$R_{min} = \frac{v^2}{127 * (e_{max} + f)} = \frac{60^2}{127 * (0.06 + 0.15)} = 134.9\text{м} \cong 135\text{м}$$

Хөндлөн төлөвлөлтөнд тавигдах шаардлага

Авто зам төсөллөх норм дүрэмд [2, 2-126] Гол замаас доош ангиллын замаар нэвтрэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний зурвасын өргөн 3.0 -3.5м байна гэж заасан.

Хүснэгт 25.

Замын хөндлөн төлөвлөлтийн үзүүлэлт

| Замын ангилал | Хөдөлгөөний зурвасын өргөн, м | Хөвөөний жишиг өргөн, м |
|-----------------------------------|-------------------------------|-------------------------|
| Хуримтлуулагч зам Зэрэглэл -2А | 3.0 -3.6 | 1.0 – 2.0 |

Эх сурвалж: ЗЗБНБД 22-004-2016

Авто зам төсөллөх барилгын норм ба дүрэмд зааснаар зорчих хэсгийн хөндлөн хэвгий асфальтбетон хучлагатай замд 2%-иас ихгүй байна. Зөвшөөрөгдөх хамгийн их дагуу налуун хэмжээ 6% байх ба ийм дагуу налуу бүхий хэсгийн үргэлжлэх урт 300м-ээс хэтрэхгүй байна. Дээрх норм дүрмийн үзүүлэлтэнд тулгуурлан төслийн замын хөндлөн төлөвлөлтийн элементүүдийн үзүүлэлтийг дорх байдлаар санал болгож байна.

Хүснэгт 26.

Төслийн замын санал болгож буй өргөн

| № | Хөндлөн төлөвлөлтийн элемент | Тоон утга |
|---|------------------------------|-----------|
| 1 | Нэг зурвасын өргөн, м | 3.0м |
| 2 | Зурвасын тоо | 2 |
| 3 | Зорчих хэсгийн өргөн, м | 6.0м |
| 4 | Хөвөөнийн өргөн, м | 1.5м |
| 5 | Нийт замын өргөн, м | 9.0м |

Хучилтын тооцооны стандарт: Хучилтын төлөвлөлтөнд Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016 норм дүрэмд заасаншаардлагын дагуу хучилт төлөвлөнө.

4.3. Автозамын трассын төлөвлөлт

Төслийн замын трассыг хоёр хувилбараар төсөллөлөө. Трассын нэгдүгээр хувилбар А0304 Ховд-Алтай чиглэлийн улсын чанартай автозамын 95-р км-ээс баруун зүгт салж Өөшийн гол дайран хөндийгөөр явж, Тоорой элсний дээд хэсгээр гарч, Жаргалант хайрхан, Бумбат хайрханы хоорондох Нарийний шилээр давж, Бүдүүний толгод хүрээд, 43.3 дах км-ээс баруун гар тийш /урд зүгт/ эргэж Өндөр Хар уулын урд талаар гаран Чандмань сумын баруун урд зүгээс орно. Энэ хувилбар 55.05 км урттай.

Хүснэгт 27.

Трассын нэгдүгээр хувилбар

| Трассын цэгүүд | Пикет | Цэгийн координат | | тайлбар | Эргэлтийн радиус |
|----------------|--------------|------------------|---------------|--------------|------------------|
| Трассын эхлэл | 00+000.0000 | X | 5249321.80900 | 89°46'15.36" | |
| | | Y | 455851.41000 | | |
| Өнцгийн орой 1 | 4+848.15090 | X | 5249344.27092 | 42°07'25.97" | 2000.00 |
| | | Y | 461469.72537 | | |
| Өнцгийн орой 2 | 6+318.55170 | X | 5251840.79512 | 42°45'09.33" | 3000.00 |
| | | Y | 464208.28119 | | |
| Өнцгийн орой 3 | 10+318.32140 | X | 5251824.27589 | 16°29'50.75" | 3000.00 |
| | | Y | 466576.56690 | | |
| Өнцгийн орой 4 | 11+941.30190 | X | 5250288.51147 | 25°22'06.28" | 5000.00 |

| | | | | | |
|-----------------|--------------|---|---------------|---------------|---------|
| | | Y | 471632.29169 | | |
| Өнцгийн орой 5 | 17+878.68860 | X | 5251583.32408 | 58°03'25.95" | 5000.00 |
| | | Y | 480325.83217 | | |
| Өнцгийн орой 6 | 27+834.41210 | X | 5255779.70520 | 14°24'41.66" | 500.00 |
| | | Y | 482147.98513 | | |
| Өнцгийн орой 7 | 29+697.06750 | X | 5255938.99164 | 22°12'32.44" | 700.00 |
| | | Y | 482271.91047 | | |
| Өнцгийн орой 8 | 29+970.78780 | X | 5256297.90464 | 16°46'09.55" | 1000.00 |
| | | Y | 482372.62075 | | |
| Өнцгийн орой 9 | 30+350.24900 | X | 5256908.00444 | 26°45'02.99" | 1000.00 |
| | | Y | 482360.95625 | | |
| Өнцгийн орой 10 | 31+042.17660 | X | 5260686.59055 | 29°08'43.13" | 3000.00 |
| | | Y | 484175.85597 | | |
| Өнцгийн орой 11 | 35+742.37470 | X | 5263037.97182 | 21°41'06.98" | 3000.00 |
| | | Y | 484032.46004 | | |
| Өнцгийн орой 12 | 37+879.05510 | X | 5265913.22422 | 55°12'52.58" | 1100.00 |
| | | Y | 482680.99742 | | |
| Өнцгийн орой 13 | 41+138.74880 | X | 5267922.30338 | 23°58'17.81" | 3000.00 |
| | | Y | 483842.78955 | | |
| Өнцгийн орой 14 | 43+325.57490 | X | 5272575.90000 | 34°18'30.67" | 2000.00 |
| | | Y | 484337.48151 | | |
| Өнцгийн орой 15 | 47+948.59360 | X | 5275016.35006 | 28°51'45.29" | 3000.00 |
| | | Y | 486412.73841 | | |
| Өнцгийн орой 16 | 51+273.97670 | X | 5277773.89921 | 38°17'01.00" | 2000.00 |
| | | Y | 486974.46333 | | |
| Өнцгийн орой 17 | 53+958.29490 | X | 5278890.60768 | 57°30'44.01" | 100.00 |
| | | Y | 486411.11334 | | |
| Өнцгийн орой 18 | 54+572.72400 | X | 5278902.37924 | 66°15'12.79" | 50.00 |
| | | Y | 486293.55195 | | |
| Өнцгийн орой 19 | 54+648.55040 | X | 5278972.66869 | 90°32'01.40" | 10.00 |
| | | Y | 486270.67498 | | |
| Өнцгийн орой 20 | 54+695.54870 | X | 5278937.08198 | 116°45'25.65" | 15.00 |
| | | Y | 486164.69959 | | |
| Өнцгийн орой 21 | 54+803.45120 | X | 5278997.14416 | 28°40'43.19" | 100.00 |
| | | Y | 486173.34932 | | |
| Трассын төгсгөл | 55+052.53330 | X | 5279197.45781 | 339°30'58.77" | |
| | | Y | 486098.52016 | | |

Трассын хоёрдугаар хувилбарын хувьд, эхлэлийн цэгээс баруун тийш гарч Өөшийн голын хөндийгөөр явж, Өөшийн голыг дайран, Тоорой элсний дээд хэсгээр гарч, Жаргалант хайрхан, Бумбат хайрханы хоорондох Нарийний шилээр давах хүртэл өмнөх трассаас явна. Энэхүү трасс 34.3км-ээс баруун гар тийш /зүүн урд зүгт/ эргэж Бүдүүний толгодын урдуур гарч Чандмань сумын зүүн урдаас орно. Энэ хувилбар нь 57.3 км болж байна.

Хүснэгт 28.

Трассын хоёрдугаар хувилбар

| Трассын | Пикет | Цэгийн координат | тайлбар | Эргэлтийн |
|---------|-------|------------------|---------|-----------|
|---------|-------|------------------|---------|-----------|

| ЦЭГҮҮД | | | | радиус | |
|-----------------|--------------|---|---------------|---------------|---------|
| Трассын эхлэл | 00+000.0000 | X | 5249321.80900 | 89°46'15.36" | |
| | | Y | 455851.41000 | | |
| Өнцгийн орой 1 | 4+848.15090 | X | 5249344.27092 | 42°07'25.97" | 2000.00 |
| | | Y | 461469.72537 | | |
| Өнцгийн орой 2 | 6+318.55170 | X | 5251840.79512 | 42°45'09.33" | 3000.00 |
| | | Y | 464208.28119 | | |
| Өнцгийн орой 3 | 10+318.32140 | X | 5251824.27589 | 16°29'50.75" | 3000.00 |
| | | Y | 466576.56690 | | |
| Өнцгийн орой 4 | 11+941.30190 | X | 5250288.51147 | 25°22'06.28" | 5000.00 |
| | | Y | 471632.29169 | | |
| Өнцгийн орой 5 | 17+878.68860 | X | 5251583.32408 | 58°03'25.95" | 5000.00 |
| | | Y | 480325.83217 | | |
| Өнцгийн орой 6 | 27+834.41210 | X | 5255779.70520 | 14°24'41.66" | 500.00 |
| | | Y | 482147.98513 | | |
| Өнцгийн орой 7 | 29+697.06750 | X | 5255938.99164 | 22°12'32.44" | 700.00 |
| | | Y | 482271.91047 | | |
| Өнцгийн орой 8 | 29+970.78780 | X | 5256297.90464 | 16°46'09.55" | 1000.00 |
| | | Y | 482372.62075 | | |
| Өнцгийн орой 9 | 30+350.24900 | X | 5256908.00444 | 26°45'02.99" | 700.00 |
| | | Y | 482360.95625 | | |
| Өнцгийн орой 10 | 30+973.44318 | X | 5260779.13313 | 26°27'15.46" | 2000.00 |
| | | Y | 484220.30527 | | |
| Өнцгийн орой 11 | 35+554.84048 | X | 5261639.81960 | 34°10'33.96" | 2000.00 |
| | | Y | 485326.29676 | | |
| Өнцгийн орой 12 | 37+064.31930 | X | 5261708.72199 | 24°34'44.68" | 2000.00 |
| | | Y | 486387.74005 | | |
| Өнцгийн орой 13 | 37+935.45650 | X | 5262626.36134 | 41°17'43.93" | 3000.00 |
| | | Y | 488092.46896 | | |
| Өнцгийн орой 14 | 40+467.53368 | X | 5266979.02150 | 13°59'58.48" | 3000.00 |
| | | Y | 489712.18647 | | |
| Өнцгийн орой 15 | 44+345.98440 | X | 5271383.98367 | 33°14'14.44" | 3000.00 |
| | | Y | 490207.19519 | | |
| Өнцгийн орой 16 | 49+255.22998 | X | 5278890.61088 | 57°27'28.14" | 15000.0 |
| | | Y | 486411.11173 | | |
| Өнцгийн орой 17 | 56+839.90833 | X | 5278902.37924 | 66°15'18.07" | 50.00 |
| | | Y | 486293.55195 | | |
| Өнцгийн орой 18 | 56+901.02429 | X | 5278972.66869 | 90°32'01.40" | 10.00 |
| | | Y | 486270.67498 | | |
| Өнцгийн орой 19 | 56+948.02163 | X | 5278937.08198 | 116°45'25.65" | 15.00 |
| | | Y | 486164.69959 | | |
| Өнцгийн орой 20 | 57+055.92412 | X | 5278997.14416 | 28°40'43.19" | 100.00 |
| | | Y | 486173.34932 | | |
| Трассын төгсгөл | 57+305.00630 | X | 5279197.45781 | 339°30'58.77" | |
| | | Y | 486098.52016 | | |

Төлөвлөсөн хоёр хувилбарын муруйн цэсийн тооцоог инженер-геодезийн тайлангаас үзнэ үү.

4.4. Авто замын дагуу төлөвлөлт

Төслийн замын газар нутаг тэгш тал, нугачаа толгод хосолсон газар нутгаар тавигдаж байгаа бөгөөд трассын эхний 18км нь голын хөндий, тэгш тал газраар өнгөрч байгаа. Ойролцоогоор 18 дах км орчмоос Жаргалант, Бумбат хайрханы дундах Нарийний шилээр 42-48 промильтой өгсөж цаашид нугачаатай хэсгээр явна. Дагуу налуун хамгийн их хэмжээ нь 48 промиль байхаар тооцсон.

Урьдчилсан дагуу төлөвлөлтийг хавсралтаас үзнэ үү.


4.5. Автозамын хөндлөн төлөвлөлт

Авто зам төсөллөх барилгын норм ба дүрэмд заасны дагуу төслийн замын хөндлөн төлөвлөлтийн элементүүдийг хувилбараар тооцлоо.

Хүснэгт 29.

Төслийн замын санал болгож буй өргөн

| № | Хөндлөн төлөвлөлтийн элемент | Тоон утга |
|---|----------------------------------|-----------|
| 1 | Нэг зурвасын өргөн, м | 3.0м |
| 2 | Зурвасын тоо | 2 |
| 3 | Зорчих хэсгийн өргөн, м | 6.0м |
| 4 | Зорчих хэсгийн хөндлөн хэвгий, % | 2% |
| 5 | Хөвөөний өргөн, м | 1.5м |
| 6 | Хөвөөний хөндлөн хэвгий, % | 3% |
| 7 | Нийт замын өргөн, м | 9.0м |



Зураг 9. Нэг маягийн хөндлөн огтлол

4.6. Ус зайлуулах хоолойн төлөвлөлт

Замын хувилбаруудын трассын дагуу гадаргуун усны судалгаа хийж, гуу жалганы үндсэн голидрол, ус цугларах талбайн үзлэг хийлээ.



I хувилбарын дагуух жалга



I хувилбарын дагуух жалга



Зураг 10. I хувилбарын дагуух ус хураах талбайн ерөнхий төлөв байдал

Гидрологийн судалгаа. Жаргалант хайрханы бэл, Нарийний шил, Нарийний хоолой, Бүдүүний толгодын бэл дагуух жалга гуу, хуурай сайруудаар түр хугацаанд ажиглагддаг хур борооны үерийн тооцоо, олон жилийн дундажын урсацын тодорхойлолтыг Чандмань, Манхан сумдын цаг уурын өртөөнд хийсэн хур тунадасны олон жилийн ажиглалтын мэдээ [Хавсралт 1, хүснэгт Х1-8], сайруудын ус зүйн морфометрийн тодорхойлолтонд тулгуурлан гаргав.

Дулааны улиралд орчны уулсаар эрчимшил ихтэй, түр зуурын аадар бороо орох үеээр хуурай сайруудаар сул хөрс, чулуулаг зөөсөн уруйн үер үүснэ.

Сайруудын сав газрын үерийн урсацын тооцоо. Замын хувилбаруудын дагуу түүнд янз бүрийн өнцгөөр хөндлөн гарч буй зарим томоохон хуурай сайр, жалганы хур борооны үерийн хамгийн их урсацын тооцоог манай орны байгаль цаг уурын нөхцөлд тохируулан гаргасан хур борооны хязгаарын эрчимшлийн аргаар тодорхойлов.

Сайрын ус зүйн тооцооллын хөндлүүрийг зам хөндлөн гарч буй заагаар авч, хөндлүүрээс дээш хэсэгт гадаргын урсацыг бүрдүүлэх талбай /км²/, үндсэн сайр, жалгын

урт /км/, жалга гууны нийт урт, сайр жалга, ус хураах сав газрын хажуу бэлийн дундаж налуу, нягтшил, ижил өндрийн шугамын нийт урт зэргийг 1:100 000 нарийвчлалтай зургаар тодорхойлов.

Хур борооны хязгаарын эрчимшлийн арга:

Энэ аргад тулгуурлан бага ус хураах талбайтай жижиг гол хуурай сайрын хур борооны хамгийн их өнгөрөлтийг дараах томъёогоор тооцно. Үүнд:

$$Q_{1\%} = q_{1\%} \cdot \varphi \cdot H_{1\%} \cdot \sigma \cdot \lambda_{1\%} \cdot F$$

Үүнд:

$Q_{1\%}$ - 1%-ийн хангамшилтай өнгөрөлт;

$q_{1\%}$ - 1%-ийн хангамшилтай их урсацын модуль, л/с*км²;

φ - урсацын итгэлцүүр;

$H_{1\%}$ -1%-ийн хангамшилтайхоногийн хамгийн их тунадас, мм;

σ - нууршил, намагшлын итгэлцүүр;

$\lambda_{1\%}$ - 1%-ийн хангамшилаас бусад хангамжилд шилжүүлэх итгэлцүүр;

F - ус хурах талбай, км²;

Урсацын хамгийн их модулийг / $\square_{1\%}$ / тодорхойлоход шаардагдах голдирол хэлбэр зүйн итгэлцүүр / Φ_{Γ} / болон ай савын хажуу бэлээр ус урсах хугацааг / $t_{ХБ}$ / дараах томъёогоор тодорхойлсон болно.

$$\Phi_{\Gamma} = \frac{1000 L}{K_{\Gamma} \cdot J_{\Gamma} \cdot F^{1/4} \cdot (\varphi \cdot H_{1\%})};$$

Үүнд:

L- Тухайн зам хүртэлх үндсэн гол, сайрын урт, км;

K_{Γ} – Голын голидрол, татмын адраашлын итгэлцүүр;

\square_{Γ} Сайрын дундаж хэвгий, %;

Ус цуглуулах талбайн хажуу бэлээр ус урсах хугацааг / $t_{ХБ}$ / тодорхойлоход шаардагдах хажуу бэлийн хэлбэр зүйн тодорхойлолтыг / $\Phi_{ХБ}$ / доорх томъёогоор тодорхойлов.

$$\Phi_{ХБ} = \frac{(1000 \cdot I)^{1/2}}{n_{ХБ} \cdot J^{1/4} \cdot (\varphi \cdot H_{1\%})^{1/2}};$$

$$I = \frac{F}{1.8 \cdot (\Sigma I + L)};$$

I – ус хурах талбайн хажуу бэлийн дундаж урт, км;

n_{x6} - хажуу бэлийн адраашлын итгэлцүүр;

J - сав газрын дундаж хэвгий;

$\sum I$ - Жалга сайрын уртын нийлбэр, км;

Үерийн урсацын итгэлцүүрийг доорх томъёогоор тодорхойлов. Үүнд:

$$\varphi = \frac{C_2 \cdot \varphi_0}{(F+1)^{n_6} \cdot \left(\frac{J_6}{50}\right)^{n_5}}$$

Үүнд: C_2 – Хөрсний бүтцээс хамаарах итгэлцүүр;

φ_0 - $F=10\text{км}^2$, $J_6=50$ байх үеийн урсацын итгэлцүүр;

n_6 - Хөрсний бүтцээс хамаарах итгэлцүүр;

n_5 - уур амьсгалаас хамаарсан итгэлцүүр;

F – ус хурах талбай, км^2 ;

φ - урсацын итгэлцүүр;

Хур борооны хязгаарын эрчимшлийн аргыг ашиглан ус хурах сав газрын ус зүйн морфометрийн тодорхойлолт, хур борооны үерийн усны нэг хувийн хангамшилттай өнгөрөлтийг тооцсон.


Авто замын хоолойн тооцоо, төлөвлөлт

Төлөвлөж буй авто замын трассын дагуу гидрологийн судалгаа хийсний үндсэн дээр гадаргуун усыг авто замаас зайлуулах хоолойнуудыг нэгдүгээр хувилбарт 58 цэгт, хоёрдугаар хувилбарт 60цэгт барихаар төлөвлөж, тэдгээр хоолойнуудын байршлыг хүснэгтээр үзүүлэв.

| Нэгдүгээр хувилбарын хоолойн байрлал | | | | | | | |
|--------------------------------------|-----------------|-----------------------|-----------------|----|-----------------|-----------------------|-----------------|
| № | Хоолойн байрлал | Хоолойн төрөл, хэмжээ | Далангийн өндөр | № | Хоолойн байрлал | Хоолойн төрөл, хэмжээ | Далангийн өндөр |
| 1 | ПК0+630 | Ф1000 | 1.45 | 31 | ПК31+400 | Ф1000 | 1.55 |
| 2 | ПК1+540 | Ф1000 | 1.4 | 32 | ПК32+300 | 2 Ф1000 | 1.45 |
| 3 | ПК3+100 | Ф1000 | 1.65 | 33 | ПК33+500 | Ф1000 | 1.4 |
| 4 | ПК3+900 | Ф1000 | 1.5 | 34 | ПК34+800 | Ф1500 | 1.95 |
| 5 | ПК5+050 | Ф1500 | 1.85 | 35 | ПК35+700 | Ф1000 | 1.7 |
| 6 | ПК6+200 | Ф1000 | 1.25 | 36 | ПК36+700 | Ф1000 | 1.55 |
| 7 | ПК7+420 | Ф1000 | 1.3 | 37 | ПК39+000 | 2 Ф1000 | 1.4 |
| 8 | ПК8+00 | Ф1000 | 1.45 | 38 | ПК42+500 | Ф1000 | 1.5 |
| 9 | ПК8+960 | Ф1000 | 1.45 | 39 | ПК40+300 | 2 Ф1000 | 1.5 |
| 10 | ПК9+600 | Ф1000 | 1.5 | 40 | ПК42+000 | Ф1000 | 1.3 |
| 11 | ПК10+650 | Ф1500 | 1.85 | 41 | ПК42+500 | Ф1000 | 1.35 |
| 12 | ПК11+900 | Ф1000 | 1.65 | 42 | ПК43+100 | Ф1500 | 1.95 |
| 13 | ПК13+200 | Ф1500 | 2 | 43 | ПК43+800 | 2 Ф1000 | 1.35 |
| 14 | ПК14+500 | Ф1000 | 1.25 | 44 | ПК 45+000 | Ф1000 | 1.35 |
| 15 | ПК15+100 | Ф1200 | 1.7 | 45 | ПК 45+500 | Ф1000 | 1.30 |
| 16 | ПК16+080 | Ф1000 | 1.45 | 46 | ПК 46+100 | Ф1000 | 1.45 |
| 17 | ПК17+400 | Ф1000 | 1.25 | 47 | ПК 47+400 | Ф1000 | 1.35 |
| 18 | ПК18+200 | Ф1000 | 1.32 | 48 | ПК 48+100 | Ф1000 | 1.3 |
| 19 | ПК19+400 | Ф1500 | 1.85 | 49 | ПК 48+600 | Ф1000 | 1.45 |
| 20 | ПК20+500 | Ф1000 | 1.25 | 50 | ПК 49+000 | Ф1000 | 1.65 |
| 21 | ПК21+100 | Ф1000 | 1.32 | 51 | ПК 49+400 | Ф1000 | 1.55 |
| 22 | ПК21+800 | Ф1000 | 1.45 | 52 | ПК 49+800 | Ф1000 | 1.35 |
| 23 | ПК22+800 | Ф1000 | 1.32 | 53 | ПК 50+600 | Ф1000 | 1.45 |
| 24 | ПК23+700 | Ф1500 | 2.25 | 54 | ПК 51+500 | Ф1000 | 1.45 |
| 25 | ПК25+400 | Ф1000 | 1.25 | 55 | ПК 51+900 | Ф1500 | 1.3 |
| 26 | ПК27+200 | Ф1000 | 1.25 | 56 | ПК 52+600 | Ф1000 | 1.3 |
| 27 | ПК28+000 | Ф1000 | 1.25 | 57 | ПК 53+300 | Ф1200 | 1.35 |
| 28 | ПК28+700 | Ф1000 | 1.25 | 58 | ПК 54+100 | Ф1200 | 1.35 |
| 29 | ПК29+100 | Ф1000 | 1.25 | | | | |
| 30 | ПК29+400 | Ф1000 | 1.55 | | | | |

Хоёрдугаар хувилбарын хоолойн байрлал


| № | Хоолойн байрлал | Хоолойн төрөл, хэмжээ | Далангийн өндөр | № | Хоолойн байрлал | Хоолойн төрөл, хэмжээ | Далангийн өндөр |
|----|-----------------|-----------------------|-----------------|----|-----------------|-----------------------|-----------------|
| 1 | ПК0+630 | Ф1000 | 1.45 | 31 | ПК31+400 | Ф1000 | 1.55 |
| 2 | ПК1+540 | Ф1000 | 1.4 | 32 | ПК32+300 | 2 Ф1000 | 1.45 |
| 3 | ПК3+100 | Ф1000 | 1.65 | 33 | ПК33+500 | Ф1000 | 1.4 |
| 4 | ПК3+900 | Ф1000 | 1.5 | 34 | ПК34+800 | Ф1500 | 1.95 |
| 5 | ПК5+050 | Ф1500 | 1.85 | 35 | ПК35+100 | 2 Ф1500 | 1.9 |
| 6 | ПК6+200 | Ф1000 | 1.25 | 36 | ПК35+800 | Ф1000 | 1.65 |
| 7 | ПК7+420 | Ф1000 | 1.3 | 37 | ПК36+500 | Ф1000 | 1.4 |
| 8 | ПК8+00 | Ф1000 | 1.45 | 38 | ПК37+100 | Ф1000 | 1.5 |
| 9 | ПК8+960 | Ф1000 | 1.45 | 39 | ПК37+900 | Ф1200 | 1.5 |
| 10 | ПК9+600 | Ф1000 | 1.5 | 40 | ПК38+500 | Ф1500 | 1.85 |
| 11 | ПК10+650 | Ф1500 | 1.85 | 41 | ПК39+300 | Ф1000 | 1.35 |
| 12 | ПК11+900 | Ф1000 | 1.65 | 42 | ПК39+900 | Ф1500 | 1.95 |
| 13 | ПК13+200 | Ф1500 | 2 | 43 | ПК41+850 | 2 Ф1000 | 1.35 |
| 14 | ПК14+500 | Ф1000 | 1.25 | 44 | ПК 42+350 | Ф1200 | 1.55 |
| 15 | ПК15+100 | Ф1200 | 1.7 | 45 | ПК 43+100 | Ф1200 | 1.6 |
| 16 | ПК16+080 | Ф1000 | 1.45 | 46 | ПК 43+650 | Ф1000 | 1.45 |
| 17 | ПК17+400 | Ф1000 | 1.25 | 47 | ПК 44+200 | Ф1000 | 1.35 |
| 18 | ПК18+200 | Ф1000 | 1.32 | 48 | ПК 44+500 | Ф1000 | 1.35 |
| 19 | ПК19+400 | Ф1500 | 1.85 | 49 | ПК 45+300 | 2Ф1000 | 1.45 |
| 20 | ПК20+500 | Ф1000 | 1.25 | 50 | ПК48+000 | Ф1000 | 1.45 |
| 21 | ПК21+100 | Ф1000 | 1.32 | 51 | ПК 49+280 | Ф1000 | 1.45 |
| 22 | ПК21+800 | Ф1000 | 1.45 | 52 | ПК 50+100 | Ф1000 | 1.35 |
| 23 | ПК22+800 | Ф1000 | 1.32 | 53 | ПК 50+800 | Ф1000 | 1.35 |
| 24 | ПК23+700 | Ф1500 | 2.25 | 54 | ПК 51+600 | Ф1000 | 1.35 |
| 25 | ПК25+400 | Ф1000 | 1.25 | 55 | ПК 52+200 | Ф1000 | 1.35 |
| 26 | ПК27+200 | Ф1000 | 1.25 | 56 | ПК 52+600 | Ф1000 | 1.35 |
| 27 | ПК28+000 | Ф1000 | 1.25 | 57 | ПК 53+500 | Ф1000 | 1.35 |
| 28 | ПК28+700 | Ф1000 | 1.25 | 58 | ПК 54+250 | Ф1000 | 1.35 |
| 29 | ПК29+100 | Ф1000 | 1.25 | 59 | ПК 55+800 | Ф1500 | 1.65 |
| 30 | ПК29+400 | Ф1000 | 1.55 | 60 | ПК 56+600 | 2Ф1200 | 1.55 |



Зураг 12. Ус зайлуулах хоолойн хэсэглэл

4.7. Жижиг гүүр төлөвлөлт

Төлөвлөж буй замын трассын дагуу байнгын болон байнгын бус урсацтай дараа газруудад гидрологийн урьдчилсан тооцоо хийсний үндсэн дээр жижиг гүүр төлөвлөлөө. Трассын эхэн хэсэгт буюу ПК 4+500 дээр хэд хэдэн жижиг салаагаар урсдаг Өөшийн голыг дайран гарч байгаа бөгөөд энд жижиг гүүр төлөвлөсөн.



Зураг 13. Өөшийн гол

Трассын дагуу төлөвлөж буй жижиг гүүрийн байрлал, төрөл

Хүснэгт 32.

| № | Гүүрийн байрлал | Гол, урсацын төрөл, нэр | Гүүрийн урт, м | Гүүрийн өндөр, м | Гүүрийн координат |
|---|-----------------|-------------------------|----------------|------------------|---------------------------------|
| 1 | ПК4+500 | Өөшийн гол | 15.0 м | 2.5м | X=460369.0166 Y=5249339.8703 |

4.8. Трассын ПК30+200 - ПК31+100 хэсгийн шийдэл, харьцуулалт


Төлөвлөж буй трассын ПК30+200 - ПК31+100 хэсэгт үерийн өргөн жалгатай хэсэгт замын трассын дөрвөн хувилбар боловсруулан харьцууллаа. Үүнд:

- a) Энэ хэсэгт замын трассыг шулуун татаж, үерийн жалга дээр 6x2 харьцаатай хоёр ширхэг жижиг гүүрээр төлөвлөх;
- b) Энэ хэсэгт мөн замын трассыг шулуун татаж, үерийн жалга дээр 2x2 дөрвөлжин хос хоолойг хоёр байрлалд төлөвлөх;
- c) Энэ хэсэгт замын трассыг уулын бэл дагуулан эргэлттэй төлөвлөж, жалга талын далангийн хажууг бэхлэх;
- d) Давуулах далан төлөвлөх;



Зураг 14.

Трассын ПК30+200 - ПК31+100 хэсгийн ерөнхий байдал




Зураг 15. Трассын ПК30+200 - ПК31+100 хэсгийн фото зураг

| Ус зүйн тооцооны үзүүлэлт | | | | | | | | | | | | | | |
|---------------------------|--------------|---------------------------|---------------|--------------|------------------|-----------|---------------------------|-------------|-------------------|------------|---------------------------------------|------------------------------------|------------------------------------|------------------------------------|
| № | Байрлал /км/ | F (км ²) | L_r (км) | J_r (‰) | $I_{хб}$ (км) | φ | $\varphi H_{1\%}$ (мм) | $\Phi_{хб}$ | $t_{хб}$ (мин) | $\Phi_{г}$ | $q_{1\%}$ (л/сек.км ²) | $Q_{1\%}$ (м ³ /сек) | $Q_{2\%}$ (м ³ /сек) | $Q_{5\%}$ (м ³ /сек) |
| 1 | 31+00 | 67.860 | 30.850 | 53.40 | 2.20 | 0.304 | 31.62 | 10.29 | 150.00 | 110.89 | 0.0210 | 45.055 | 39.648 | 32.439 |



Км 31+00.0 дээрх ус хураах талбай



Км 31+00.0 дээрх ус хураах талбай

Зураг 16.

Гидравлик тооцоог Маннингийн томъёогоор бодож дараах хүснэгтэнд орууллаа.

Хүснэгт 34.


| | |
|--|--|
| $Q=V \cdot A$ | |
| Q-Усны зарцуулга / м ³ /сек / | |
| V- Урсгалын хурд /Дугуй, дөрвөлжин хоолой, шуудуу / м/сек / | |
| A-Төлөвлөж буй байгууламжаар урсах усны нойтон талбай м ² | |
| $V=1/n \cdot R^{2/3} \cdot S^{1/2}$ | |
| n- Гадаргуугаасхамаарсан коэффициент, Асфальтбетон 0.013-0.017, Бетон 0.011-0.020, байгалийн жалгандТогтмол хэсэгт 0.03-0.07, Тогтмол бус хэсэгт 0.04-0.07 гэх мэт | |
| S-Дагууналуу L / L | |
| R- Гидравлик радиус | |
| $R=A/P$ | |
| A-Төлөвлөж буй байгууламжаар урсах усны нойтон талбай /м ² / | |
| P-Төлөвлөж буй байгууламжаар урсах усны периметр /м/ | |

Авто замын трасс дайран өнгөрөх цэгийн одоо байгаа жалгын геометр үзүүлэлтийг доор үзүүлэв. /Хамгийннарийнхэсэгт/

Хүснэгт 35.

| Ажлын нэр | Х/н | Геометр үзүүлэлт |
|---|----------------|------------------|
| Одообайгаа жалгын ёроолын өргөн | м | 54 |
| Одоо байгаа жалгын дээд талын өргөн | м | 87 |
| Одоо байгаа жалгын дундаж өндөр | м | 2.8 |
| Одоо байгаа жалгынхөндлөн огтлолын талбай | м ² | 197.4 |
| Шуудууны одоо байгаа дагуу налуу | % | 1% |
| Гадаргуугаасхамаарсан коэффициент | | n=0.05 |
| Шуудууны бэхэлгээ | | байхгүй |

Тайлбар: Одоо байгаа жалгын шахагдсан хэсгийг сонгож геометр үзүүлэлтийг сонгож авлаа.



Зураг 17.


Одоо байгаа жалгын хамгийн нарийн хэсэг дээр тооцоогоор гарсан $Q3\%=32.5$ м³/сек усыг ямар түвшинтэйгээр гарах боломжтойг дараах тооцоогоор харуулав.

Хүснэгт 36.

| Байрлал | Үерийн усны өндөр /м/ | A | P | R | $R^{2/3}$ | n | $I^{1/2}$ | V | Qd | Тайлбар |
|----------|-----------------------|-------|--------|--------|-----------|----|-----------|-------|---------|-------------------|
| км 31+00 | 2.8 | 197.4 | 174.47 | 1.1314 | 1.086 | 20 | 0.10 | 2.171 | 428.640 | Одоо байгаа жалга |
| км 31+00 | 0.8 | 56.4 | 127 | 0.4441 | 0.582 | 20 | 0.10 | 1.165 | 65.694 | Одоо байгаа жалга |
| км 31+00 | 0.7 | 40.68 | 124.61 | 0.3265 | 0.474 | 20 | 0.10 | 0.949 | 38.603 | Одоо байгаа жалга |

а). Гүүр төлөвлөх хувилбар.

Төлөвлөж буй трассын ПК30+200 - ПК31+000 хэсэгт үерийн мушгирсан хуурай сайр дээр жижиг 2 гүүр төлөвлөхөөр тооцлоо.



Зураг 18. Нарийны хоолойн хэсгийн үерийн хуурай сайр

Трассын ПК30+200 - ПК31+100 хэсгийн жижиг гүүрийн байрлал

Хүснэгт 37.


| № | Гүүрийн байрлал | Гол, урсацын төрөл, нэр | Гүүрийн урт, м | Гүүрийн өндөр, м | Гүүрийн координат |
|---|-----------------|-------------------------|----------------|------------------|-------------------|
| 1 | ПК30+000 | Жалга | 8.0 м | 2.5м | |
| 2 | ПК31+000 | Жалга | 8.0 м | 2.0м | |

Гүүрийн ажлын тоо хэмжээ

Хүснэгт 38.

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|---|----------|--|-------------|------------|
| 28-02-00 Барилгын талбайн бэлтгэл | | | | |
| | 28-02-01 | Гүүрийн зурвас газрын цэвэрлэгээ | м2 | 288 |
| | 28-02-02 | Барилгын үйлдвэрлэл явуулах талбай байгуулах | м2 | 225 |
| 28-09-00 Захын тулгуур байрлуулах | | | | |
| 3 | 28-05-02 | Суурийн нүх ухах | м3 | 502.4 |
| 4 | 28-05-06 | Суурь тэгшилгээ бетон | м3 | 7.68 |
| 5 | 28-05-07 | Суурь бетон цутгах | м3 | 49.5 |
| 6 | 28-09-09 | Захын тулгуурын их бие | м3 | 125.4 |
| 7 | 28-05-12 | Буцаан дүүргэлт | м3 | 302.6 |
| 8 | 28-09-05 | Захын тулгуурын далавч | м3 | 39.04 |
| 9 | 28-09-02 | Захын тулгуурын толгой цутгах | м3 | 6.38 |
| 28-10-00 Алгасалын бүтээц байрлуулах ба байгуулах | | | | |
| 10 | 28-10-09 | Хавтант дамнуруу цутгах | м3 | 24.03 |
| 11 | 28-10-12 | Ус гарах хоолой байрлуулах | е | 4 |

| | | | | |
|---------------------------------|----------|---|----|-------|
| 12 | 28-11-06 | Аюулгүйн хашлага цутгах | м3 | 7.52 |
| 28-12-00 Зорчих хэсэг байгуулах | | | | |
| 13 | 28-05-06 | Тэгшилгээний бетон цутгах | м3 | 9 |
| 14 | 28-12-00 | Асфальтбетон хучилт хийх | м3 | 7 |
| 15 | 28-18-12 | Халуун битумээр 2 үе наамал ус тусгаарлагч хийх | м2 | 100 |
| 16 | 28-12-10 | Дамжих хавтан байрлуулах | м3 | 13.2 |
| 28-10-00 Далан суурийн бэхэлгээ | | | | |
| 17 | 28-18-13 | Голдиролын чулуун бэхэлгээ 200мм | м2 | 228.4 |
| 18 | 28-15-03 | Элс хайрган дэвсгэр үе 150мм | м2 | 171.3 |
| 19 | 28-12-13 | Эргийн чулуун бэхэлгээ 1 үе | м3 | 189 |
| 20 | 28-09-04 | Рисберм чулуугаар байгуулах | м3 | 74.68 |



бу/м төмөрбетон гүүр

Зураг 19.

b) Хоолой төлөвлөх хувилбар







Зураг 20. Ус цугларах талбай

2 x 2 дөрвөлжөн 3ш хоолойн ажлын тоо хэмжээ L=13500

Хүснэгт 39.

| Үндэслэл | Ажилбар | Тоо хэмжээ |
|----------|--|------------|
| 28-18-01 | Хоолойн суурийн ухмал /м3/ | 73.6 |
| 28-18-02 | Хоолойн ул суурийг нягтруулах /м2/ | 160.0 |
| 28-18-03 | Зохист ширхэглэл бүхий элс хайрганы хольцоор суурь байгуулах/м3/ | 48.0 |
| 28-22-01 | Бетон суурь байгуулах В15 /м3/ | 11.73 |
| 28-22-02 | Хоолойн угсармал хэсэглэл суурин дээр цутгах В30/м3/ | 94.5 |
| 28-18-07 | Хоолойн тулц бетон цутгах В25/ м3/ | 11.8 |
| 28-22-04 | Хоолойн далбааны хэсэглэл цутгах В30 / м3/ | 55.65 |
| 28-22-03 | Хоолойн толгойн хэсэглэл цутгах В30 / м3/ | 1.7 |
| 28-18-10 | Түрхмэл ус тусгаарлагч хийх /м2/ | 345.0 |
| 28-18-12 | Амсрын ул бетон цутгах В 25, h=20см /м2/ | 21.48 |
| 28-14-01 | Урсгал залах далан байгуулах /м3/ | 1001.6 |
| 28-15-07 | Урсгал залах далангийн шуудуун доторх талын бетоноор бэхлэх В-15 | 306.48 |
| 28-18-16 | Буцаан дүүргэлт /м3/ | 25.5 |
| 28-18-18 | Урсгалын хэвгийг бульдозероор засах/м3/ | 187.5 |

дүрэм 21.000000



Зураг 21. 2x2 Төмөрбетон дөрвөлжин хоолой

с) Бэхэлгээтэй далан төлөвлөх

Замын трасс Нарийний шилээр даваад үерийн жалганы хойд талаар явна. ПК30+200-ПК31+100 хэсэгт жалга мушгирч байгаа хэсэгт жалгыг огтлохгүйгээр жалганы хойд талаар уулын бэлээр явахаар нэг хувилбар төлөвлөлөө. Энэ тохиолдолд далангийн жалга талын хажуу налууг угаагдлаас хамгаалан чулуугаар бэхлэхээр төлөвлөж байна. Жалга даган тойрч байгаа энэ хэсгийн урт 1.5км болно.



Зураг 22. ПК30+200 – ПК31+500


Бэхэлгээтэй далан төлөвлөсөн хэсэг:

ПК30+200 – ПК31+500

L=1.5км

Хэвтээ муруйн радиус R(min)=500м;

Далангийн өндөр h(min)=1.8м



Зураг 23. Далангийн хажуу налуун бэхэлгээ

Трассын ПК30+200 - ПК31+100 хэсгийн бэхэлгээтэй далангийн хэмжээ

Хүснэгт 40.

| № | Далангийн байрлал | Далангийн өндөр, м | Урт, км | ГША-ын тоо хэмжээ, м3 | Чулуун бэхэлгээний материалын тоо хэмжээ, м3 |
|---|---------------------|--------------------|---------|-----------------------|--|
| 1 | ПК30+200 – ПК31+500 | 1.8м | 1.5км | 27000 | 1673 |

d) Давуулах далан төлөвлөх

Төлөвлөж буй трассын ПК30+200 - ПК31+100 хэсэгт үерийн өргөн жалгатай хэсэгт давуулах далан төлөвлөх хувилбар авч үзлээ. Энэ тохиолдолд 2 цэг дээр (ПК30+200 болон ПК31+000) давуулах далангаар үерийн усыг зам дээгүүр өнгөрүүлэх боломжтой юм.



ПК30+200 дээрх давуулах далан L= 65м
 ПК31+000 дээрх давуулах далан L= 60м
 Давуулах далангийн өндөр

Хийц:

- Бетон хавтан h=18 см
- Чулуун суурь h=20 см


Зураг 24. Давуулах далан байрлуулах хэсэг

Трассын ПК30+200 - ПК31+100 хэсгийн давуулах далангийн байрлал

Хүснэгт 41.

| № | Байрлал | жалганы төрөл | Далангийн урт | Хийц |
|------|----------|---------------|---------------|--|
| 1 | ПК30+200 | Үерийн жалга | 65м | - Бетон хавтан h=18 см - Чулуун суурь h=20 см |
| 2 | ПК31+000 | Үерийн жалга | 60м | - Бетон хавтан h=18 см - Чулуун суурь h=20 см |
| Нийт | | | 125м | - |

Давуулах далангийн хийц



Зураг 25. Давуулах далан

Одоо байгаа жалга дээр тавих хиймэл байгууламжийн геометр хэмжээс 6м х 2м жижиг гүүр

Хүснэгт 42.

| Ажлын нэр | Х/н | Геометр үзүүлэлт |
|--|----------------|------------------|
| Өргөн | м | 6 |
| Өндөр | м | 2 |
| Хөндлөн огтлолын талбай | м ² | 12 |
| Нойтон хэсгийн хөндлөн огтлолын талбай 70% | м ² | 9.6 |
| Нойтон хэсгийн периметр | м | 15.2 |
| Шуудууны одоо байгаа дагуу налуу | % | 0.5% |
| Гадаргуугаас хамаарсан коэффициент | | n=0.015 |
| Ус урсах гадаргуу | | Чулуун бэхэлгээ |

Хүснэгт 43.

Одоо байгаа жалган дээр тавих хиймэл байгууламжийн геометр хэмжээс 2м х 2м дөрвөлжин 3 ш хоолой

| Ажлын нэр | Х/н | Геометр үзүүлэлт |
|--|----------------|------------------|
| Өргөн | м | 6 |
| Өндөр | м | 2 |
| Хөндлөн огтлолын талбай | м ² | 12 |
| Нойтон хэсгийн хөндлөн огтлолын талбай 80% | м ² | 9.6 |
| Нойтон хэсгийн периметр | м | 15.2 |
| Шуудуун одоо байгаа дагуу налуу | % | 0.5% |
| Гадаргуугаас хамаарсан коэффициент | | n=0.013 |
| Ус урсах гадаргуу | | Бетон |

Одоо байгаа жалга дээр тооцоогоор гарсан $Q_{3\%}=32.5$ м³/сек усыг нэвтрүүлж чадах хиймэл байгууламжуудын харьцуулалт:

| Төлөвлөж буй хиймэл байгууламж | Усны өндөр /м/ | A | P | R | R ^{2/3} | n | I ^{1/2} | V | Qd | Тайлбар |
|--------------------------------|----------------|-----|------|-------|------------------|-------|------------------|-----|--------|--|
| (2x2)*3 Хоолой | 1.6 | 9.6 | 15.2 | 0.632 | 0.736 | 76.92 | 0.07 | 4.0 | 38.45 | $Q_{3\%}=32.5 < 38.4$ м ³ /сек |
| 6 х 2 Жижиг гүүр | 1.6 | 9.6 | 15.2 | 0.632 | 0.736 | 66.67 | 0.07 | 3.5 | 33.323 | $Q_{3\%}=32.5 < 33.3$ м ³ /сек |

Замын ПК30+200 - ПК31+100 хэсгийн шийдлүүдийн төсөвт өртөгийн харьцуулалт:

Хүснэгт 44.

| № | Шийдэл | Төсөвт өртөг |
|---|------------------------------|--------------|
| 1 | 2 гүүр / L=6м/ | 558,849,526 |
| 2 | 2 цэгт 2 хос 2х2 хоолой | 248,926,236 |
| 3 | Давуулах далан / L=125м/ | 267,532,476 |
| 4 | Бэхэлгээтэй далан / L=1.5км/ | 400,473,494 |

Харьцуулалтаар хоолой байрлуулах хувилбар харьцангуй өртөг багатай гарч байна. Энэ хэсгийн ажлын тоо хэмжээ, төсөвт өртөгийн хавсралтаас үзнэ үү.

4.9. Хучилтын хийцийн хувилбарууд

Хучилтын тооцооны стандарт: Хучилтын төлөвлөлтөнд Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016 норм дүрмийг баримтлан, ОХУ-ын ОДН 218.046-01 Уян хучилт төсөллөх норм дүрмийн аргачлал ашиглалаа.

Тооцооны өгөгдөл: Ул хөрсний төрөл - элсэнцэр, чийгшлийн I зэрэг буюу харьцангуй чийг 0,65W_T. Хөдөлгөөний эрчмийн өсөлт – 7,5%, Тооцоот ачаалал 100кН, нэгж даралт 0,6мПа, дугуйн мөрний диаметр-37см, тооцоот ачаалал бүхий хөдөлгөөний эрчим – 29 маш/хоног, нийт - 221367 тооцоот ачаалал.

Тооцоот ачаалал

Хүснэгт 45.

| он | Зорчигч тээврийн хөдөлгөөн | Ачаа тээврийн хөдөлгөөн | Хоногийн дундаж хөдөлгөөний эрчим | Тооцоот ачаалалд шилжүүлсэн эрчим, маш/хоног | Тооцоот ачаалалд шилжүүлсэн эрчим, маш/жил |
|------|----------------------------|-------------------------|-----------------------------------|--|--|
| 2017 | 27 | 5 | 32 | 8 | 2811 |
| 2018 | 29 | 5 | 34 | 8 | 2994 |
| 2019 | 31 | 6 | 37 | 9 | 3189 |
| 2020 | 67 | 9 | 76 | 16 | 5709 |
| 2021 | 72 | 9 | 82 | 17 | 6088 |
| 2022 | 78 | 10 | 88 | 18 | 6493 |
| 2023 | 83 | 11 | 94 | 19 | 6925 |
| 2024 | 90 | 11 | 101 | 20 | 7386 |
| 2025 | 96 | 12 | 108 | 22 | 7878 |
| 2026 | 104 | 13 | 116 | 23 | 8404 |
| 2027 | 111 | 13 | 125 | 25 | 8965 |
| 2028 | 119 | 14 | 133 | 26 | 9543 |
| 2029 | 127 | 15 | 143 | 28 | 10159 |
| 2030 | 136 | 16 | 152 | 30 | 10815 |
| 2031 | 146 | 17 | 163 | 32 | 11514 |
| 2032 | 155 | 18 | 173 | 33 | 12205 |
| 2033 | 164 | 19 | 183 | 35 | 12937 |
| 2034 | 174 | 20 | 194 | 37 | 13644 |
| 2035 | 184 | 21 | 205 | 39 | 14390 |
| 2036 | 193 | 22 | 215 | 41 | 15109 |
| 2037 | 203 | 23 | 226 | 43 | 15864 |
| 2038 | 213 | 24 | 238 | 46 | 16658 |
| 2039 | 224 | 26 | 249 | 48 | 17491 |
| | | | | Хоногийн дундаж 29 | Нийт 221,367 |

Тооцоот хөдөлгөөний эрчмээр тооцон бат бэхийн коэффициент $K=0.95$, найдваржилтын коэффициент $K_H=0.95$, хөнгөвчилсэн төрлийн хучилт төлөвлөх боломжтой. Хучилтын шаардлагдах бат бэх $E_{tr}=152\text{МПа}$. Энэ шаардлагыг хангах хучилтын хувилбарыг тооцон харьцуулалт хийлээ.

Хүснэгт 46.

Хучилтын хувилбар 1.

| № | Хучилтын үе | Бат бэхийн модуль, мПа | | | Үеийн зузаан, см | h/D | E2/E1 | E _{общ} , мПа |
|---|---|------------------------|-------------|--------------------|------------------|------|-------|------------------------|
| | | Харимхайн хотойлгонд | Гулзайлтанд | Шилжис-хийлтэнд | | | | |
| 1 | Харлуулсан дайрган үе (БНД90/130 маркийн битумээр боловсруулсан, 10-20мм буталсан чулуун хольц) | 1000 | 1200 | 450 | 5 | 0.14 | 0.12 | 152.5 |
| 2 | Хайрган үе (40мм ширхэглэлтэй дайрга, хайрган хольц) | 200 | 200 | 200 | 30 | 0.81 | 0.33 | 120 |
| 3 | Далангийн хөрс: Элсэнцэр хөрс, (0.65Wт харьцангуй чийгтэй) | 65 | 65 | φ=35 c=0.013мПа | | | | |

Хүснэгт 47.

Хучилтын хувилбар 2.

| № | Хучилтын үе | Бат бэхийн модуль, мПа | | | Үеийн зузаан, см | h/D | E2/E1 | E _{общ} , мПа |
|---|--|------------------------|-------------|--------------------|------------------|------|-------|------------------------|
| | | Харимхайн хотойлгонд | Гулзайлтанд | Шилжис-хийлтэнд | | | | |
| 1 | Давхар гадаргуун боловсруулалт | | | | | | | |
| 2 | Цементээр бэхжүүлсэн хөрс (4-6%-ийн цементээр бэхжүүлсэн хөрс) | 680 | 680 | 650 | 18 | 0.49 | 0.11 | 156.4 |
| 3 | Элс хайрган хольц | 120 | 120 | 120 | 20 | 0.54 | 0.54 | 72 |
| 4 | Далангийн хөрс: Элсэнцэр хөрс, (0.65Wт харьцангуй чийгтэй) | 65 | 65 | φ=35 c=0.013мПа | | | | |

Хучилтын харьцуулалт

Хучилтын дээрх хоёр хувилбарын харьцуулалтыг барилгын ажлын зардал, засвар арчлалтын ажлын зардлаар харьцуулж тооцлоо.

Хучилтын 1-р хувилбар буюу харлуулсан дайрган хучилттай хувилбарын барилгын ажлын төсөвт өртөг нь 186,990,884 төг, хучилтын хоёрдугаар хувилбарын төсөвт өртөг 139,402,134төг болж байна.

ТӨСӨВТ ӨРТГИЙН ТОВЧОО

| № | Зардлын нэр | Бүгд өртөг /төгрөг/ |
|----|---|---------------------|
| 1 | Ажилчдын цалин | 1 113 297 |
| 2 | Тээвэр, машин ашиглалтын цалин | 2 381 098 |
| 3 | Ажилчдын нэмэгдэл цалин | 527 654 |
| 4 | Талбайн ИТА-гийн цалин | 422 757 |
| 5 | Алслалын нэмэгдэл цалин | 2 350 291 |
| 6 | НИЙТ ЦАЛИН | 6 795 096 |
| 7 | Нийгмийн даатгалын шимтгэл | 883 362 |
| 8 | Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт | 7 807 926 |
| 9 | Материал | 123 215 221 |
| 10 | Тээвэр | 17 414 340 |
| 11 | Багаж хэрэгсэлийн элэгдэл | 42 384 |
| 12 | Ажлын хувцасны элэгдэл | 258 351 |
| 13 | Түр барилгын элэгдэл | 0 |
| 14 | Нүүлгэн шилжүүлэх зардал | 0 |
| 15 | ШУУД ЗАРДЛЫН ДҮН | 156 416 681 |
| 16 | Удирдлагын зардал 63.5% | 2 822 451 |
| 17 | Ашиг 71.8% | 3 191 370 |
| 18 | Ажиллагсадын даатгал | 54 361 |
| 19 | Машин механизм, тоног төхөөрөмжийн даатгал | 0 |
| 20 | Барилга, угсралтын ажлын даатгал | 625 667 |
| 21 | Ажиллагсдын хээрийн нэмэгдэл | 717 685 |
| 22 | БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ЗАРДЛЫН ДҮН | 163 828 214 |
| 23 | Захиалагчийн хяналтын зардал 2% | 3 208 393 |
| 24 | Магадлашгүй ажил | 3 276 564 |
| 25 | НӨАТ 10% | 16 382 821 |
| 26 | Норм, нормативын сан 0.18% | 294 891 |
| 27 | Төхник ашиглалтын түвшин тогтоох зардал | 0 |
| 28 | ТӨСӨВТ ӨРТГИЙН ДҮН | 186 990 884 |

ТӨСӨВТ ӨРТГИЙН ТОВЧОО

| № | Зардлын нэр | Бүгд өртөг /төгрөг/ |
|-----------|---|---------------------|
| 1 | Ажилчдын цалин | 1 026 139 |
| 2 | Тээвэр, машин ашиглалтын цалин | 4 393 966 |
| 3 | Ажилчдын нэмэгдэл цалин | 818 436 |
| 4 | Талбайн ИТА-гийн цалин | 422 757 |
| 5 | Алслалын нэмэгдэл цалин | 3 505 717 |
| 6 | НИЙТ ЦАЛИН | 10 167 015 |
| 7 | Нийгмийн даатгалын шимтгэл | 1 321 712 |
| 8 | Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт | 6 641 598 |
| 9 | Материал | 52 182 426 |
| 10 | Тээвэр | 41 561 614 |
| 11 | Багаж хэрэгсэлийн элэгдэл | 53 144 |
| 12 | Ажлын хувцасны элэгдэл | 32 843 |
| 13 | Түр барилгын элэгдэл | 0 |
| 14 | Нүүлгэн шилжүүлэх зардал | 0 |
| 15 | ШУУД ЗАРДЛЫН ДҮН | 111 960 352 |
| 16 | Удирдлагын зардал 63.5% | 4 229 924 |
| 17 | Ашиг 71.8% | 4 782 812 |
| 18 | Ажиллагсадын даатгал | 81 336 |
| 19 | Машин механизм, тоног төхөөрөмжийн даатгал | 0 |
| 20 | Барилга, угсралтын ажлын даатгал | 447 841 |
| 21 | Ажиллагсдын хээрийн нэмэгдэл | 669 789 |
| 22 | БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ЗАРДЛЫН ДҮН | 122 172 055 |
| 23 | Захиалагчийн хяналтын зардал 2% | 2 349 523 |
| 24 | Магадлашгүй ажил | 2 443 441 |
| 25 | НӨАТ 10% | 12 217 205 |
| 26 | Норм, нормативын сан 0.18% | 219 910 |
| 27 | Техник ашиглалтын түвшин тогтоох зардал | 0 |
| 28 | ТӨСӨВТ ӨРТГИЙН ДҮН | 139 402 134 |

Ашиглалтын үеийн засвар арчлалтын зардлыг харлуулсан дайрган хучилтанд 5 жил тутамд нэг удаа ээлжит засвар, давхар гадаргуун боловсруулалт бүхий хучилтанд 3 жил тутамд 1 удаа ээлжит засвар хийхээр тооцвол:

Хүснэгт 50.

| № | Засвар арчлалтын зардал, мян.төг | | № | Засвар арчлалтын зардал, мян.төг | |
|----|----------------------------------|--|------|----------------------------------|--|
| | Хувилбар 1 | Хувилбар 2 | | Хувилбар 1 | Хувилбар 2 |
| | Харлуулсан дайрган хучилт | Давхар гадар.боловср бүхий цементээр бэхжүүлсэн хучилт | | Харлуулсан дайрган хучилт | Давхар гадар.боловср бүхий цементээр бэхжүүлсэн хучилт |
| 1 | 9,236 | 9,236 | 11 | 9,236 | 9,236 |
| 2 | 9,236 | 9,236 | 12 | 9,236 | 55,011 |
| 3 | 9,236 | 55,011 | 13 | 9,236 | 9,236 |
| 4 | 9,236 | 9,236 | 14 | 9,236 | 9,236 |
| 5 | 55,011 | 9,236 | 15 | 55,011 | 55,011 |
| 6 | 9,236 | 55,011 | 16 | 9,236 | 9,236 |
| 7 | 9,236 | 9,236 | 17 | 9,236 | 9,236 |
| 8 | 9,236 | 9,236 | 18 | 9,236 | 55,011 |
| 9 | 9,236 | 55,011 | 19 | 9,236 | 9,236 |
| 10 | 55,011 | 9,236 | 20 | 9,236 | 9,236 |
| | | | Нийт | 322,035 | 459,360 |

Засвар арчлалтын зардлын хувьд давхар гадаргуун боловсруулалт бүхий хучилтын ашиглалтын зардал өндөр гарч байна.

Хүснэгт 51.

| Замын хувилбарын харьцуулалт | | |
|--|---------------------------|--|
| Үзүүлэлт | 1-р хувилбар | 2-р хувилбар |
| | Харлуулсан дайрган хучилт | Давхар гадар.боловср бүхий цементээр бэхжүүлсэн хучилт |
| 1км замын ажлын төсөвт өртөг, төг | 186,990,884 | 139,402,134 |
| Зөвлөхийн зардал, төг | 9,349,544 | 6,970,107 |
| 1км замын засвар арчлалтын зардал, төг | 322,035 | 459,360 |
| Нийт | 196,662,463 | 146,831,601 |

Харьцуулалтаас үзэхэд хучилтын 2-р хувилбар буюу давхар гадаргуун боловсруулалт бүхий цементээр бэхжүүлсэн хучилтын төсөвт өртөг бага байна.

4.10. Хувилбаруудын ажлын тоо хэмжээ

Ховд аймгийн Чандмань сум хүртэлх замын барилгын ажлын тоо хэмжээг трассын хувилбар тус бүрээр болон хучилтын хийцийн хувилбар, хүндрэлтэй газрын шийдэл тус бүрээр тодорхойллоо.

Трассын 1-р хувилбарын хувьд барилгын ажлын тоо хэмжээ тодорхойлон доорх хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 52.

Трассын 1-р хувилбарын барилгын ажлын төсөв, L= 55.052 км

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

| Шифр | Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
|----------|--|------|------------|
| 25-01-11 | Конторын барилга барих /6м*4м*2.5м/ | 1ш | 1 |
| 25-01-03 | Усны нөөцийн сав байрлуулах/10тн/ | 1ш | 1 |
| 25-01-12 | Харуулын байр барих /2м*2м*2м/ | 1ш | 1 |
| 25-01-01 | Гэр барих | 1гэр | 10 |
| 25-01-04 | Бие засах газар байгуулах /2м*1м/ | 1ш | 1 |
| 25-01-08 | Шатахууны агуулах сав байрлуулах /20т/ | 1ш | 1 |
| 25-01-12 | Харуулын байр барих /2м*2м*2м/ | 1ш | 1 |

ЗАМЫН ЧИГ СЭРГЭЭХ

| Шифр | Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
|----------|----------------------|-----|------------|
| 25-02-01 | Замын чигийг сэргээх | 1км | 55.052 |

ТАЛБАИН ЦЭВЭРЛЭГЭЭ

| Шифр | Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
|----------|---------------------------------|-----|------------|
| 25-03-01 | Бульдозероор ургамлын үе хуулах | 1м3 | 132,125 |
| 25-20-01 | Ул хөрсийг нягтруулах | 1м2 | 660624 |

ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ

| Шифр | Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
|----------|--|-----|------------|
| 25-04-16 | Шороон ордоос зөөврөөр далан байгуулах | 1м3 | 462,437 |
| 25-04-14 | Түр зам байгуулах | 1км | 52 |
| 25-13-09 | Хадан хөрсийг тэсэлж суллах | 1м3 | 570 |
| 25-03-01 | Карьерын хөрс хуулалт | 1м3 | 10,440 |
| 25-04-49 | Автогрейдер эцсийн нарийн тэгшилгээ хийх | 1м2 | 495,468 |

| | | | |
|----------|---|-----|---------|
| 25-04-05 | Экскаватораар ухмал байгуулж далан байгуулах | 1м3 | 396,374 |
| 25-04-69 | Тохиромжгүй материалыг ухаж зайлуулах | 1м3 | 55,500 |
| 25-07-09 | Хажуугийн шуудуу, ухмалын өөрийн шуудууг автогрейдерээр байгуулах | 1м3 | 13,763 |
| 25-07-05 | Далан ба ухмалын хажуу налууг экскаватораар тэгшлэх /хажуу налуун урт 5м-ээс урт/ | 1м2 | 29,000 |

СУУРЬ ХУЧИЛТЫН АЖИЛ

| Шифр | Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
|----------|---|-----|------------|
| 25-05-09 | Хайрган суурь байгуулах | 1м3 | 99093.6 |
| 25-06-15 | Шингэн түрхлэг хийх | 1м2 | 195434.6 |
| 25-06-01 | Битумээр боловсруулсан дайрган үе байгуулах | 1м3 | 16,516 |
| 25-06-12 | Хайрган хөвөө байгуулах | 1м3 | 56979 |

ЗАМЫН ТОНОГЛОЛ

| Шифр | Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
|----------|--|-----|------------|
| 25-08-01 | Замын тэмдэг ба километрийн тэмдэг суурьлуулах | 1ш | 55 |
| 25-08-02 | Дохионы шон суулгах | 1ш | 232 |

ТӨМӨРБЕТОН ХООЛОЙН БАРИЛГА 1.0МХ1 /54ш/

| Шифр | Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
|----------|--|-----|------------|
| 28-18-01 | Хоолойн суурийн ухмал | 1м3 | 4336.2 |
| 28-18-02 | Хоолойн ул суурь нягтруулах | 1м2 | 2743.2 |
| 28-18-04 | Бетон суурь байгуулах | 1м3 | 236.52 |
| 28-05-06 | Бетоноор тэгшилгээний үе байгуулах | 1м3 | 316.98 |
| 28-18-05 | Хоолойн угсармал хэсэглэл суурин дээр байрлуулах | 1м3 | 326.16 |
| 28-18-07 | Хоолойн тулц бетон цутгах | 1м3 | 312.66 |
| 28-05-06 | Хоолойн бетон шал, тулц хана цутгах | 1м3 | 778.14 |
| 28-18-09 | Хоолойн толгойны хэсэглэл цутгах | 1м3 | 303.48 |
| 28-18-08 | Хоолойн далбааны хэсэглэл цутгах | 1м3 | 90.72 |
| 28-18-10 | Түрхмэл ус тусгаарлагч хийх | 1м2 | 607.5 |
| 28-18-13 | Амсарын чулуун бэхэлгээ хийх | 1м2 | 777.6 |
| 28-18-15 | Далангийн хажуу налууг чулуугаар бэхлэх | 1м2 | 391.5 |
| 28-18-16 | Буцаан дүүргэлт хийх | 1м3 | 2312.28 |

ТӨМӨРБЕТОН ХООЛОЙН БАРИЛГА 1.0МХ2 /4/

| Шифр | Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
|----------|--|-----|------------|
| 28-18-01 | Хоолойн суурийн ухмал | 1м3 | 200 |
| 28-18-02 | Хоолойн ул суурь нягтруулах | 1м2 | 480 |
| 28-18-04 | Бетон суурь байгуулах | 1м3 | 33.6 |
| 28-05-06 | Бетоноор тэгшилгээний үе байгуулах | 1м3 | 29.16 |
| 28-18-05 | Хоолойн угсармал хэсэглэл суурин дээр байрлуулах | 1м3 | 25.08 |
| 28-18-07 | Хоолойн тулц бетон цутгах | 1м3 | 28.08 |
| 28-05-06 | Хоолойн бетон шал, тулц хана цутгах | 1м3 | 81.8 |
| 28-18-09 | Хоолойн толгойны хэсэглэл цутгах | 1м3 | 17.2 |
| 28-18-08 | Хоолойн далбааны хэсэглэл цутгах | 1м3 | 18.72 |
| 28-18-10 | Түрхмэл ус тусгаарлагч хийх | 1м2 | 320 |
| 28-18-13 | Амсарын чулуун бэхэлгээ хийх | 1м2 | 32.32 |
| 28-18-15 | Далангийн хажуу налуу члуугаар бэхлэх | 1м2 | 36.6 |
| 28-18-16 | Буцаан дүүргэлт хийх | 1м3 | 413.6 |

ЗАВОД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ УГСРАХ

| Шифр | Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
|----------|--|-----------|------------|
| 25-16-07 | Бетон цехийн угсралт /50 м3/цагийн хүчин чадалтай/ | 1 иж бүрд | 1 |
| 25-16-01 | Чулуу бутлан ангилах төхөөрөмжийн угсралт (60тн/цагийн хүчин чадалтай) | 1 иж бүрд | 1 |
| 25-16-10 | Асфальтбетон заводын угсралт | 1 иж бүрд | 1 |

Трассын 2-р хувилбарын хувьд барилгын ажлын тоо хэмжээ тодорхойлон доорх хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 53.

Трассын 2-р хувилбарын барилгын ажлын төсөв, L= 57.305 км

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

| Шифр | Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
|----------|--|------|------------|
| 25-01-11 | Конторын барилга барих /6м*4м*2.5м/ | 1ш | 1 |
| 25-01-03 | Усны нөөцийн сав байрлуулах/10тн/ | 1ш | 1 |
| 25-01-12 | Харуулын байр барих /2м*2м*2м/ | 1ш | 1 |
| 25-01-01 | Гэр барих | 1гэр | 10 |
| 25-01-04 | Бие засах газар байгуулах /2м*1м/ | 1ш | 1 |
| 25-01-08 | Шатахууны агуулах сав байрлуулах /20т/ | 1ш | 1 |
| 25-01-12 | Харуулын байр барих /2м*2м*2м/ | 1ш | 1 |

ЗАМЫН ЧИГ СЭРГЭЭХ

| Шифр | Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
|----------|----------------------|-----|------------|
| 25-02-01 | Замын чигийг сэргээх | 1км | 57.305 |

ТАЛБАИН ЦЭВЭРЛЭГЭЭ

| Шифр | Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
|----------|---------------------------------|-----|------------|
| 25-03-01 | Бульдозероор ургамлын үе хуулах | 1м3 | 137,532 |
| 25-20-01 | Ул хөрсийг нягтруулах | 1м2 | 687660 |

ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ

| Шифр | Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
|----------|--|-----|------------|
| 25-04-16 | Шороон ордоос зөөврөөр даланбайгуулах | 1м3 | 481,362 |
| 25-04-14 | Түр зам байгуулах | 1км | 55 |
| 25-13-09 | Хадан хөрсийг тэсэлжсулгах | 1м3 | 570 |
| 25-03-01 | Карьерын хөрс хуулалт | 1м3 | 10,440 |
| 25-04-49 | Автогрейдер эцсийн нарийн тэгшилгээ хийх | 1м2 | 515,745 |
| 25-04-05 | Экскаватораар ухмал байгуулж далан байгуулах | 1м3 | 412,596 |
| 25-04-69 | Тохиромжгүй материалыг ухаж зайлуулах | 1м3 | 55,500 |

| | | | |
|----------|---|-----|--------|
| 25-07-09 | Хажуугийн шуудуу, ухмалын өөрийн шуудууг автогрейдерээр байгуулах | 1м3 | 14,326 |
| 25-07-05 | Далан ба ухмалын хажуу налууг экскаватораар тэгшлэх /хажуу налуун урт 5м-ээс урт/ | 1м2 | 29,000 |

СУУРЬ ХУЧИЛТЫН АЖИЛ

| Шифр | Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
|----------|---|-----|------------|
| 25-05-09 | Хайрган суурь байгуулах | 1м3 | 103149 |
| 25-06-15 | Шингэн түрхлэг хийх | 1м2 | 203432.75 |
| 25-06-01 | Битумээр боловсруулсан дайрган үе байгуулах | 1м3 | 17,192 |
| 25-06-12 | Хайрган хөвөө байгуулах | 1м3 | 59311 |

ЗАМЫН ТОНОГЛОЛ

| Шифр | Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
|----------|--|-----|------------|
| 25-08-01 | Замын тэмдэг ба километрийн тэмдэг суурьлуулах | 1ш | 54 |
| 25-08-02 | Дохионы шон суулгах | 1ш | 240 |

ТӨМӨРБЕТОН ХООЛОЙН БАРИЛГА 1.0МХ1 /56ш/

| Шифр | Ажлын нэр | Х/Н | Тоо хэмжээ |
|----------|--|-----|------------|
| 28-18-01 | Хоолойн суурийн ухмал | 1м3 | 4496.8 |
| 28-18-02 | Хоолойн ул суурь нягтруулах | 1м2 | 2844.8 |
| 28-18-04 | Бетон суурь байгуулах | 1м3 | 245.28 |
Замын төсөл хэрэгжснээр эдгээр малчин ард иргэд малын бүтээгдэхүүнээ борлуулах, худалдаа үйлчилгээ, эрүүл мэндийн төвлөрсөн үйлчилгээнд цаг алдалгүй хүрэх боломж нээгдэхээс гадна зам харилцаа сайжирснаар Жаргалантын хүрхэрээг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх, Бумбатын рашааныг түшиглэн амралт сувилал хөгжүүлэх боломж бий болно.

Чандмань суманд үйл ажиллагаа явуулж буй 17 хоршоолол, 9 дэлгүүр, 1 зочид буудал, 1 шатахуун түгээх станц, Хаан банкны салбар, ноос боловсруулах 1 инкубатор төв, 12 жилийн дунд сургууль, 1 цэцэрлэг зэрэг байгууллагуудын үйл ажиллагаа сайжирч, ашиг орлого нэмэгдэх, үйлчилгээний чанар дээшилж нийгмийн бас нэг чухал нөлөө үзүүлэх юм. Жижиглэн худалдааны бизнес эрхлэгчид худалдаагаа өргөжүүлэх, барааныхаа нэр төрлийг олшруулах, бусад суманд хүрч үйлчлэх боломжтой болно.

9.2. Төслийн нийгмийн өгөөж, үр дагавар

Уг төсөл хэрэгжсэнээр бүс нутгийн иргэдийн тээвэр ашиглалтын зардал, зорчих цаг хугацаа багасаж, тав тухтай, найдвартай зорчих боломжтой болно. Энэ хүчин зүйлс Чандмань сум болон ойролцоох Зэрэг, Манхан, Говь-Алтайн Хөхморьт, Баян-Уул сумдын эдийн засгийн чадавх дээшлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны салбар өргөжих тэлснээр эдийн засгийн хөгжлийг идэвхжүүлэх ач холбогдолтой.

Төсөл хэрэгжүүлэх хугацаанд нутгийн иргэд түр хугацаагаар хөдөлмөр эрхлэх боломж бүрдэнэ. Цаашилбал төсөл хэрэгжсэнээр тээврийн үр ашгийг өсгөж, ачаа, зорчигч тээврийн эргэлт нэмэгдэж, хугацааны хэмнэлт бий болох, тээврийн хэрэгслийн туулах зайг уртасган, улмаар орлогын түвшин болон ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулах, хүний хөгжлийн талаар төр засгаас хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийг дэмжихэд шаардлагатай хөрөнгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэх зэргээр ядуурлыг бууруулахад шууд ба шууд бус нөлөө үзүүлнэ.

Төсөл хэрэгжих шатанд бүс нутгийн иргэдийг түр ажлын байраар хангах, ялангуяа сумдын ажилгүй, ядуу иргэдийг түлхүү авч ажиллуулна. Мөн төслийн багийн худалдаа ахуйн үйлчилгээ болон хоол хүнс, мөн төслийн үйл ажиллагаанд хэрэглэх шатахуун, тослох материал, засвар үйлчилгээг бүс нутгаас авч сумдын бизнесийг дэмжинэ.

Төсөл хэрэгжиж дуусснаар тээвэрлэлт найдвартай, хурдан шуурхай болж, аяллын цаг богиносгох төдийгүй зорчигчдын тав тух дээшилнэ. Тээврийн хэрэгслийн элэгдэл, эвдрэл багасаж, тээврийн хэрэгсэл эзэмшигчдэд эдийн засгийн хэмнэл гарна. Хүн амын зорчих хөдөлгөөн нэмэгдэх нь бүс, нутаг орны хөгжилд эерэгээр нөлөөлнө. Бэлчээрийн талбай талхлагдах байдал зогсож, бэлчээрийн хомсдол багасснаар мал аж ахуйд эергээр нөлөөлнө.

Замын дагуу өвөлждөг, намарждаг малчдын худалдаа үйлчилгээ сайжирна. Зам сайжирснаар малчдын хүүхдүүд сургууль цэцэрлэгт хамрагдах боломж нэмэгдэж, улмаар сумын нийгмийн болон боловсролын түвшин дээшилнэ. Замын харилцаа холбоо сайжруулснаар боловсролын болон эрүүл мэндийн салбарын боловсон хүчний хүртээмж нэмэгдэнэ. Сумдын удирдлага засгийн газрын хөтөлбөр үйлчилгээг хүргэх, төрийн бус байгууллагуудын хөтөлбөрийн ханган нийлүүлэлт ч ихэснэ. Төслийн эдгээр эерэг үр нөлөөний үр дүнд хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөн буурна.

Замын төсөл хэрэгжсэнээр замын трассын дагуух сумдын эдийн засгийн болон нийгмийн түвшин сайжирч, сумд хөгжил эрчимжинэ.

Бүс нутгийн иргэдэд төсөл хэрэгжсэнээр тэдний аж байдалд нөлөөлж, сөрөг үр дагавар гарч болзошгүйг анхаарах шаардлагатайг онцолж байна. Үүнд: зам барилгыг ажлын явцад байгаль орчинд хохирол учруулах; усны эх үүсвэрт нөлөөлөх; замын хөдөлгөөнд малын аюулгүй байдлыг хангах, зорчих хөдөлгөөн нэмэгдсэнээр малчдын тайван байдал алдагдах, малын хулгай нэмэгдэх; замын байдал сайжирснаар авто машины хурд нэмэгдэн улмаар авар ослын хэмжээ өсөх гэх мэт. Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд төслийн бүх үе шатанд сонирхлын бүлгүүдийг өргөнөөр оролцуулах шаардлагатай юм. Энэ нь уг төслийн сөрөг нөлөөллөөс зайлсхийх гол үндэс болно.

Замын нарийвчилсан инженерийн зураг төслийг бүс нутгийн төлөөлөлтэй зөвлөлдсөний дагуу боловсруулна. Замын хажуугийн зогсоол, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, туслах зам зэргийг техникийн болон нийгмийн анхаарвал зохих асуудалд тусгаж байгуулна.

Төслийн хэрэгжилтийн явцад учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад дараах арга хэмжээг авч ажиллахыг зөвөлж байна.

1. Олон нийттэй зөвлөлдөх, мэдээлэл хүргэх хөтөлбөр боловсруулах, төслийн талаарх мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх.
2. Мал олноор бэлчээрлэдэг газруудад замын тэмдэг байршуулж, малын бэлчээр дэх аюулгүй байдлыг хангах.
3. Төсөл хэрэгжих үе шат бүрд замын хөдөлгөөний байдлын өөрчлөлтийг тусгасан замын хөдөлгөөнийг зохицуулах төлөвлөгөөг нутгийн иргэдтэй зөвлөлдөж боловсруулах, замын хөдөлгөөний өөрчлөлтийн талаар мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх.
4. Усны хомсдолтой газарт замын барилгын материалд шаардагдах усыг шинээр худаг ус гаргаж авах.

10. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Төслийн эдийн засгийн дүн шинжилгээгээр өнөөгийн цэвэр үнэ цэнэ NPV= 7,292 тэрбум төг (буюу эерэг үр дүнтэй), эдийн засгийн дотоод өгөөжийн хувь IRR нь 4,11% гарч байгаа нь уг төслийг эдийн хувьд хэрэгжүүлэх боломжтой байна. Уг төслийг 2018-2019 онд хэрэгжүүлнэ. Авто замын төслийг хэрэгжүүлснээр Ховд аймгийн Чандмань, Манхан, Зэрэг сумд болон цаашлаад Хар нуур, Дөргөн нуурын ай сав орчмоор нутагладаг ард иргэдийн нийгэм эдийн засгийн хөгжилд ихээхэн эерэг нөлөө үзүүлэх юм.

Трассын хувилбаруудыг дараах үзүүлэлтээр харьцуулж дүгнэв.

Трассын хувилбаруудын байр зүйн болон трассын үндсэн үзүүлэлтийн харьцуулалт:

Хүснэгт 1.

| № | Трассын харьцуулалт | х/н | 1-р хувилбар | 2-р хувилбар |
|------|---|-----|----------------|----------------|
| 1 | Трассын урт | км | 55,052 | 57,305 |
| 2 | Эргэлтийн тоо | ш | 21 | 22 |
| 3 | Эргэлтийн хамгийн бага радиус | м | 2000 | 2000 |
| 4 | Дагуу налуу хэмжээ | % | 42,7 | 42,7 |
| 5 | Хамгийн их дагуу налуутай хэсгийн үргэлжлэх урт | м | 3300 | 3300 |
| 6 | Хоолойн тоо | ш | 58 | 60 |
| 7 | Нэг зурвасын өргөн | м | 3,0 | 3,0 |
| 8 | Зурвасын тоо | ш | 2 | 2 |
| 9 | Зорчих хэсгийн өргөн | м | 6,0 | 6,0 |
| 10 | Хөвөөний өргөн | м | 1,5 | 1,5 |
| 12 | Гүүрийн тоо, урт | ш | 3 (1; 2; 3) | 3 (1; 2; 3) |
| 13 | Гүүрийн урт | у/м | 48 (24; 18; 6) | 48 (24; 18; 6) |
| 14 | Геологи-гидрологийн хүндрэлтэй хэсгийн үргэлжлэх урт: | | | |
| 14.1 | Үүшийн голын хөндийгөөр явах хэсгийн урт | м | 2000 | 2000 |
| 14.2 | Тооройн элс | м | 5200 | 5200 |
| 14.3 | Нарийны хоолойн үерийн хуурай сайртай хэсгээр өнгөрөх урт | м | 2100 | 2100 |
| 15 | Хучилтын хийцийн төрөл /1км авто замын хучилтын төсөвт өртөг/ | | | |

| | | | | |
|-------------------------------|--|-----|----------------|----------------|
| 15.1 | Давхар гадаргуун боловсруулалт бүхий СТВ | Төг | 139 402 134 | |
| 15.2 | Харлуулсан дайрган хучилт | Төг | 186 990 884 | |
| 15.3 | Шинжлэх Ухаан Техникийн Зөвлөлийн гишүүдийн санал болгосны дагуу: - “Хэсэгчилсэн асфальтбетон хучилт бүхий хайрган хучилт” | төг | 177 084 639 | |
| 16 | Авто замын төсөвт өртөг /Зөвлөх үйлчилгээний 5% нэмсэн болно./ | | | |
| 16.1 | Давхар гадаргуун боловсруулалт бүхий СТВ | Төг | 18 294 257 050 | 19 003 282 702 |
| 16.2 | Харлуулсан дайрган хучилт | Төг | 22 548 468 402 | 23 431 559 178 |
| 16.3 | Шинжлэх Ухаан Техникийн Зөвлөлийн гишүүдийн санал болгосны дагуу: - “Хэсэгчилсэн асфальтбетон хучилт бүхий хайрган хучилт” | Төг | 21 522 388 472 | 23 123 595 716 |
| Санал болгох трассын хувилбар | | | + | |

ЗӨВЛӨМЖ

Төслийн замын хөрөнгө оруулалтын өнөөгийн цэвэр үнэ цэнийг авч үзвэл тооцоо хийсэн бүх хувилбар эерэг гарч байгаа тул уг төслийг хэрэгжүүлэх боломжтой байна. Дотоод өгөөжийн дотоод хувь харьцангуй өндөр байгаа 1-р хувилбарын хувьд төслийн хөрөнгө оруулалтын өнөөгийн цэвэр үнэ цэнэ NPV= 10 904 699 200 төг, дотоод өгөөжийн хувь IRR= 4,84% болж байна.

Гэхдээ 1-р хувилбарын хучилт нь хөнгөвчилсөн төрлийн хучилт байгаа бөгөөд ийм хучилтын ашиглалтын үеийн засвар арчлалтын зардал асфальтбетон хучилтаас өндөр байдгийг зураг төсөл боловсруулах шатанд анхаарч хучилтын төлөвлөлтийг оновчтой сонгохыг зөвлөж байна.



III. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГАА



11. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГАА

11.1. Байгаль орчны төлөв байдлын судалгаа, үнэлгээ

Төсөл хэрэгжих талбайн байршил

Төлөвлөж буй Ховд-Чандмань чиглэлийн 62 км авто зам Ховд аймгийн Чандмань, Манхан сумын нутаг дэвсгэр дээр тавигдана. Замын трассын ерөнхий чиглэл нь Ховд аймгийн Манхан сумын төвөөс 5 орчим км зайд орших А0304 Ховд-Алтай чиглэлийн авто замын 95-р км-ээс зүүн чигт салж, Өөшийн голын хөндий, Жаргалант хайрхан, Бумбат хайрхан уулын дундуур гарч Чандмань сум хүрнэ.

Уур амьсгалын ерөнхий шинж

Төсөл хэрэгжих Ховд аймгийн Чандмань, Манхан сумд нь баруун талаараа Алтайн уулс, зүүн талаараа Хангайн уулт өндөрлөгөөр хүрээлэгдсэн Их нууруудын хотгорын мужид оршино. Их нууруудын хотгор нь бие биеэсээ нэлээд салангад хэд хэдэн хотгороос тогтох бөгөөд эргэн тойрон уулсаар хүрээлэгдэн орших учир баруун зүгээс ирэх чийглэг агаар энд нэвтрэх нь ховор, харин зүүн урд талаас нээлттэй болохоор говийн хуурай агаар нэвтрэн орж ирэхэд саад болох зүйлгүй. Гадаргын ийм байдлаас болж уур амьсгал нь ерөнхийдөө гандуу, чийг багатай, халуун хуурай, байгалийн байдал цөлөрхөг шинжтэй болсон байна. Хар-ус нуурын орчмын нутаг дэвсгэр нь уур амьсгалын мужлалтаар Их нууруудын хотгорын их хүйтэн, ширүүн өвөлтэй, хэт эх газарлаг мужид багтана.

Агаар орчин, агаарын чанарын төлөв байдал

Төсөл хэрэгжих Ховд аймгийн Манхан, Чандмань сумдад улсын агаарын чанарыг хянах суурин харуул байхгүй бөгөөд төслийн талбайд хамгийн ойр орших нь Ховд аймгийн Ховд хотод байдаг. Нэг удаагийн шинжилгээгээр агаарын чанарыг тодорхойлж үнэлгээ өгөх боломжгүй хэдий ч хээрийн судалгааны ажил болон бусад судалгааны мэдээлэлд үндэслэн төсөл хэрэгжих талбайн агаарын чанарын ерөнхий байдлыг тодорхойлбол төслийн талбай орчмын агаарын чанарын төлөв байдал ноцтой хэмжээнд хүрээгүй буюу агаар орчинд сөрөг нөлөө үзүүлэхүйц хэмжээнд биш байна.

Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал

Төсөл хэрэгжих Чандмань, Манхан сум нь Монгол орны Хөрс-газарзүйн мужлалтаар Говийн их мужийн хотгорын бүсшилийн хэв шинж бүхий Хяргас-Хар нуурын 25-р тойрог болон өндрийн бүсшилийн хэв шинж бүхий Монгол Алтайн 51-р тойрогт (Жаргалант хайрхан, Бумбат хайрхан уулын орчмоор) багтана. Ховд аймгийн Чандмань, Манхан сумын нутгаар ухаа толгод, тал хөндийн хөрснөөс заримдаг цөлийн бор, заримдаг

цөлийн цайвар бор, цайвар хүрэн, уулын хөрснөөс уулын хүрэн, уулын цайвар хүрэн, өндөр уулын хээрийн бүдүүн ялзмагт хөрс тархжээ.

Усан орчны төлөв байдал

*Замын трассын дагуух гадаргын урсцын судалгаа:*Замын трассын дагуу Чандмань сумын төвийн урд талын булгуудаас эх аван урсдаг Жаргалантын урд гол, авто замын трассын эхний хэсэгт байрлах Өөшийн гол, мөн Төгрөгийн гол (Алтайн хойд хажуу руу урсах бөгөөд ширгэдэг гол. Хойд ба Дундцэнхэрийн голуудтай нийлсний дараа Төгрөг нэртэй болдог) зэрэг гадаргын урсацтай.

*Худаг, булгийн судалгаа:*Замын трассын дагуу Өөшийн голын хөндийд байх 5 м гүн, 1.0 л/сек ундаргатай худаг, 6 м гүн, 1.5 л/сек ундаргатай Дуутын худаг, 0.4 л/сек ундаргатай Шар булаг, Шар булагийн ойролцоох 0.14 л/сек ундаргатай булгууд, 0.17 л/сек-ийн ундаргатай Хөтөл усны булаг, 0.5 л/сек ундаргатай Эмгэн булаг, 5 м гүн, 1.5 л/сек ундаргатай Товгорын худаг, 6 м гүн, 0.3 л/сек ундаргатай Таван толгойн худаг, Чандмань сумын урд талд байрлах Урд Жаргалант гол эх авдаг 0.4 5 м гүн, 1.5 л/сек ундаргатай 6 булаг, Сумын хойд талд орших 5 м гүн, 0.25 л/сек ундаргатай Хөндлөнгийн худаг зэрэг усны эхүүсвэрүүд байна.

Чандмань сумын төвд цэвэр усны хэрэгцээг хангадаг 3 худагтай бөгөөд 2002 оны 1 дүгээр сард ашиглалтанд орсон гүний худаг 45.0 м гүнтэй, усны түвшин нь 14.0 м, ундарга нь 17 л/сек, 2008 оны 12 дугаар сард ашиглалтанд орсон худгийн гүн 45.0 м, усны түвшин 16.0 м, ундарга нь 20 л/сек бол 3 дахь худгийн гэрчилгээ олдоогүй тул худгийн мэдээллийг тодруулж чадаагүй болно. Дээрх гүний худаг, булгийн гол тэжээл нь хур, борооны ус бөгөөд хур борооны уснаас тэжээлийнхээ 70-аад хувийг, гүний уснаас 30-аад хувийг авдаг байна. Усны найрлага нь ердийн усны найрлагатай, гидрокарбонат, натри, калийн бүлгийн ус байна.

*Төслийн талбайн цэвдгийн нөхцөл:*Монгол орны цэвдгийн тархалтын (1971 он, 1:1500000 хураангуйлалтай) зургаас авч үзвэл төслийн талбай нь олон жилийн цэвдгийн ховор алаг цоог болон тохиолдлын тархалттай бүслүүрт байрлаж байна.

Төслийн талбайн гидрогеологийн судалгаа: Төсөл хэрэгжих талбайн геологийн судалгаагаар авто замын трассын дагууд хурдас, чулуулгийн шинж, гарал үүсэл, найрлага бүтцийг харгалзан хоёр уст давхарга, ус тодорхой хэмжээгээр агуулсан чулуулгийн тодорхойлсон байна. Үүнд: Гуравдагч-Дөрөвдөгч (Q3-4)-ийн настай, аллюви-пролювийн гаралтай, хурдсанд агуулагдаж байгаа уст давхарга, гуравдагч-Дөрөвдөгч (Q3-4)-ийн настай, делюви-пролюви (dp)-ийн гаралтай, хурдсанд агуулагдаж байгаа уст давхарга болон судалгааны талбайн баруун болон зүүн урд талаар PR-PZ болон PR-

PZ1-2-ийн хурдас тархсан өндөр уул, болон нам өндөрлөгтэй уул, толгод, ухаа, гүвээ үүсгэж тогтсон бөгөөд дээрх төрлийн чулуулаг нь насны хувьд ойролцоо үүсэж бүрэлдсэн нөхцөл, цаг, хугацаа ойролцоо учир нэгтгэн нэг ус агуулгын ан цавын уст давхаргад нэгтгэн үзсэн байна.

Ургамлан бүрхэвчийн төлөв байдал

Төсөл хэрэгжих Ховд аймгийн Чандмань, Манхан сумд нь Ургамал-газарзүйн мужлалаар Их нууруудын хотгорын цөлөрхөг хээрийн тойрогт хамаарна. Их нууруудын хотгорын цөлөрхөг хээрийн тойрогт Монгол-Алтай, Хангай, Тагнын нуруудын хооронд орших эргэн тойрон уул нуруудаар хүрээлэгдсэн Увс, Хяргас, Хар-Ус нууруудын томоохон хотгорууд хамаарна. Тойргийн төв хэсгээр цөлийн, захаараа цөлөрхөг хээрийн элементүүд тааралдана. Энэ тойрогт Зүүнгар-Тураны цөлийн төлөөлөгчид үндсэндээ зонхилох бөгөөд нийт 897 зүйл бүртгэгдэж, зөвхөн энд тархсан 32 зүйл ургамал тархана.

Монгол улсын “Байгалийн ургамлын тухай хууль”-ийн дагуу ургамлын түүний нөөц, нөхөн сэргэх чадварыг нь харгалзан нэн ховор, ховор, элбэг гэж ангилна. Хар-ус нуурын байгалийн цогцолборт газарт 58 овгийн 234 төрөлд хамаарах 457 зүйл ургамал бүртгээд байгаагаас 90 зүйл нь эмийн, 13 зүйл нь Монгол улсын Улаан номонд орсон, 9 зүйл нь үлдэц ба завсрын унаган, ховор 60 зүйл ургамал ургадаг. (С.Мөнхбаяр, Б.Мандах нар, 1999). Монгол улсын 1995 оны Улаан номонд тэмдэглэгдсэн 86 зүйл (Улаан ном, 2013 оныхоор 128 зүйл) ургамлаас 22 зүйл нь тохиолдож байгаагийн 13 зүйл нь нэн ховор, 9 зүйл нь ховор гэсэн статустай байна.

Хар-ус нуурын эргэн тойрны болон нуурын дундах арлын хулсан шугуй, нуурын захын ус, намгийн ургамал бараг судлагдаагүй бөгөөд нууруудын мандлаар Монгол улсын Улаан номонд орсон бяцхан саахуу цэцэг, Монголын унаган ургамал болох цав цагаан бөлбөө ургах ба Жаргалант хайрхан уул нь бүслүүржилт, ургамлын бүрхүүлийн бүтэц, зүйлийн бүрдлээрээ Монгол Алтайгаас эрс ялгагдана. Жаргалант хайрханы нуруунд өндөр уул, уулын хээр, цөлжүү хээр, цөлийн хээр, гэсэн ургамалжилтын бүс, бүслүүр илэрнэ. Энд нэн ховор ургамал ягаан мүүгээ, Монголын улаан номонд орсон ховор ургамал болох алтайн сонгино, ганц цэцэгт алтан зул, вансэмбэрүү, алтан гагнуур, ацан ажигана, монгол чононого, шивүүрт ортууз зэрэг ургамлууд тохиолдоно.

Амьтны аймгийн төлөв байдал Төлөвлөж буй авто замын трассын I, II хувилбар нь Хар-ус нуурын байгалийн цогцолборт газрын зүүн урд хэсгээр дайрч, Жаргалант хайрхан, Бумбат хайрхан уулын дундуур гарах бөгөөд Хар-ус нуураас 40-50 км алслагдана. Төсөл хэрэгжих талбай орчмын амьтны аймгийн онцлогийг Хар-ус нуурын байгалийн цогцолборт газар, Жаргалант хайрхан, Бумбат хайрхан уулын амьтны аймгийн онцлогоор төлөөлүүлэн авав. Хар-ус нуурын байгалийн цогцолборт газарт 54 зүйл хөхтөн, 268 зүйл

шувуу, 4 зүйл загас, 6 зүйл мөлхөгч бүртгэгдсэн байна. Байгалийн цогцолборт газар нь амьтны аймгийн хувьд цөл, хээр, өндөр уулын бүсийн төлөөлөгчдийн төдийгүй ус намгийн шувуудын хувьд хамгийн тохиромжтой амьдрах орчин юм.

Хөхтөн: Хар-ус нуурын байгалийн цогцолборт газарт 54 зүйл хөхтөн тархсан бөгөөд төсөл хэрэгжих талбай орчмын ховор, нэн ховор, хамгаалалтын статус бүхийдараах хөхтөн амьтны зүйлийг авч үзэв.

Цоохор ирвэс /Panthera uncia/

Тархац: Төсөл хэрэгжих талбайн баруун талд орших Хар-ус нуурын байгалийн цогцолборт газрын хэмжээнд Жаргалант хайрхан ууланд 2003 оны судалгаагаар 25 бодгаль, нарийвчилсан судалгаа 2014 онд хийгдэж ойролцоогоор 25-30 гэсэн судалгаа гарсан байна. Уг нарийвчилсан судалгааг хийхдээ Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар Жаргалант хайрхан уулын орчимд нийтдээ 40 ширхэг автомат камер суурилуулж уг камерныхаа мэдээллүүдийг цуглуулж гаргасан байна.

Монгол бөхөн /Saiga borealis/

Тархац: Монгол бөхөнгийн тоо толгойн тархцыг 2000 оноос хойш жил бүр судалж байгаа бөгөөд 2000 онд 5000 гаруй толгой (Б. Амгалан, 2000) байсан бөхөн 2004 онд 700 гаруй /Б.Амгалан, 2004/ болтлоо цөөрсөн гэсэн судалгааны дүгнэлт гарсан бөгөөд Байгалийн цогцолборт газрын нутаг болох Дөргөний хүрэн тал, Манханы хэсэгт цөөн тооны бөхөн амьдардаг.

Монгол бөхөн Хар ус нуураас урагш Монгол Алтайн уулсын бэлээр тархсан популяци юм. Одоогийн байдлаар Дөргөний хүрэн тал, Шарга Хүйсийн говьд, Хар ус нуурын баруун эрэг орчмын нутаг Манхан сумын Өөшийн хөдөө хэмээх хэсэгхэн нутагт цөөн тоогоор тархан амьдарч байгаа бөгөөд тоо толгой нь цөөрсөөр байна. Өөшийн хөдөөд 44+-8 толгой бөхөн тоологдсон /Шар 1998/. Үүнээс хойш эдгээр бөхөнгийн тоо толгой цөөрсөөр байгаа бөгөөд 2003 онд 20 гаруй бөхөн байна гэсэн аман мэдээ байдаг. Байгаль цаг уурын таагүй нөхцөлийг бэлчээрийн зохисгүй ашиглалт улам бүр ширүүн болгож популяцийн тоо толгой нь 2001-2002 онд 750 болтлоо буурсан байна (Л.Амгалан 2002). 2005 оны байдлаар Шаргын говь, Хүйсийн говь, Дөргөний талд нийтдээ 1500 толгой бөхөн үлджээ (Л.Амгалан, Б.Чимэддорж 2005). Манханы популяци нь 1982 онд 130 гаруй бөхөнтэй байснаа 1983-1984 оны зуднаар 30 хүрэхгүй тоотой болж, 1993 онд 70 гаруй, 1998 онд 50 толгой орчим болсон байна (С.Бадрах 1993, С.Шар 1998). 2005 оны судалгаагаар 15 орчим бодгаль үлдсэн байна (Л.Амгалан, Б.Чимэддорж 2005).

Сүүлийн жилүүдэд Хүйсийн говиос баруун хойд зүг Таван хайрханы тал, Дөргөний тал, Хомын хоолой, Хар нуурын баруунаар Хомын хоолой хүртэл тархах болсон. Харин зүүн

зүг Олон булаг, Халиун, Бигэрийн хоолойгоор Улаан шалын хоолойруу шилжилт нүүдэл хийхэд гол саад нь Халиун, Бигэр сумын төв болж байна. Байгалийн онцгой нөхцөлд 2002 оны зудтай өвөл Чандмань сумын хойд хөндий Улаан шалын хоолойд цөөн бөхөн гүйдлээр очсон боловч байршин нутаглаж чадаагүй байна.

Бөхөнгийн янзаганд учрах аюул занал: Бөхөн шинээр төрсөн янзгаа машин зам дээр хярж хэвтүүлэн явдгийг тэгш талд дээр хурдлан яваа жолооч газрын өнгөнөөс ялгалгүй дайрах тохиолдол элбэг байдаг байна.

Алтайн аргаль /Ovis ammon/

Тархац: Жаргалант хайрхан ууланд 1000 га-д 1-2 нягтшилтай 1999 онд 50-60, 2009 онд 34 толгой аргаль, угалз тоологдсон байна.

Янгир ямаа /Capra sibirica/

Тархац: Жаргалант хайрхан ууланд 2009 оны судалгаагаар нийт 19 сүргийн 169 янгир ямаа, үүнээс 45 буюу 28% тэхь, 81 буюу 49% ямаа, 11 буюу 9% борлон, 23 буюу 14% - ийг ишиг тус тус тоологдсон байна.

Хар сүүлтий /Gazella subgutturosa/

Тархац: Шарга, Манхан, Хар Ус нуур орчмын хар сүүлтий нэн ховордсон нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт авсан нь энэ бүс нутагт өсч үржих нөхцөлийг бүрдүүлсэн.

Зэгсний зэрлэг гахай /Sus scrofa nigripes/

Тархац: Хар-Ус Нуурын зэгсний гахай 1972 онд 200 гаруй толгой байсан бол өвчнөөр хоргодох, цусыг нь ардын эмчилгээнд хэрэглэх зорилгоор хууль бусаар агнах зэргээс шалтгаалж тоо толгой нь цөөрч, 1998 оны тооллогоор Цагаан булан, Далай нуурын өтгөн зэгстэй хэсэгт 50 орчим толгой (С.Шар, 1998) үлдсэн байна. 2013 оны судалгаагаар Хар-ус нуурын БЦГ-т 120 бодгаль тоологдсон байна.

Шувуу: Хар-ус нуурын байгалийн цогцолборт газарт 17 багийн 35 овгийн 270 зүйлийн шувууд бүртгэгдсэний дотор өндөглөдөг 123, өвөлждөг 49, нэн ховор 4, ховордож байгаа 14 зүйл шувуу улаан номонд орсон 19, унаган зүйл 2, дайран өнгөрдөг 20 зүйл байна. Эдгээр шувуудаас 150 гаруй зүйл нь ус намгархаг орчинтой холбоотой шувууд байдаг. Хар-ус нуурын байгалийн цогцолборт газар нь “Олон улсын ус, намгархаг газар, ялангуяа усны шувуу олноор амьдардаг орчныг хамгаалах” Рамсарын конвенцид 1999 онд орсон. Байгалийн цогцолборт газрыг байгуулах үндэслэл боловсруулах судалгааны явцад 202 төрлийн шувуу ажиглагдсанаас Монгол оронд анх удаа тэмдэглэгдэж буй 4 шувуу (*Tachybaptus ruficollis*, *Nycticorax nycticorax*, *Porzana parva*, *Charadrius hiaticula*)-г зэрэг шувуудыг олж илрүүлсэн ба түүнээс хойш гадаад дотоодын олон шувууд судлаачид хэд хэдэн удаагийн судалгааны ажлаар шинэ зүйлүүд нэлээд нэмж тэмдэглэж байсны

улмаас одоогийн байдлаар 270 гаруй зүйл байна гэж үзсэн байна. Ховор, ховордож буй шувуудын дотроос анхаарал татаж буй зүйл нь борцгор хотон, жороо тоодог хоёр юм. Борцгор хотон нь 1950-иад оны үед энд хэдэн зуугаараа өндөглөн зусдаг байсан бол 1995 онд дөнгөж 3 хос өндөглөсөн байв. Ховордох болсон гол шалтгаан нь хотонгийн хушуугаар хусуур хийдэгтэй холбоотой.


Загас: Хар ус нуурын байгалийн цогцолборт газрын нуур, голуудад 3 овгийн 4 зүйл загас тархсан байдаг ба бүгд цэнгэг болон давстай усанд зохицон амьдрах өвөрмөц зохилдлоготой бөгөөд Монгол хадран загас нь эндхийн унаган зүйл юм. ХУНБЦГ-ын Хар Ус, Хар, Дөргөн, Ногоон нуурт агнуурын ач холбогдол бүхий Монгол хадран, Алтайн сугас, гэсэн 2 зүйл байдаг. Алтайн сугас нь Нохой сугас, Шар сугас гэсэн 2 хэлбэрт тохиолдох бөгөөд тэдгээр нь өөр хоорондоо ялгагдах онцлогтой /Доктор Б.Мэндсайхан, 2010 он/.

Хоёр нутагтан ба мөлхөгчид: Хар ус нуурын байгалийн цогцолборт газарт цөлжүү хээр, хээрийн ландшафт зонхилох тул хоёр нутагтан амьтдын зүйл байхгүй ба Хар-ус нуурын хотгор ба түүний орчин тойрны нутгаар хэвлээр явагчдаас цөөн зүйл тархсан байдаг. Монгол орны 20 зүйл мөлхөгч амьтны 4 овгийн 5 зүйл нь энэ нутагт тохиолддог. Эдгээрээс ховор, нэн ховор ангиллын амьтан байхгүй бөгөөд цоохор хонин гүрвэл (*Phrynoscephalus versicolor*), могой гүрвэл (*Eremias multiocellata*), говийн гүрвэл, рашааны могой (*Elaphe dione*), бамбай хоншоорт могой (*Aqkistrodon halys*) элбэг тохиолдоно (Мөнхбаяр 1991, Тэрбиш 1997).

Шавж: Хар-Ус нуурын байгалийн цогцолборт газарт 27 овгийн 70 төрлийн 131 зүйлийн шавж бүртгэгдсэнээс 12 зүйл, 4 салбар зүйл нь монгол орны эндемик зүйлүүд юм. (К.Улыкпан, 2004) Хар-ус нуур орчмын шавжийн судалгаа нь 1986 оноос эхлэн судлагдсан бөгөөд энэ талаар судалгааны мэдээ баримт, хэвлэлийн эх сурвалж нэлээд байгаа боловч сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгаа ховор байдаг.

Тусгай хамгаалалттай газар нутаг

Улсын тусгай хамгаалалттай газар нутаг: Ховд-Чандмань чиглэлийн 62 км авто замын төсөл нь Ховд аймгийн Чандмань, Манхан сумдын нутаг дэвсгэрт хэрэгжинэ. Төсөл хэрэгжих Чандмань сумын нутгийн 60 гаруй хувьд Хар-ус нуурын байгалийн цогцолборт газар, Манхан сумын нутагт Шарга-Манханы байгалийн нөөц газрын Манханы хэсэг оршдог. Замын трасс нь Хар-ус нуурын байгалийн цогцолборт газрын зүүн урдуур дайрч өнгөрч байгаа бол Шарга-Манханы байгалийн нөөц газраас 10 орчим км зайд Замын трассын I, II хувилбарууд эхэлнэ.



Зураг 32. Төсөл хэрэгжих орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутаг

Хүснэгт 85.

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээлэл

| № | ТХГН-ийн нэр, ангилал | Хамгаалал танд авсан огноо | Хамгаалалтанд авсан тогтоол, шийдвэр | Засаг захиргааны хуваарь |
|--------------------------------------|--|----------------------------|--------------------------------------|--|
| 1 | Хар-ус нуурын Байгалийн цогцолборт газар | 1997-06-13 | УИХ-ын 1997 оны 47-р тогтоол | Ховд аймгийн Мянгад, Дөргөн, Чандмань, Манхан, Буянт сумдын нутгийг хамарна. |
| Хамгаалалтанд авсан үндэслэл: | | | | |

| | | | | |
|---|--|------------|-------------------------------------|--|
| | Ус, намгийн шувуудын амьдрах орчныг бүрдүүлэх, нууруудын эргэн тойрны зэгс, шагшуургыг хамгаалах, ерөөсөө Төв Азийн ус, намгийн хамгийн том төлөөлөгч, экологийн өвөрмөц орчныг хамгаалах зорилготой. | | | |
| 2 | Шарга-Манханы Байгалийн нөөц газар | 1993-11-12 | 1993 оны УИХ- ын 83-р тогтоол | Ховд аймгийн Буянт, Манхан сумын нутагт орших Манханы хэсэг, Говь Алтай аймгийн Тонхил, Дарви, Төгрөг, Халиун сумдыг Шаргын хэсэг гэсэн хоорондоо 200-аад км зайтай 2 хэсгээс тогтоно. |
| | <p align="center">Хамгаалалтанд авсан үндэслэл:</p> <p>Дэлхий дээр байгаа 2 зүйл бөхөнгийн нэг болох монгол бөхөнгийн сүүлчийн голомт нутаг. Бөхөнг хамгаалж өсгөн үржүүлэх зорилгоор 1993 онд УИХ-ын 83 дугаар тогтоолоор байгалийн нөөц газар болгон тусгай хамгаалалтад авсан байна.</p> | | | |

Төсөл хэрэгжих талбай нь Байгалийн цогцолборт газрын тодорхой хэсгийг дайрч байгаа тул Монгол улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэмийг мөрдөж үйл ажиллагаа явуулах шаардлагатай.


Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг: Төсөл хэрэгжих талбайд аймгийн тусгай хамгаалалттай газар нутаг байхгүй бөгөөд Чандмань, Манхан сумын ИНХ-ын тогтоол, шийдвэрийн дагуу дараах газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан байна. Замын трассын I, II хувилбарууд нь Манхан сумын нутаг дахь Тооройн ОНТХГН, Чандмань сумын нутаг дахь Бүдүүний ОНТХГН-ийг дайран өнгөрч байна.

Хүснэгт 86.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг

| № | ОНТХГН-ийн нэр | Тогтоол, шийдвэр | ТХ-д авсан огноо, ТХ-аас гарах огноо | Хамгаалалтанд авсан үндэслэл/ зориулалт | Талбайн хэмжээ, мян.га |
|---------------------------|--------------------|-----------------------------|--------------------------------------|---|------------------------|
| Ховд аймаг - Чандмань сум | | | | | |
| 1 | Бумбат хайрхан уул | Сумын ИТХ-ын 5/02-р тогтоол | 2014.04.24 - 2019.04.24 | Бусад | 39.9 |


| | | | | | |
|-------------------------|-----------------------|-----------------------------|-------------------------|---|-------|
| 2 | Чандмань хүрэн тал | Сумын ИТХ-ын 5/03-р тогтоол | 2014.04.24 - 2019.04.24 | Отрын бэлчээр нутаг, ургамал ан амьтанг хамгаалах нэн ховор амьтан бөхөнгийн нөөц нутгаар тооцож орон нутгийг хамгаалах | 109.8 |
| 3 | Бүдүүн | - | 2013.01.07 | Байгаль, түүхийн дурсгалт газар | 9.6 |
| 4 | Цагаан хад | - | 2013.01.07 | Байгаль, түүхийн дурсгалт газар | 10.4 |
| Ховд аймаг - Манхан сум | | | | | |
| 1 | Гоогийн нуруу | Сумын ИТХ-ын 8/6-р тогтоол | 2015.07.17 - 2030.07.17 | Ой, амьтан, ургамал, усны нөөц газар | 7.1 |
| 2 | Хөөгийн нуруу | | | Бусад | 5.2 |
| 3 | Гурван цэнхэрийн агуй | | | Бусад | 15.0 |
| 4 | Мөөнөг | | | Бусад | 4.2 |
| 5 | Тоорой | | | Бусад | 4.3 |



Зураг 33. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг

11.2. Түүх соёлын дурсгалт зүйлсийн судалгаа, хамгаалах арга зам

Ховд-Чандмань чиглэлийн авто замын трассын дагуу археологийн дурсгалын судалгаа одоогоор хийгдээгүй бөгөөд инженер-геологийн судалгааны ажлын үеэр замын трассын дагуу 2 хиргисүүр бүртгэгдсэн байна. Хиргисүүр 1 нь авто замын трассаас 200м, хиргисүүр 2 нь 350 м зайтай оршиж байна.



Зураг 34. Замын трассын дагуух хиргисүүрүүдийн байршил



Зураг 35. Шар булгийн орчмын хиргисүүр (Хиргисүүр 1)



Зураг 36.

Замын трассын хувилбарууд салах уулзвар орчмын хиргисүүр (Хиргисүүр 2)

Инженер-геологийн судалгааны ажлын үеэр илэрсэн тус 2 хиргисүүр нь хатуу хучилттай авто замын трассаас ... метрээс .. метрийнзайд оршиж байгаа бөгөөд авто зам тавих үед хийгдэх газар шорооны ажлын явцад сүйдэх эрсдэлтэй.

Иймээс судалгааны ажлын үеэр бүртгэгдсэн хиргисүүрүүдийг Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар бүлэг болон “Монгол улсын нутаг дэвсгэр дээр археологи, палеонтологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам”-ын 2.4, 2.5 дугаар заалтуудыг үндэслэн түүх-археологийн дурсгалын хамгаалалтанд анхаарч, хатуу хучилттай автозамын барилга байгууламжийн ажлын үед хөрс хуулалт болон бусад үйл ажиллагаа явуулах тохиолдолд нөлөөллийн бүсэд орж байгаа бол эдгээр дурсгалуудыг малтан судалж талбайг чөлөөлүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Мөн түүнчлэн газрын хөрсөн доор булагдсан дурсгал байхыг үгүйсгэхгүй тул зам барилгын болон бусад ажлын явцад анхаарал болгоомжтой ажиллаж, ямар нэгэн

дурсгал, олдвор илэрсэн тохиолдолд нэн даруй мэргэжлийн байгууллагад мэдэгдэх нь зүйтэй.

Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38-р зүйлд соёлын өвийг хамгаалахтай холбоотой хориглох үйл ажиллагааг заасан бөгөөд тус хуулийн 38.1.2-т палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэхгүйгээр хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, тариалангийн талбай олгох, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулж газар олгохыг хориглосон байна. Иймд авто зам тавих ажлын өмнө авто замын трассын дагуу археологи, палеонтологийн судалгааг нарийвчлан хийж, цаашдын үнэлгээгээр авто замаас үүсэх нөлөөллийг нарийвчлан тодорхойлж, сөрөг нөлөөлөл байгаа бол бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Монгол улсын Засгийн газрын “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт батлах тухай” 2008 оны 175 дугаар тогтоолын дагуу тус жагсаалтад Ховд аймгийн нутаг дэвсгэр дэхь дараах түүх соёлын дурсгалууд орсон байна. Үүнд:

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Манхан сумын Тахилтын хотгор гэдэг газар орших Хүннүгийн язгууртны булш
2. Манхан сумын Хойдцэнхэрийн-Өл гэдэг газар орших Гурванцэнхэрийн агуйн хадны зураг
3. Манхан сумын Ишгэн толгойн хадны зураг
4. Мөнххайрхан сумын Долооннуурын Улаан толгойд орших эртний бичээс
5. Мөст сумын Бодончийн гол, Баянзүрх гэдэг газар орших хиргисүүр, буган чулуун хөшөөний цогцолбор, чулуун зэвсгийн үеийн бууц
6. Үенч сумын Ямаан-Ус гэдэг газар орших хадны зураг
7. Ховд сумын Сөрт гэдэг газар орших дүрс, тэмдэг бүхий хөшөө чулуу
8. Цэцэг сумын Халиуны хөтөл гэдэг газар орших хүн чулуун хөшөө
9. Эрдэнэбүрэн сумын Цамбагарав уулын Хар дэлийн бууцны хадны зураг

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Булган сумын Ягшийн хөдөө гэдэг газар орших эртний булшнууд
2. Жаргалант сумын төвд орших Сангийн хэрмийн туурь
3. Мөнххайрхан сумын Улаан говийн аманд орших хүн чулуун хөшөө
4. Мөнххайрхан сумын Шуурхайн хөх нуурын орчимд орших хүн чулуун хөшөө
5. Мөнххайрхан сумын Доод-Улхан гэдэг газар орших хадны зураг
6. Мөнххайрхан сумын Дээд-Улаан говийн аманд орших буган чулуун хөшөө
7. Үенч сумын нутагт орших Харуул-Овоо

8. Ховд сумын Чандмань Хар-Үзүүр гэдэг газар орших хадны зураг

Төслийн талбайд улсын болон аймгийн хамгаалалтанд байх томоохон онцлог түүх соёлын дурсгал байхгүй боловч хээрийн судалгааны ажлаар замын трассын дунд хэсэгт хиргисүүрүүд таарсны дээр Чандмань сумын нутаг дэвсгэрт орших Бүдүүн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг Байгаль, түүхийн дурсгалт газраар тусгай хамгаалалтанд авсан байгаагаас үзвэл замын трассын дагуу түүх соёлын дурсгалыг нарийвчлан илрүүлж, байршлыг тогтоон, цаашдын үнэлгээгээр нөлөөллийг тогтоох нь зүйтэй.

Хамгаалах арга зам

- Замын шороо бэлдэх болон зам барилгын явцад мэдэгдээгүй түүх дурсгалын зүйлс, булш, бунхан хиргисүүр, археологи, палеонтологийн зүйлс илрэх тохиолдолд түүх соёлын үнэт өвийг хамгаалах үүднээс үйл ажиллагааг зогсоож, сумын удирдлага, эрдэм шинжилгээний мэргэжлийн байгууллагад мэдэгдэх, улмаар тухайн газар нутгийг хамгаалалтанд авах зэрэг арга хэмжээ авна.
- Түүхийн дурсгалт газруудыг илрүүлж тогтоохоос гадна орон нутгийн онцгой ач холбогдол бүхий түүхийн дурсгалт газруудын зэрэглэлийг тогтоож, замын дэргэд тухайн дурсгалт газрын талаар самбар, тэмдэгжүүлэлтийг байршуулах.
- Нутгийн ард иргэдтэй тухайн орон нутгийн түүх соёлын дурсгалт газрыг хамгаалах арга хэмжээг хамтран авч хэрэгжүүлэх.
- Байгаль, түүхийн дурсгалт газруудын ойролцоо хамгаалалтын бүсүүдийг тогтоох бөгөөд энэ нь тухайн объектоос 50 метрээс багагүй зайтай байна.
- Түүх соёлын дурсгалуудын тухай, түүнийг хөндөхгүй байх талаарх хууль эрх зүйн орчин, хамгаалах арга хэмжээний тухай өөрийн болон гэрээт компаний ажилчдыг сургалтанд хамруулах, зааварчилгаа өгөх.
- Газрын хэвлий хөндөх үед соёлын өв нөлөөлөлд өртөж болзошгүй. Энэ нь далангийн суурийг хуулж авах, даланд ашиглах шороон ордуудын карьерыг нээж ашиглах явцад хамааралтай. Ийм учраас ажиллагсад соёлын өв, түүнийг хамгаалах талаар зохих мэдээлэлтэй байх нь чухал.

11.3. Төслийн замаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл

Агаар орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл:

Агаарын бохирдол үүсэх үндсэн нөхцөл нь зам барилга байгууламжийн барих ажлын үед гарах тоос, ашиглаж буй машин механизм, техник хэрэгслээс гарах химийн хорт бодис бүхий хий, утаа, тортог болно. Хатуу хучилттай авто зам байгуулах үйл ажиллагааны явцад төслийн талбай руу элс, дайрга, цемент болон бусад орц бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, сэлбэг материалыг тээвэрлэж буй шороон замууд, элс, дайрганы нунтаг тоосонцор, төслийн талбайд ажиллаж буй машин, техникээс үүдэлтэй тоос шороо, түлшний дутуу шаталтаас ялгарах хорт утаа хийнүүд тухайн орчны агаарыг бохирдуулна. Агаарын бохирдол нь зам барилга байгууламжийн талбайд ажиллаж байгаа ажиллагсад, орон нутгийн иргэдийн эрүүл мэндээс гадна ойр орчмын амьтан, ургамал, газар нутагт нөлөөлдөг.

Замын барилга байгууламж барих талбайн гадаргууг тэгшилж бэлтгэх, замд ашиглах элс хайрганы орд нээх, ухаж ашиглах, шороон замаар зөөж тээвэрлэх, овоолго хийх, зам талбайд элс хайрган хучилт хийх, цемент бетоны хольц зуурмаг хийх зэрэг олон төрлийн газар шорооны ажлаас ихээхэн хэмжээний тоос гарах нөхцөл үүсдэг. Мөн зам барилгын ажлын үед бульдозер, экскаватор, ачигч, хүнд даацын тээврийн хэрэгсэл зэрэг хүнд механизмууд ажиллаж түлш шатаан нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), азотын давхар исэл (NO₂), хүхэрлэг хий (SO₂), утаа хөө тортог гэх мэт бохирдуулагчид болон хөрс хуулалт, түр зам ашиглалтаас төслийн талбайн хөрс талхлагдаж тоос агаарт хаягдаж агаар орчин тодорхой хугацаанд бохирдож болзошгүй байна.

Агаар орчны бохирдлын хэмжээ зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давахгүй байх, хамрах хүрээ нь бага байх нөхцөлтэй боловч төсөл хэрэгжих талбай нь Их нууруудын хотгорын хур тунадас бага, хуурай уур амьсгалтай бүсэд хамаарч байгаа бөгөөд цаг агаарын нөхцөл тааламжгүй байх, уур амьсгалын үзүүлэлтүүдийн өөрчлөлттэй давхардах зэрэг тохиолдолд зам барилгын үйл ажиллагааны улмаас үүсэх тоосжилтын хэмжээ харьцангуй өндөр байх магадлалтай.

Хатуу хучилттай зам барьснаар өмнөх олон салаа шороон зам болон хучилтгүй замаас үүсдэг тоосжилт багасах боловч зам барилгын ажлын үед бүтээн байгуулалт, газар шорооны ажил, тээвэрлэлтээс үүсэх тоосжилтыг бууруулах арга хэмжээг төлөвлөн авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй нөлөөлөл:

Авто замыг барьж байгуулах үед их талбайг хамарсан газар шорооны ажил хийгдэх учир хөрс эвдрэх, элэгдэх нөлөөлөл үүсэх бөгөөд уг ажлыг бага талбайд явуулж, чанартай гүйцэтгэх хэрэгтэй. Төслийн хувьд замын трассын хувилбарууд нь хуучин ашиглагдаж байсан шороон замыг нэлээд хамрах тул шинээр зам доор орж эвдрэх талбай харьцангуй багасч орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихээхэн буурна.

Хөрсний өнгөн үеийн шимт давхаргад ургамал ургаж шимт тэжээлээ авах, хөрсний үржил шимийг тэтгэдэг олон зүйлийн бичил биетэн амьдрах, олон мэрэгчид үүрлэх, хорхой шавжийн амьдрах орчин болдог тул шимт давхаргыг элэгдэл эвдрэлд оруулж устгах нь шууд болон дам байдлаар байгаль орчинд ихээхэн сөрөг нөлөө үзүүлнэ. Иймээс хөрсийг бага хөндөх, элэгдэл эвдрэлд бага оруулах, хөндсөн газрын хөрсний шимт давхаргыг тусгайлан хуулж авч нөхөн сэргээлтэд хадгалах, түүнийг эвдэрсэн газрын нөхөн сэргээлтэд ашиглах зэрэг нь хөрстэй харьцаж байгаа үйл ажиллагааны технологийн процесстой салшгүй холбон үзэх шаардлагатай.

Усан орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл:

Зам барих технологи ажиллагаанд ихээхэн хэмжээний ус ашиглах бөгөөд усны эх үүсвэр, түүний нөөц хэмжээг авч үзэх шаардлагатай. Ховд-Чандмань чиглэлийн 62 км авто зам барих төслийн технологийн хэрэгцээний усыг ойролцоох гадаргын урсцаас хангахаар төлөвлөсөн байна. Иймд усны эх үүсвэрийн нөөц, горимд сөрөг нөлөө үүсэхгүй байх, ажил эхлэхийн өмнө хатуу хучилттай авто замын барилга байгууламжид хэрэглэх усны хэрэглээний хэмжээг нарийвчлан тооцож, эх үүсвэрийг тодорхойлох, харьяалагдах орон нутгийн захиргааны саналыг авч, хууль журмын дагуу холбогдох төлбөрийг төлөх шаардлагатай.

Авто замын барилга байгууламжийг барих үед усны бохирдол үүсэх нөхцөл нь зам барих газраас үерийн урсац нам дор газрууд руу чиглэн зам барилгын ажлын талбайгаас хөндөгдсөн сул хөрс шороо зөөгдөж булингар, бохирдол үүсэх, мөн ашиглаж буй тээврийн хэрэгслээс алдагдах шатах тослох материал, ил задгай хог хаягдал гадаргын урсцаар зөөгдөн тархах нөхцөлтэй. Ахуйн хатуу, шингэн хаягдлаас гүний усанд бохирдол үүсэх нөлөөлөл нь хүний үйл ажиллагаанаас шууд хамааралтай.

Зам барилгын ажил, далан байгуулах, орчны тоосжилтыг бууруулах зэрэгт газрын гүний ус ашигласнаар тухайн орчмын бага гүнд орших усны түвшин тодорхой хугацаанд доошилж хэмжээ, нөөц багасаж болзошгүй. Газрын гүнээс усыг хяналтгүйгээр авч

ашиглах, бохирдсон усыг ил задгай гадаргууд замбараагүй асгах нь гадаргын болон газрын доорх усны чанарт сөргөөр нөлөөлнө.

Ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй нөлөөлөл:

Төслийн хувьд замын трассын хувилбарууд нь хуучин ашиглагдаж байсан шороон замыг нэлээд хамрах тул шинээр тавих замын нөлөөллөөр шууд талхлагдалд орж устах ургамлын нөмрөгийн бүрхэвч харьцангуй багасч орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихээхэн буурна.

Зам ангийн түр суурин бий болсноор тухайн орчимд хүн, машин техник холхиж, ойр орчмын ургамлан нөмрөг ихээр талхлагдах бөгөөд замын ажлыг гүйцэтгэх явцад машин техник, хүний үйл ажиллагаагаар ойр орчим талхлагдаж, ургамлын зүйлийн бүрдэл цөөрч болзошгүй. Замд ашиглагдах хайрга, элс шорооны овоолго, түр зуурын хуримтлал үүсгэсэн тохиолдолд тухайн орчны ургамлан нөмрөг дарагдаж талхлагдана. Ургамлан нөмрөг хамгаалах арга хэмжээ нь хөрсөн бүрхэвчийг хамгаалж, нөхөн сэргээж байгаа арга хэмжээтэй салшгүй холбоотой.

Амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл:

Замын ажлын үед эвдэрсэн газар нь амьдрах орчны доройтлыг бий болгох, зэрлэг амьтдын идэш тэжээлийн хүртээмжит байдал алдагдахад нөлөөлж болзошгүй. Тээврийн хэрэгслийн байнгын шилжилт хөдөлгөөн, дуу чимээ нэмэгдсэнээр ан амьтан дайжих, байршил тархалт нь өөрчлөгдөн амьдрах орон зай нь хумигдах нөлөөлөлтэй боловч төслийн хувьд замын трассын хувилбарууд нь хуучин ашиглагдаж байсан шороон замыг нэлээд хамрах тул тус нөлөөллийн эрчим дунд зэрэг байх төлөвтэй. Зам тавих талбай түүний орчмын мөлхөгч, мэрэгч, шавжийн суурьших газар устаж болзошгүй. Авто зам барих үед карьер үүсгэх, түр жижиг овоолго үүсгэх, нүх ухах, салаа замууд гаргах зэрэг хотос хонхор тогтсон газруудад тогтоол ус үүсч, элдэвшавьж өсөж үржиж бохирдлын эх үүсвэр бий болж болзошгүй бөгөөд элдэв нүхэнд хөхтөн амьтад, мал унаж бэртэж болзошгүй.

Авто зам тавигдсанаар тухайн замаар зорчих хөдөлгөөн ихсэж хууль бус ан агнуур ихсэх аюултай. Иймд орон нутгийн иргэд, холбогдох байгууллагатай хамтран ажиллах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь зүйтэй.

Авто замаар машин техник явах үед амьтад замаар гарах тохиолдолд дайруулж осолдох эрсдэл үүсч болзошгүй тул ан амьтдын нүүдлийн замд саад болохгүй байхад анхаарч стандартын дагуу тухай зэрлэг амьтан болон мал нэвтрэх гарцыг байгуулах шаардлагатай. Хатуу хучилттай замыг төлөвлөхдөө энэ бүс нутгийн ан амьтдын нүүдлийн

замд саад болохгүй байхад анхаарах, тухайлбал зам болон бусад байгууламжуудад далан барихдаа бөхөн, хар сүүлтий зээрийн нүүдэл дайран гарч болзошгүй хэсгүүдэд чөлөөтэй нэвтрэх гарц, гарам байгуулах мөн ашиглалтын явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь амьтдын нүүдэл шилжилтэд ноцтой саад болж байгаа эсэхэд хяналт тавих нь зүйтэй.


Төлөвлөж буй замын трассын орчим дахь Монгол орны Улаан номонд орсон зэрлэг амьтдын байршил нутгийг хуваагдал, хумигдалд оруулж байгаа эсэх талаар амьтны аймгийн болон нийгмийн судалгааны үр дүн, замын трассын дагуу болон түүний зэргэлдээх амьдрах орчин, туруутан амьтдын зүйлийн бүрдэл, тоо толгой, шилжилт хөдөлгөөн, мөн авто замын ачаалал, гэрийн малын байршил зэргийг үндэслэн үндэслэн цаашдын үнэлгээгээр нарийвчлан тогтоож, шаардлагатай газруудад холбогдох /MNS 6515:2015. *Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага*/ стандартын дагуу тухай зэрлэг амьтан болон мал нэвтрэх гарцыг байгуулах шаардлагатай.

Ашигласан материал

1. Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл. АЗУАГН 2.01.01-2004. УБ. 2004 он.
2. Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016, УБ хот, 2016 он.
3. Уян хучилтын тооцооны аргачлал ...
4. “Авто зам гүүрийн арчлалт засварын ажлын зардлын суурь норм” ЗЗБД 84-021-2016
5. Handbook of Highway engineering, T.F.Fwa, 2009

Хавсралт 1.


Орон нутгийн захиргаа, иргэдтэй санан солилцсон, мэдээл авсан баримт, албан тоот.



**ХОВД АЙМАГ
УС ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**
84140 Ховд, Ховд аймаг, Утас/факс 7043-2307
2017.08.28 № 219
танай 2017.08.25 ны № 112001 -т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Ш.БАТСҮХ ТАНАА

Тус газраас Ховд аймгийн Жаргалант, Манхан, Чандмань сумуудын сүүлийн 10 жилийн цаг агаарын мэдээг ирүүлсэн албан бичгийн дагуу гаргаж, хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 7 хуудастай.

ДАРГА  А.ЭНХЗАЯА



С. Ариунтөг - 2
Манхан
Ховд аймгийн
Засаг дарга
2017/29

Ховд аймгийн
Засаг дарга
2017/29

Тр661/45-2017

МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

84140 Ховд, Ховд аймаг,
Утас: 70433601, Факс: 70432022,
E-mail: Khovd.govern@yahoo.com

2012.09.15 № 112136

танай _____-ны № _____-т

“ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК-НИЙ
ЗАХИРАЛ У ЖАН ТЭГ ТАНАА

Танай компани Ховд аймгийн Жаргалант суманд хийгдэх 10 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл, Ховд-Чандмань чиглэлийн 62 км авто замын Техник эдийн засгийн үндэслийн судалгааны ажлыг гүйцэтгэхээр тендэрт шалгаран ажиллаж байгаа билээ.

Манай аймгийн “Хотын ерөнхий төлөвлөгөө”-ний дагуу төлөвлөгдсөн хэсэгчилсэн 10 км авто замын трассыг, мөн Ховд-Чандмань чиглэлийн авто замд төлөвлөсөн трассын хувилбар 2-ыг дэмжиж байгаагаа үүгээр мэдэгдэж байна.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  Ш.БАТСҮХ



2012.09.15

Хавсралт 2. Трассын 1-р хувилбар



Хавсралт 3. Трассын 2-р хувилбар



Хавсралт 4. Трассын 3-р хувилбар



Хавсралт 5. Уур амьсгалын мэдээлэл

| Агаарын дундаж температур, °C | | | | | | | | | | | | |
|-------------------------------|-------|-------|------|-----|------|------|------|------|------|-----|-------|-------|
| он/сар | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII |
| 1. Манхан | | | | | | | | | | | | |
| 2007 | -22.5 | -13.0 | -4.1 | 7.3 | 15.1 | 20.1 | 23.1 | 19.3 | 13.5 | 1.9 | -7.4 | -19.7 |
| 2008 | -27.1 | -22.9 | -1.2 | 7.0 | 14.6 | 19.8 | 21.0 | 20.0 | 13.0 | 4.6 | -6.3 | -19.3 |
| 2009 | -24.9 | -14.1 | -2.6 | 9.3 | 14.2 | 18.0 | 20.4 | 17.9 | 11.5 | 4.9 | -13.3 | -22.1 |
| 2010 | -23.9 | -23.7 | -8.0 | 2.0 | 12.1 | 19.9 | 21.4 | 17.1 | 12.3 | 3.8 | -3.3 | -13.7 |
| 2011 | -30.7 | -21.3 | -9.1 | 8.2 | 12.2 | 19.3 | 20.3 | 19.9 | 10.9 | 4.7 | -7.6 | -20.2 |
| 2012 | -28.2 | -23.1 | -6.9 | 6.7 | 13.5 | 20.8 | 21.1 | 18.1 | 13.2 | 2.7 | -8.7 | -19.0 |
| 2013 | -20.7 | -18.0 | 2.9 | 7.6 | 13.1 | 17.9 | 20.3 | 19.2 | 11.8 | 4.0 | -7.9 | -19.9 |
| 2014 | -19.8 | -23.3 | -5.5 | 7.9 | 12.2 | 18.3 | 21.5 | 18.9 | 12.0 | 7.3 | -7.4 | -21.1 |
| 2015 | -16.2 | -13.9 | -3.1 | 7.9 | 13.9 | 17.3 | 22.4 | 19.9 | 11.2 | 4.1 | -6.2 | -15.5 |
| 2016 | -26.7 | -25.0 | -3.9 | 8.3 | 11.0 | 19.8 | 22.0 | 18.6 | 14.4 | 2.1 | -7.3 | -12.4 |
| 2. Ховд | | | | | | | | | | | | |
| 2007 | -22.0 | -12.8 | -4.6 | 6.9 | 14.5 | 19.5 | 22.5 | 18.9 | 12.9 | 1.1 | -8.0 | -19.7 |
| 2008 | -26.8 | -21.9 | -1.6 | 6.4 | 14.0 | 19.0 | 20.6 | 19.3 | 12.1 | 3.9 | -6.5 | -18.0 |
| 2009 | -24.2 | -14.9 | -3.2 | 8.6 | 13.6 | 17.2 | 19.9 | 17.6 | 11.0 | 4.4 | -13.9 | -22.8 |
| 2010 | -25.0 | -24.3 | -8.9 | 1.3 | 11.4 | 19.1 | 20.9 | 16.5 | 11.7 | 3.0 | -5.1 | -15.0 |
| 2011 | -30.9 | -19.9 | -9.1 | 7.7 | 11.4 | 18.8 | 19.5 | 19.3 | 10.2 | 3.8 | -8.1 | -20.7 |
| 2012 | -28.3 | -23.4 | -7.1 | 6.3 | 12.7 | 20.5 | 20.8 | 17.5 | 12.4 | 2.4 | -8.1 | -18.6 |
| 2013 | -20.2 | -16.2 | 2.2 | 7.0 | 12.2 | 17.2 | 20.0 | 18.6 | 11.2 | 3.3 | -9.6 | -19.8 |
| 2014 | -20.4 | -21.5 | -4.6 | 7.4 | 11.5 | 17.7 | 20.8 | 18.4 | 10.9 | 5.9 | -8.1 | -19.4 |
| 2015 | -15.9 | -13.6 | -4.3 | 7.2 | 13.1 | 17.3 | 22.1 | 19.8 | 10.5 | 3.6 | -7.6 | -14.7 |
| 2016 | -25.1 | -22.7 | -3.0 | 7.8 | 10.4 | 18.9 | 21.7 | 18.3 | 13.9 | 1.0 | -7.9 | -12.9 |
| 3. Чандмань | | | | | | | | | | | | |
| 2007 | -18.3 | -8.8 | -5.0 | 5.5 | 12.8 | 17.7 | 20.9 | 17.5 | 11.8 | 0.2 | -7.2 | -16.1 |
| 2008 | -23.5 | -19.0 | -1.9 | 5.1 | 12.3 | 17.8 | 18.8 | 18.1 | 11.2 | 3.9 | -5.2 | -16.2 |
| 2009 | -21.2 | -14.2 | -4.1 | 7.7 | 12.1 | 15.4 | 18.3 | 16.2 | 10.3 | 3.7 | -12.4 | -18.6 |
| 2010 | -20.8 | -20.8 | -9.1 | 0.2 | 9.9 | 17.7 | 19.4 | 15.3 | 10.7 | 3.0 | -4.0 | -13.6 |
| 2011 | -28.9 | -18.0 | -9.6 | 6.7 | 9.7 | 17.1 | 17.8 | 17.8 | 9.1 | 3.6 | -6.5 | -18.7 |
| 2012 | -25.5 | -21.9 | -7.2 | 4.5 | 11.0 | 18.4 | 19.0 | 16.1 | 11.5 | 1.6 | -8.8 | -17.5 |
| 2013 | -16.5 | -15.7 | 1.8 | 6.0 | 10.9 | 15.5 | 18.1 | 17.1 | 10.1 | 3.1 | -7.7 | -16.3 |
| 2014 | -16.4 | -20.4 | -4.7 | 6.4 | 10.0 | 16.0 | 19.2 | 17.1 | 10.5 | 5.5 | -6.8 | -17.1 |

| | | | | | | | | | | | | |
|------|-------|-------|------|-----|------|------|------|------|------|-----|------|-------|
| 2015 | -13.4 | -12.5 | -4.8 | 6.1 | 11.7 | 15.6 | 20.8 | 18.8 | 9.3 | 3.4 | -6.8 | -11.8 |
| 2016 | -23.6 | -19.6 | -3.9 | 6.5 | 8.9 | 17.6 | 20.4 | 16.8 | 13.1 | 0.2 | -7.3 | -9.9 |

| Агаарын хамгийн бага температур, °C | | | | | | | | | | | | |
|-------------------------------------|-------|-------|-------|-------|-------|------|------|------|-------|-------|-------|-------|
| он/сар | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII |
| Манхан | | | | | | | | | | | | |
| 2001 | -32.0 | -32.1 | -24.0 | -15.7 | -1.5 | 0.9 | 7.3 | 7.4 | -2.0 | -12.8 | -23.9 | -35.6 |
| 2002 | -36.7 | -36.7 | -32.8 | -13.4 | -2.0 | 8.2 | 10.0 | 3.9 | -5.4 | -18.9 | -20.4 | -35.0 |
| 2003 | -34.0 | -35.9 | -23.9 | -17.3 | -3.2 | 7.5 | 8.9 | 4.4 | -4.7 | -15.5 | -21.5 | -30.4 |
| 2004 | -33.0 | -32.0 | -19.7 | -8.3 | -7.4 | 2.9 | 9.5 | 5.1 | -11.5 | -13.7 | -22.4 | -42.7 |
| 2005 | -43.9 | -44.5 | -33.1 | -10.9 | -10.1 | 1.0 | 10.0 | 5.6 | -4.2 | -9.5 | -27.0 | -35.2 |
| 2006 | -35.2 | -25.4 | -23.5 | -12.8 | -4.5 | -1.8 | 8.8 | 4.8 | -1.4 | -10.0 | -22.8 | -26.3 |
| 2007 | -33.1 | -25.8 | -23.2 | -15.5 | -0.8 | 1.8 | 12.1 | 6.3 | -3.2 | -13.8 | -20.0 | -30.7 |
| 2008 | -37.7 | -37.6 | -18.2 | -10.7 | -8.0 | 5.3 | 6.4 | 2.9 | -5.2 | -11.1 | -20.3 | -34.7 |
| 2009 | -36.7 | -27.2 | -22.5 | -6.3 | -2.3 | 3.1 | 9.1 | 3.9 | -4.9 | -10.4 | -27.0 | -31.8 |
| 2010 | -34.1 | -38.2 | -26.8 | -18.4 | -4.6 | 3.0 | 7.7 | 3.3 | -0.2 | -9.7 | -17.4 | -28.3 |
| 2011 | -40.6 | -31.4 | -30.0 | -7.8 | -4.8 | 7.9 | 6.0 | 4.1 | -3.1 | -10.0 | -18.1 | -29.7 |
| 2012 | -37.7 | -35.7 | -24.5 | -11.8 | -3.9 | 7.9 | 11.6 | 5.7 | -2.3 | -15.3 | -23.2 | -32.6 |
| 2013 | -33.8 | -33.7 | -15.6 | -9.8 | -3.3 | 4.6 | 10.1 | 5.8 | -6.2 | -11.0 | -21.1 | -30.9 |
| 2014 | -31.3 | -37.3 | -26.7 | -8.4 | -2.5 | 2.4 | 7.4 | 5.2 | -3.7 | -14.1 | -25.6 | -31.6 |
| 2015 | -29.9 | -29.0 | -22.4 | -11.1 | -2.3 | 1.3 | 7.0 | 6.1 | -4.2 | -13.8 | -20.1 | -29.9 |
| 2016 | -43.7 | -39.5 | -25.4 | -7.7 | -5.3 | 7.2 | 11.9 | 5.4 | -1.9 | -18 | -28.5 | -24.6 |
| Ховд | | | | | | | | | | | | |
| 2007 | -30.6 | -25.2 | -21.4 | -13.9 | -0.1 | 1.8 | 11.6 | 7.1 | -4.4 | -13.2 | -20.3 | -30.9 |
| 2008 | -37.5 | -37.2 | -17.0 | -9.9 | -6.5 | 5.0 | 7.6 | 2.8 | -5.1 | -9.6 | -19.8 | -33.9 |
| 2009 | -35.0 | -27.1 | -23.2 | -4.4 | -2.4 | 3.4 | 8.0 | 5.7 | -3.0 | -9.6 | -27.4 | -32.8 |
| 2010 | -36.9 | -41.0 | -28.2 | -20.6 | -2.1 | 4.4 | 7.5 | 3.7 | -0.8 | -9.9 | -24.7 | -30.0 |
| 2011 | -40.8 | -32.9 | -26.7 | -8.6 | -2.7 | 7.5 | 5.3 | 3.5 | -3.2 | -11.6 | -19.0 | -30.2 |
| 2012 | -37.8 | -35.6 | -24.5 | -9.3 | -2.8 | 9.1 | 10.7 | 4.6 | -2.3 | -15.1 | -23.7 | -30.9 |
| 2013 | -32.7 | -28.8 | -16.5 | -12.7 | -1.4 | 5.7 | 9.0 | 5.2 | -5.5 | -10.4 | -25.0 | -30.5 |
| 2014 | -31.3 | -34.7 | -22.0 | -7.6 | -1.4 | 2.3 | 6.6 | 5.8 | -4.1 | -14.1 | -26.1 | -29.7 |
| 2015 | -28.6 | -28.5 | -25.0 | -10.6 | -2.1 | 2.4 | 6.4 | 5.6 | -5.4 | -13.2 | -22.0 | -25.6 |
| 2016 | -39.7 | -36.6 | -21.2 | -6.4 | -4.3 | 8.5 | 11.3 | 4.5 | 0.1 | -21.6 | -27.1 | -23.9 |
| Чандмань | | | | | | | | | | | | |
| 2007 | -28.8 | -19.0 | -20.8 | -14.0 | 0.2 | -0.5 | 9.6 | 7.3 | -4.3 | -14.3 | -16.5 | -26.0 |
| 2008 | -32.5 | -31.6 | -12.7 | -12.2 | -7.1 | 3.4 | 7.9 | 2.6 | -4.9 | -10.1 | -16.1 | -29.2 |

| | | | | | | | | | | | | |
|------|-------|-------|-------|-------|------|-----|------|-----|------|-------|-------|-------|
| 2009 | -30.5 | -26.8 | -20.9 | -4.8 | -0.8 | 1.1 | 7.4 | 3.2 | -4.0 | -9.1 | -23.3 | -29.5 |
| 2010 | -30.6 | -33.5 | -27.4 | -20.8 | -4.2 | 3.8 | 6.2 | 2.4 | -0.8 | -9.7 | -20.3 | -26.6 |
| 2011 | -37.6 | -27.4 | -24.4 | -8.6 | -6.5 | 8.1 | 3.8 | 3.9 | -3.6 | -10.1 | -16.7 | -27.6 |
| 2012 | -33.5 | -32.5 | -22.7 | -10.9 | -4.1 | 8.4 | 10.3 | 2.9 | -2.7 | -11.3 | -20.2 | -29.9 |
